



Урбанек ХХК



МУИС



НШУС

ᠪᠠᠲ ᠬᠠᠨ
ᠰᠢᠨᠵᠢᠯ

**Бат хан
800 жил**



Бат хан - 800 жил

Зохиолч: Ч.Чойсамба

Редактор: Ж.Болдбаатар, Ч.Чойсамба

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

**Эрдэм шинжилгээний бага хурлыг нээж, МУИС-ийн НШУС-ийн захирал, доктор,
профессор Ш.Содномын хэлсэн үг**

Энд хуран цугларсан эрдэмтэн мэргэд ээ!

Монгол хүний эрэлхэг зориг, суу заль, эрдэм ухааны царааг Өрнө дахинаа яруу тод илтгэн харуулж чадсан Чингис хааны ач хүү, Алтан ордны улсыг жинхэнэ ёсоор үндэслэгч Бат ханы мэндэлсний 800 жилийн ой энэ онд тохиож байна.

Бат хан бол Чингис өвгийн гар дээр өсөн торниж, цэргийн эрдэм ухаан, төр засах, ардыг ачлах үйлс төгөлдөр, авьяаслаг зохион байгуулагч, үлэмж нэр хүндтэй монгол төрийн гарамгай зүтгэлтэн байсныг бид түүхээс мэднэ. Бат хан Монголын эзэнт гүрний хаяаг тэлэн өргөжүүлэх, хамгаалан бэхжүүлэх хэрэгт ихээхэн хувь нэмэр оруулж, Монголын цэргийг захирч Европын гүн рүү нэвтэрсэн, суу алдар нь цуурайтсан их жанжин байсан юм. Ийм учраас тэрбээр Монголын аугаа их түүхт хүмүүсийн тоонд зүй ёсоор багтдаг билээ.

МУИС-ийн Түүхийн судалгааны хүрээлэн, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, «Урбанек» ХХКомпаниас хамтран зохион байгуулж байгаа Бат ханы мэндэлсний 800 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал нээснийг мэдэгдье.

Хурлын ажилд амжилт хүсье.

Дэлхий дахины болон Монголын түүхэнд Бат ханы гүйцэтгэсэн үүрэг

МУИС-ийн Түүхийн судалгааны хүрээлэн, академич Жигжидийн Болдбаатар

Дэлхийн талыг эзэгнэсэн их гүрэн байгуулахад үлэмжийн их Чингис хааны үр, ач нарын хүчин зүтгэл, хувь нэмэр асар их юм. Тэд бүхний дотроос цэнхэр Дунайгаас морио услан, «Ромыг эзэлнэ» хэмээн сүрдүүлж байсан монгол угсааны хоёрхон их хүн байсны нэг нь Чингис хааны ахмад хүү Зүчийн хөвгүүн Бат бүлгээ. Энэ онд Бат ханы мэндэлсний 800 жилийн ой тохиож байна.

Тэрбээр Их Монгол улс тулгын чулуугаа тулж, гал голомтоо бадрааснаас хоёрхон жилийн дараа буюу 1208 онд эхээс хүй тасарч, хүмүүн төрх олжээ. Бат бол Чингис хааны голомтон дээр гарсан ууган ач хүү болой. Тэрбээр 19 нас хүртлээ үлэмжийн их хаан өвгийн гар дээр эрхлэн өсч, харвах, намнах, ачлах, бусдыг оройлон дагуулах эрдэмд гаргуун суралцсан байна. Энэ дашрамд тэмдэглэхэд, судлаачдын дотор Зүчийг Чингис хааны төрсөн үр биш, Бөртэ үжинг мэргидэд олзлогдсон үед олдсон хүүхэд хэмээн сэжиглэх, хардах явдал бий. Хаан ор залгамжлах хөвгүүний тухай яриа гарахад Чингис хаан: «Үхэл надаас тойрох мэт үнэхээр түүнийг санасангүй» гээд, «Хөвгүүдийн ах Зүчи мөн. Юу хэлнэ, чи хэл» гэв. Цагадай «Зүчийг үг хэл гээд Зүчийг юунд томилох гэж байна? Энэ мэргидийн орхидост бид захирагдах гэж үү?»[1] гэснээс маргаан үүсч, Зүчитэй барилцан авч хэсэг будилсны эцэст Чингис хаан үгүүлрүүн: «Зүчийг тэгж хэлж яаж болно? Хөвгүүдийн минь ахмад Зүчи биш үү? Хожим тэгж бүү хэлтүгэй» гэж зарлиг буулгажээ. Зүчи Өгэдэйг хаан өргөмжлөхийг санал болгосон байна. Чингис хаан зарлиг болруун: «...Эх дэлхий аугаа бөгөөд ус мөрөн олон бий. Харь улсыг эзлүүлэн тус тус салгая. Өөр өөрийн нутгийг өргөтгөж яваарай. Харин Зүчи, Цагадай та хоёр, хэлсэн үгэндээ хүрч, ардын инээдэм, амьтны тоглоом болохгүй, эв найртай яваарай»[2] хэмээжээ. «Нууц товчоо»-ны энэ мэдээнээс үндэслэж, түүхчид болон уран бүтээлчид Зүчийг Чингис хааны хүүхэд биш үзэх явдал бий. Гэтэл түүхэн сурвалжид Чингис хаан Зүчийг өөрийн хүү биш гэж сэжиглэсэн, гадуурхсан нэг ч баримт тэмдэглэгдэн үлдээгүй бөгөөд Зүчийг ахмад хөвгүүнээ хэмээн үзэж, илүү хүндэтгэлтэй хандаж байсан, Их Монгол улсыг байгуулаад албат иргэдээ хуваахдаа Зүчид удаах Цагадайн нэгэн адил 9 мянган өрх соёрхжээ.

Чингис хаан баруун зүг байлдахаар мордохдоо Зүчи, Цагадай, Өгэдэй гурван хөвгүүнээ дагуулж явсан юм. Зарим хүн Зүчийг урвах гэж байна хэмээн эцэгт нь ховлоход дуудсан ёсоор болзсон хугацаанд Зүчи хүрэлцэн ирээгүйд эргэлзэж баривчлахыг завдаж байтал Зүчи эцгийн дуудсан тэр цагт хүнд өвчтэй байсан ба тэгээд удалгүй өвчнөөр нас барсан үнэн мэдээг сонсоод Чингис хаан хөвгүүнээ хилсээр хардаж байсандаа ихэд гэмшиж, Зүчийг маш их өрөвдөн хайрлаж, уйтгарлан гашуудаж байжээ. Ер нь хүү Батыг нь ууган ач нарынхаа нэг гэж үзэж, шууд өөрийн асрамж, халамжинд авч, онцгой анхааран хүмүүжүүлж байсан бөгөөд эцгийг нь нас барснаас хойш улам илүү сайн байсныг түүхэн баримт нотолно. Зүчи 30-40 насны хооронд хан хорвоогоос хальсан бололтой[3]. Ийм учраас Зүчи, түүний үр сад Алтан урагт мадаггүй зүй ёсоор тооцогдож ирсэн байна.

Их хааны ач нарын дотроос Бат ухаалаг чанар, эрэлхэг зориг, цэргийн эрдэмд гарамгай байдлаараа илүү тодорч, өвөг эцгийн итгэлийг алхам алхмаар олсоор байсан юм. Чингис

хааныг амьд ахуйд Бат хэд хэдэн удаагийн тулалдаанд эрэлхэг зориг, ид хав, эрч хүчээ үзүүлж байжээ.

Авга ах Өгэдэй хааны үед Бат 27 насандаа итгэл даах цэргийн томоохон жанжны зиндаанд хүрсэн учир 1235 оны Их хуралдайгаар Өрнө зүг хийх их аян дайныг удирдах үүргийг хүлээсэн байна. Энэ аян дайнд Чингис хааны Алтан ургийн 13 хан хүү оролцсон юм. Тэд бол Зүчи ханы хөвгүүд Орд, Бат, Бэрх, Шейбан, Тангут, Цагадай ханы хөвгүүд Байдар, Хайду, ач Бүри, Өгэдэй их хааны хөвгүүд Гүюг, Хадан, Тулуй ханы хөвгүүд Мөнх, Бүжэг, Чингис хааны тав дахь хөвгүүн, Хулан хатнаас төрсөн Хүлгэн нар бүлгээ[4]. Түүхэнд ахмад хөвгүүдийн аян дайн гэж нэрлэгдсэн байлдан дагууллаар Кибчагийн тал нутаг, Оросыг эзэлж, Дорнод Европ хүрч, Монголын эзэнт гүрний хаяаг тэлжээ.

Бат ханы аян дайныг Ж.Ж.Саундерс: «Дорнод Европын ихэнх хэсгийг хамарсан тэрхүү аян дайны газар зүйн өргөн хүрээ, цэргийн тэр олон анги нэгтгэлүүдийг хооронд нь зохицуулан зохион байгуулж байсан ур чадвар, дайсныг цагийн хатуу болзоонд яг бүслэн цохиж, устгаж, мөрдөн хөөж байсан, мөн түүнчлэн хангамж нийлүүлэлтийн хүнд асуудлыг шийдвэрлэж байсан арга ухаан, Европын огт мэдэхгүй газар нутагт Азийн армийн аян дайны ялалтыг зохион байгуулж, амжилтад хүргэж байсан нарийн ухаан — энэ бүгдийг судлан үзэхэд Монголын удирдагчид дэлхий ертөнцөд урьд нь ховорхон тааралдсан, цаашдаа ч ховор тааралдах тийм дайны урлагийн мастерууд байжээ гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй хүн байхгүй биз ээ»[5] хэмээн үнэлжээ. Харин Бат хан Европ руу хийсэн аян дайнаа ямар учраас зогсоосон тухайд Өрнө, Дорнын олон судлаач янз бүрээр санал бодлоо илэрхийлсэн байдаг. Энэ асуудалд дан ганц талаас нь хариулт өгөх боломжгүй бөгөөд систем хандлагын үүднээс цогц хандах шаардлагатай юм. Миний бодлоор бол Бат хан цэргээ ухраах тушаал өгсөн нь:

1. Их хаан Өгэдэй таалал төгссөнөөс болсон. Монголчууд хэзээнээс хаанаа тэнгэрээс гаралтай гэж үзэж, «төр бол хаан», «хаан бол төр» гэсэн төр шүтэх үзэл газар авч байсан учир ихэд гашуудан эмгэнэж, их хаандаа хүндэтгэл үзүүлэх үүднээс үй олон хүний аминд хүрсэн дайн байлдааныг үргэлжлүүлэх нь их нүгэл, утгагүй хэрэг гэж үзсэн.

2. Бат хан анхнаасаа Европыг байлдан дагуулах бодолгүй байсан бөгөөд команчуудыг орогнуулаад зогсоогүй, барьж өгөх шаардлагыг хүлээж аваагүй Мажарын ван IV Белаг цээрлүүлэх зорилгоо нэгэнт хэрэгжүүлсэн байв. Бат хан маш хүлээцтэй хандаж, IV Белаг 30 орчим удаа элч, захидал илгээж байсны сүүлчийнхийг би өөрийн шавь Мажарын эрдэмтэн О.Барболатай хамтран орчуулж, тайлбар, сэлтгэй хэвлүүлсэн билээ[6]. Энэ захидалд: «Би, Дээд тэнгэрийн ивээлээр эрхэндээ орогчдыг өргөн тэтгэнэ, харин эсэргүүцэгчдийг дарна. Мажар хаан Таныг гайхаж байна. Би танд 30 удаа элч илгээсэн, яагаад над руу ганц удаа ч болов элч илгээхгүй байна вэ? Таныг баян чинээлэг, их цэрэгтэй, хүчирхэг том гүрнийг ганцаараа захирдгийг би мэднэ. Өөрсдөө сайн дураараа бусдын эрхшээлд орох хэцүү, харин Таны тухайд энэ удаа сайнаар эргэнэ. Та “Күн” боолоо (команчууд буюу кибчагууд — Ж.Б.) хамгаалж байгааг би мэдсэн. Та хамгаалах хэрэггүй, тэдний төлөө надтай бүү харгалд. Тэдний зугтах нь Танаас амархан, суурин байшин байхгүй учраас гэрээ ачаалаад хаашаа ч хамаагүй нүүдэллэж одно. Харин Та барилга байшинд амьдардаг, суурин байдалтай, цайз хотод суугаа учир яаж миний гараас гарч, хаашаа хэрхэн зугтах билээ» хэмээн асуусан байдаг. Чингэхлээр Бат хан юу юугүй Европ руу халдан довтлох бодолгүй, арга буюу Мажарын IV

Белад цохилт өгч, энэ явцдаа Европын гүн рүү орсон нь харагдаж байна. Нөгөө талаар Төв болон Зүүн Европын орнуудын ядуу тарчиг байдал Бат ханы цаашид давших сонирхлыг бууруулсан байх.

3. Өгэдэй хааны хүү Гүюг, Цагадайн ач Бүри нар үл ялих шалтгаанаар Бат хантай тэрсэлдэж зөрчилдсөн нь Европт хийж буй байлдааныг зогсооход нэгэн шалтаг болсон. Бат хан энэ тухай Өгэдэй их хаанд: «Бид харь элэгтэй, дайсагнасан улсын дотор явж байгаа учир»[7] түнжин хагарахгүй байх нь юу юунаас чухал гэж бичсэнийг их хаан анхааралдаа авч, Гүюг, Бүри нарт хатуухан сануулга өгч, хэрхэн шийтгэх эрхийг Бат ханд олгожээ. Их хааны зарлигийг Бат хан хүлээж аваад, тэдэнд энэрэнгүй хандсан билээ. Энэ бүхнээс үзэхэд Өгэдэй хаан, Бат хан асуудлыг хувийн эрх ашгийн үүднээс бус, нийт үндэсний үйл хэргийн үүднээс давхар бодож, даамай сэтгэж хандаж байсан нь харагддаг.

4. Олон жил үргэлжилсэн дайн байлдаанаас цэргүүд нь залхаж, ядарч, гэр орноо санаж байсныг Бат хан харгалзан үзэхээс аргагүй болсон. Угаасаа эхэлсэн зүйл төгсдөг нь жам ёсон бүлгээ.

5. Бат хан өөрийн нь эсрэг Европын бүх хүчин Ромын папыг тойрон нэгдэж болохыг үгүйсгээгүй, энэ асуудалд ихэд болгоомжтой нухацтай хандсан зэргийг дурдаж болох юм. Ийнхүү Бат хан Европ руу довтлон амжилт олсноор нэг сая монгол хүн өөр аль ч үндэстний хийж чадаагүйг гүйцэлдүүлж, өөрсдөөсөө 150 дахин олон хүн амьдран сууж байсан асар уудам газар нутгийг зуу хүрэхгүй жилийн дотор байлдан дагуулж, эрхшээлдээ оруулж чаджээ[8].

Зүүн болон Төв Европт аялан байлдаж буцаж ирсний дараа Бат хан 1242-1243 оны орчим Монголын Алтан ордон хэмээх хүчирхэг улсыг байгуулж, өнө удаан мандан бадрах эх суурийг тавьсан юм. Тэрбээр Эрчис мөрнөөс өрнө зүг Дунай мөрний доод урсгал, өмнө зүг Дербент (Дагестан) болон Арран (Өмнөд Азербайжан), хойт зүгт Ижил мөрний Булгарыг хамарсан өргөн уудам нутагтай улсын эзэн болжээ.

Бат хан улс төрийн хувьд эртний уламжлал ёсоор улсаа гурван гар болгон хувааж, Оросын нутагт шууд бус засаглал тогтоон, хараат түшмэг улс болгож, Оросын вангуудыг өөрөө томилдог болсон байна. Мөн газар нутгаа 10 том тойрогт хуваажээ. Оросын вангуудаас хамгийн түрүүнд (1242-1243 оны заагт) Новгородын Ярослав II Всеволодович Алтан ордонд Оросын вангуудыг тэргүүлэн захирах эрх олж авчээ[9]. Тэрбээр Бат ханы итгэлийг олж, түүний зараалаар Хархоринд очсон боловч, учир битүүлгээр нас барсан байна. Үүний дараа түүний хүү Невийн Александр эцгийнхээ бодлого, санааг өөрчлөөгүйгээр барахгүй, Бат ханд илүү их итгэлийг олсон бүлгээ.

1980-аад оны сүүлч-1990-ээд оны эхээр Невийн Александрыг Бат ханы хуурай хүү, зарим нь бүр татвар эмийн хүү ч байсан байж магадгүй гэж бичиж, ярьж монгол гаралтай, Алтан ургийн хүн гэх нь холгүй байсан. Невийн Александр үйл, хандлагаараа Бат ханд өргөмөл хүүгийн зиндаанд итгэгдэж, тал олсон нь үнэн бодитой бөгөөд харин түүний төрсөн хүү гэдэг нь хэтрүүлж давсалсан яриа болой. Учир нь Бат хан 1208 онд, Невийн Александр 1220 онд төрсөн, 12 насны зөрөөтэй, Бат 27 настай байхдаа Өрнө зүг аян дайн хийх их хэргийг удирдах үүрэг хүлээсэн билээ. Ингэхлээр Бат ханы төрсөн хүү байх ямар ч боломжгүй юм.

Бат хан Өгэдэй хаанаас хойш Чингис хааны удмынхны дотроос улс төрийн талаар хамгийн нэр нөлөөтэй байсан бөгөөд хан ор суулгахад их зонхи нь түүний амыг харж байсан бүлгээ. Тухайлбал, Бат хан: «... Хан хөвгүүдийн дотроос Мөнх л хаан хүний билэг төгс юм. Тэр Чингис хааны засаг, зарлиг хоёрыг нүдээрээ үзэж, чихээрээ сонссон хүн. Энэ хүн ертөнцийн сайн, мууг үзэж, хамаг хэрэг явдлын ашиг, зовлонг амсан, янз бүрийн оронд олон удаа цэрэг захиран явсан бөгөөд оюун билэг нь олноос хэтийджээ»[10] хэмээсний дагуу 1251 онд Мөнхийг Их Монгол улсын хаан ширээнд өргөмжилсөн билээ.

Бат хан эдийн засгийн хувьд хот сууринг шинээр болон сэргээн байгуулах, худалдаа, эдийн засаг, албан татварын тогтолцоог оновчтой бүрдүүлэх, өртөө байгуулж, зам харилцааны шинэ сүлжээг бий болгох зэрэг цогц бодлого боловсруулан хэрэгжүүлжээ. Тэрбээр юуны өмнө, ижил мөрний цутгалан Ахатуба голын зүүн эрэг дээр Сарай-Бат хотыг байгуулж, нийслэлээ болгосон байна. Ийнхүү шинэ нийслэлтэй болж, бусад худалдааны төв-хотуудыг үүсгэснээр Алтан ордон улс хотуудын орон гэгдэх болжээ. Улмаар Бат хан нийслэлдээ төрийн ордон байгуулсан байна. Билгүүн номч Б.Ринчен «... Хаадын өргөөг “шар ордон” хэмээн нэрлэдэг байсан бөгөөд Ижил мөрөнд байсан Бат Сайн ханы өргөөг мөн Шар ордон гэж байсан учир тэр нэрийг нь Алтан ордон гэж улсын нэр болгож нэрлэх болсон»[11] гэжээ.

Бат хан улсынхаа газар зүйн байрлалыг ашиглан, улсаа Өрнө, Дорныг холбосон худалдааны гол төв болгох бодлого баримталсан байна. Эн түрүүнд худалдаачдыг ивээлдээ авч, хөхиүлэн дэмжих, худалдааны зам маршрутыг сэргээх, шинэчлэн тогтоох, усан замын худалдааг онцгойлон үзэхээр болжээ. Ялангуяа худалдааны замын аюулгүй байдлыг хангаж, худалдаачдад хөнгөлөлт, урамшуулал эдлүүлэн, тэдний нэр хүндийг өргөж чадсанаар олон улсын худалдаа сэргэн хөгжихөд асар их нөлөө үзүүлжээ. Энэ үеийг судалсан Японы эрдэмтэд Ижил мөрөн, Хар далай, Хорезмыг холбосон олон улсын худалдаа Алтан ордон улсын нийслэл Сарай хотод төвлөрч, XIV зууны эхээр дорно зүгийн гар урлал, олон улсын худалдааны метрополис болсныг онцолсон байдаг[12]. Сарай хотын хөгжил цэцэглэлт нь «монголчуудын тогтоосон энх»-ийн хүрээнд багтаж, XIV зууны эхээр Каспийн тэнгисийн эргэн тойрны улстай худалдаа хийж, эдийн засаг нь хөгжсөн бөгөөд Монголын эзэнт гүрний бүтээсэн соёл иргэншлийн нэгэн дүр төрх болсон[13] хэмээн тухай үеийн Алтан ордон улсын дэлхийн болон бүс нутгийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг дүгнэсэн буй.

Бат хан улсаа Монголын эзэнт улсын салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж, байлдан дагуулсан улс орнуудаасаа Их хааны хуульчлан тогтоосон аравны нэг хувийг татварт авах зарчмыг баримталж, хүн амын тооллого явуулан, энэ үндсэн дээр албан татварын нэгдсэн тогтолцоо хэрэгжүүлжээ. Тэрбээр хот, хотод баскак-даргач нарыг томилон суулгасны нэг үндсэн үүрэг нь татвар хураах явдал байв.

Бат хан мэргэжлийн болон гэр зуурын гэсэн түвшинд гар урлалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого явуулж, урчууд арьс шир, үслэг эдлэл боловсруулах, хувцас хэрэглэл хийх, алт, мөнгө, үнэт эрдэнийн чулуугаар гоёл чимэглэл урлах, хөвөн, ноосон нэхмэл эдлэл, торго, бөс бараагаар хувцас оёх, төмөрлөг эдлэлээр дуулга, зэр зэвсэг хийх, зоос цутгах, вааран эдлэл үйлдвэрлэх зэргээр ур ухаанаа сорьж байв.

Бат ханы үеэс Алтан ордон улс өртөөгөөр урьд өмнө хэзээ ч байгаагүй мэдлэг, мэдээллийг Өрнө, Дорнод түгээн дэлгэрүүлсэн юм. Алтан ордон улсаас Хархорин хүртэл хоёр талаасаа

өртөөг угтуулан байгуулсны гавьяа Бат ханд зүй ёсоор оногдоно.

Бат хан оюун санааны хувьд улс үндэстэн бүр өөрийн гэсэн шашин суртлыг чөлөөтэй дэлгэрүүлэх, сэтгэн бодох, шүтэн бишрэх боломж олгож, Өрнө, Дорныг соёл, шинжлэх ухааны түмэн шижмээр холбох хэрэгт гарамгай үүрэг гүйцэтгэсэн юм. Хятадын луужин, сампин, дарь зэрэг зүйл Өрнө дахинд нэвтэрч, Энэтхэг тоо, лалын одон зурхайн арга барил Төв, Зүүн Азид нэвтэрч, Ойрхи Дорнодын бичил уран зураг, нэхмэл хатгамал урлаг, шаазан ваарын урлалд Хятадын нөлөө гүнзгий тусч эхэлжээ. Өрнөдөөс Дорно дахин руу шинжлэх ухааны ололт нэвтэрч, газар зүйн мэдлэг өргөн дэлгэрсэн байна. Бат хан болон Монголын хаад язгууртны энэхүү тууштай бодлого өнөөгийн даяаршлыг эхлүүлсэн ч гэж хэлж болох юм. Ийм учраас европ, араб, перс сурвалжид Бат хан гэхээсээ илүү «Сайн хаан» гэсэн нэрээр мөнхжин үлджээ.

Бат хан хүний хувьд эрдэмтэн судлаач, улс төрийн зүтгэлтэн, жуулчны анхаарлыг хамгийн ихээр татаж, түүхэнд эерэг үнэлгээ давамгайлан үлдээсэн зүтгэлтэн юм. Вильгельм Рубрук: «Энэхүү Бат бол шууд захирагдах эзэн хаанаас бусад татарын (Монголын) бүх ноёд, тайж нараас үлэмжхэн хүчирхэг байв»[14], Жувейни: Бат хариу боддоггүй өгөөмөр, зүйрлэшгүй уужим сэтгэлтэй хүн[15], Арменийн түүхч Гандзакийн Кирикос: «...Хан, тайж, ван, худалдаачин болон хохирон гомдож эх нутгаа алдсан хэн бүхэн Батад очиход тэрбээр шударгаар тунгаан, орон нутаг, ванлигийг буцаан өгч, бичиг, пайз олгож байв. Түүний тушаал зарлигийг хэнбугай ч эсэргүүцэж үл зүрхэлнэ»[16], С.Цолмон: «Бат нь эрч хүчтэй, ухаалаг, хүлээцтэй, найрсаг удирдагч хүний бүхий л шинжийг шингээсэн томоохон зохион байгуулагч байв. Тэрбээр Алтан ургийнхны дотоодын зөрчил төдийгүй, улсынхаа болон хувийн гомдлыг шийдвэрлэхээр очсон олон орны элч төлөөлөгчдийн асуудлыг голчоор нь шийддэг ноён нуруутай, алсын хараатай удирдагч байсан юм»[17], С.Лочин: «Бат ханы ухаалаг, сэргэлэн, зохион байгуулах их авьяастай, ааш зан төлөв, даруу, өвөг эцэг Чингис хааны их засаг хуулийг хатуу чанд даган мөрддөг хүн байв»[18], Д.Цахилгаан: «Бат бол өөрийн алдарт өвөө Чингис хааныг амьд сэрүүнд нь адис авшиг хүртэж, эцэг Зүчийн эзэмшил нутгийг өвлөн захирах зарлиг хүлээсэн гойдын заяат түүхэн бодьгал агаад Өгэдэй, Гүюг, Мөнх гурван их хааны үед Монголын эзэнт гүрний баруун гарын Алтан ордны улсыг эрхшээн захирч явсан цуут хаан бөлгөө»[19] гэжээ.

Дэлхий дахины болон Монголын түүхэнд Бат ханы гүйцэтгэсэн үүргийг хураангуйлан дүгнэвэл:

— Үлэмжийн их Чингис хааны гар дээр өсч, түүний ухааны даац, авьяас билэг, цэргийн жанжны ур чадвар, үлгэр дууриаллаар өсч хүмүүжин, бойжиж торнисон ууган ач нарын нэг;

— Их Монгол улсын 1235 оны их хуралдайгаар Чингис хааны ууган ач нарын дотроос шалгарч, Өрнөдийг байлдан дагуулах амаргүй хэргийг ерөнхийлөн удирдахаар итгэмжлэгдэн зарагдаж, түүртэлгүй хэрэгжүүлсэн цэргийн аугаа их жанжин;

— Мөрдөн тагнах нарийн чадмаг арга, морь, хүн хоёрын ээнэгшин дасаж, зохицсон гоц чанар, морин цэргийн уран хөдөлгөөнт манёвр, түргэвчилсэн давшилтанд сэхээ завдал өгөлгүй цувуулан цохих тактик, цэргийн анги, нэгтгэлүүдийн чанд зохион байгуулалт, дайчдын үл таних газрын байрлалыг зөв баримжаалах, зэр зэвсгээ гойд эзэмших чадвар,

байлдах арга, туршлага, сэтгэлийн хат бүхий Өрнөдийн орнуудынхаас үлэмж давуу армийг бий болгосон цэргийн стратегич, тактикч, цэрэг-дайны урлагийн аугаа их мастер;

— Европ дахинд Монгол хүний ур ухаан, ургуулан бодох чадвар, сэдэн олох сэтгэлгээ, зохион байгуулах авьяасыг илтгэн үзүүлсэн их Чингис хааны сод билэгт үр сад;

— Орчин цагийн улс төр судлалын «улс» хэмээх ухагдахууны болзлыг бүрэн дүүрэн хангахуйц Оросын ванлигуудын нутаг дэвсгэрээр хөллөсөн Монголын Алтан ордон улсыг үндэслэн байгуулсан төрийн гарамгай зүтгэлтэн,

— Нэр хүнд, ухааны цар, хашир туршлагаараа нэгэн үе Алтан ургийнханд хүндлэгдэн хошуучилж, Их Монгол улсын эзэн хааныг сонгон өргөмжлөхөд гол үүрэг гүйцэтгэж байсан нөлөө бүхий төрийн түшээ байжээ.

Бат ханы цадиг намтрыг гүнзгийрүүлэн судлахад анхаарах зарим асуудал

Доктор, профессор Бэсүд-сультчин

Рэгдэлдагвын Цалхаанамсан (Д.Цахилгаан)

Үүх түүхээ үл мэдэх ард түмэн балар ширэнгэнд буй сармагчины сүрэг лугаа адил гэсэн үг байдаг. «Үндсээ үл мэдэх нь адгуус буюу» гэж В.Инжинаш айлджээ. Ардчиллын сайн цаг ирж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, үүх түүхээ судалж, үнэн мөнийг бэдрэн яваа үед XIII зууны монголчуудын содон сонин түүхийн нэгэн хэсэг Бат ханы намтар цадигийг судлан бичих хувь надад тохиосон билээ.

Бат бол өөрийн алдарт өвөө Чингис хааны амьд сэрүүнд нь адис авшиг хүртэж, эцэг Зүчийн эзэмшил нутгийг өвлөн захирах зарлиг хүлээсэн гойдын заяат түүхэн бодьгал аваад Өгэдэй, Гүюг, Мөнх гурван их хааны үед Монголын эзэнт гүрний баруун гарын Алтан ордны улсыг эрхшээн захирч явсан цуут хаан бөлгөө.

Бат ханы амьдрал, үйл ажиллагаа, XIII-XIV зууны Монголын түүхийг цаашид гүнзгийрүүлэн судлахад учир холбогдолтой хэдэн санааг та бүхний мэргэн оюунд толилуулья.

Нэг

Бат хан, түүнийг залгамжлагчид, ер нь Алтан ордны түүх бүхэлдээ нэг талаас Монголын, нөгөө талаас Оросын түүхэнд томоохон байр суурь эзлэх бөгөөд Монгол, Оросын харилцааны эртний үе, хэдэн зууны ээдрээт үйл явдлыг судлах, шинжлэх, дүгнэх, цэгнэхэд барим тавим холбогдож байгаагаараа онцгой үнэтэй юм.

Монголчууд Оросыг эрхшээн захирч байсан үеийн тухай нэрт эрдэмтэн Г.В.Вернадский: «...Оросын бүхий л түүхэнд Монголын үе бол хамгийн их учир холбогдолтой нь юм. Энэ бол Орос орны, ялангуяа Дорнод Оросын улс төр, нийгмийн байгуулалтыг бүхэлд нь хамарсан гүн гүнзгий өөрчлөлтийн үе байлаа»[20] гэж тэмдэглэсэн байна. Үүнийг Батын үйл ажиллагаанд бүрнээ хамаатуулан ойлгож болно.

Л.Гумилёв: «...Тэд (монголчууд) бидний цус, бидний түүх, бидний хэл, бидний ертөнцийг үзэх хандлагад шингэсэн юм», «...Татарууд бидний хувьд харь бус, төрөл ард түмэн» гэж Орос, Монголын түүхэн гүнзгий холбоог тэмдэглэсэн байдаг.

«...Оросууд бид татар, түрэг, монголчуудтай нэгэн адил Чингис хааны үр хөвүүд», Чингисийн удам «...оросууд биднийг Дорноос ирж эрхшээхдээ барууны дөнгөнөөс чөлөөлсөн юм», монголчуудаас өмнөх Орос, монголчууд ирсний дараах Орос хоёр бол «...огт өөр орчин, хоёр өөр чиг санаа, хоёр өөр утга чанар» бөгөөд Европ, Византийн бөглүү хаяа хязгаар байсан Орос орон монголчууд ирсний дараа дэлхийн нэгэн тулгуур төв, хүчирхэг эзэнт гүрэн болж хувирсан юм гэх мэтээр Евразийн түүх судлалаар мэргэшсэн А.Дугин «Чингис хаан», «Монголосфера», «Основы геополитики», «Абсолютная Родина. Метафизика Благой Вести» зэрэг 2000, 2001 онд гарсан судалгааны шинэхэн бүтээлүүддээ цохон дурдсан нь чухамхүү

Батын эзэмшлийн үеийн Орос орныг тодорхойлсон хэрэг юм.

Гэхдээ Бат ханы үе, ер нь Оросын түүхэн дэх Монголын үеийг тэс өөрөөр харуулсан «судалгаа» ч мөн олон байдгийг хэлэх хэрэгтэй. Романовынхны удмын хаадын захиалгаар Германы түүхч Байер, Миллер, Шлёзер нар Оросын түүхийг бичихдээ: «Татар Монголын талхидал» хэмээх нэр томъёог анх гаргаж ирсэн бөгөөд Оросын түүхэнд монголчуудын гүйцэтгэсэн үүргийг нэлэнхүйд нь гуйвуулах ажил XVIII-XIX зуунд эрчимтэй хийгдсэн юм. Оросын эзэн хааны шинжлэх ухааны академаас 1832 онд түүхчдийн дунд болзолт уралдаан зарлаж, «...Алтан Ордны улсын түүхийг шүүмжлэлт үзэл санаагаар боловсруулах»-ыг чухалчлан заагаад, шалгарсан зохиолд хоёр зуун червон (алтан зоос) шагнахаар тогтож байсан баримт бий[21]. Одоо ч энэ гуйвуулга үргэлжилсээр байна.

Хоёр

Батын үйл амьдрал бол нэг талаасаа дайн байлдаан, нөгөө талаасаа бүтээн байгуулалтын түүх юм. Оросын эрдэмтэн А.П.Окладников: «...Монголчууд дайран орсон нь жижигхэн вант улсууд болж бутарсан Орос оронд харийн булаан эзлэгчдийг эсэргүүцэх, Москваг тойрон Орос түмэн нэгдэх үйл ажиллагаанд тусалсан байна» гэж тэмдэглэсэн нь үйл явцын эерэг, сөрөг талыг цомхон, тод илэрхийлсэн хэрэг юм.

Аливаа түрэмгийлэл, байлдан дагууллыг зөвтгөх нь харалган бөгөөд шударга бус явдал болохсон. Ялангуяа хүчинд автагдсан улс орон, ард түмэн харийн эзэгнэлд амар тайван «жаргаж» байсан гэвэл үнэнд нийцэх үү?! Гэхдээ юманд учир, суманд занги бий. «... Монголчууд ... Орос орны тухайд вассалын дэглэм сахиж байжээ. Тиймээс (тэднийг) Оросод ... дан уй гашуу тарьж, эвдэж сүйтгэж байсан мэтээр үзэж болохгүй»[22], «...Алтан ордны харьяанд байсан хоёр зуун жил нь Орос оронд гачаал зовлонтой ч, бас Оросыг бусадтай холбосон баярлууштай хуудсыг түүхэнд үлдээжээ»[23] гэх мэтээр бичсэн хүн бол Хаант Оросын ерөнхий сайд байсан Пётр Столыпиний удмын Аркадий Столыпин билээ. Тэрбээр 1971 онд «Москва, Бээжингийн завсар дахь Монгол орон» ном бичиж, Францад хэвлүүлсэн юм.

Бат хан XIII зууны эхэн хагаст тархай бутархай, сул дорой байсан Оросыг нэгтгэн хүчирхэг эзэнт улсыг эмхлэн байгуулж, Монголын төрт ёсыг Оросын нийгэмд соёолуулж өгсөн нь маргаангүй үнэн билээ. Хууль ёс, яам тамга, алба татвар, хил гааль, өртөө унаа, нэгдсэн арми, элчин харилцаа, улс дамжсан худалдаа зэрэг төрт улсад л байдаг шалгуур ойлголт Оросод Батын эзэгнэлийн үеэс л орж ирсэн байна. Оросод Батын соёолуулсан Монголын төрт ёсны үр хөврөл олон зууны хатуу ширүүн сорилтыг дааж, Оросын нийгмийн хөрсөнд үндэслэн ургаж төлжсөн билээ. Энэ тухай Солонгосын эрдэмтэн Ким Жон Рэ: «...Монголчуудын цэргийн болон татварын систем Алтан орд үгүй болсны дараа ч Орос үндэстнүүдийн дунд Романовын эзэнт улсаар дамжин Зөвлөлт Холбоот Улс хүртэл хэрэглэгдсээр иржээ. Зөвлөлтийн эзэнт улс (Paix Sovetska) Монголын загварыг хэрэглэж байв» гэж дурдсан байна.

Гурав

Чингис, Өгэдэйн үеэс үүсч бүрэлдсэн Монголын эзэнт гүрэн, мөхөс миний төсөөллөөр бол, Холбооны (Federation) бүтэцтэй байжээ. Алтан ордны улс, Иль хаадын улс, Тураны

(Цагадайн) улс, Юань улс зэрэг нь энэ холбоог бүрэлдүүлж байсан байна. XIII-XIV зууны Монголын эзэнт гүрний төрийн тогтолцоо нь өнөө цагийн холбооны улс гүрний олон хэв шинжийг агуулсан бөгөөд өөр хоорондоо захирах-захирагдах дэг ёс, цэрэг зэвсгийн болон эдийн засгийн хүч чадавхийг хуваарьлан тэнцвэржүүлж, итгэмжлэн хянах нийтлэг бүтэц, эрх зүй, хамтран ажиллах, нэг нь нөгөөгөө нөхөх хэрэгцээ шаардлага зэрэг олон талаараа ижил төстэйг ухаарч болно.

Нарийн яривал, Батын үеэс Алтан ордны улсын дотор ч federation (confederation) маягийн харилцаа (Москвагийн улс, Ногайн улс, Цагаан ордны улс г. м.) байсан бөгөөд түүний үр хөврөл одоо хүртэл тасраагүй гэж үзэж болохоор байна.

Ер нь Монголын хаант төрийн цэрэгжсэн тогтолцоо нь тухайн цагтаа хүчирхэг төрт ёсны үлгэр болж байсан бөгөөд зөвхөн Оросод төдийгүй, Хятад, Энэтхэг, Европ, Дундад Азид хүчирхэг төрт улс гүрнүүд үүсэн тогтоход дууриал болсон гэж хэлж болно. Зөвхөн тухайн цагтаа гэдгийг цохон тэмдэглэе.

Эзэн хаант тогтолцоо, цэргийн хүчинд дулдуйдсан дэглэм өнөө хүртэл өчнөөн улс гүрэнд байсаар байна. Гэхдээ үүнийг зохиомлоор XIII-XIV зууны Монголын эзэнт төрийн хэв загвартай адилтгах буюу ер нь холбон үзэх үндэсгүй. Төрийн аливаа хэлбэр тогтолцоо нь зөвхөн тухайн улс оронд (орон зайнд), тухайн цаг үед таарч байж л үйлчилдэг, таарахаа болихоор солигддог, хувисамхай атлаа бүтээлч шинжтэй билээ. Монголын эзэнт гүрэн байгуулагдаж, түүний харьяанд тив дамнасан хүчирхэг улсууд оршин тогтож байсан нь Ази, Европ, Ойрх Дорнодын үндэстэн угсаатан, хүн зоны хооронд эдийн засаг худалдааны болон соёлын харилцаа, солилцоо, холбоо хэлхээ бий болгож, гурван тив, олон бүс нутгийн улс төр, нийгэм, эдийн засгийн дэвшилд даамай нөлөөлж, хөгжлийн хүчирхэг ундарга буй болгосон хийгээд, энэ утгаараа хүн төрөлхтний түүхэнд дорвилог байр суурь эзэлсэн болохыг өнөө цагт хэн ч үгүйсгэхгүй биз ээ.

Дөрөв

Бат хан Монголын нэр сүрийг Орос, Европ болон дэлхий дахинд хэдэн зуунд мартагдахааргүй дуурсган түгээсэн нь нэгэн цагийн цуу дуулиан төдий биш юм. Орос хэлэнд «Орос хүнийг сайн тэмтэрвэл татар яс баригдана» гэсэн утгатай хэлц үг байдаг. Үнэхээр ч Бат хан, Невийн Александрын үеэс Орос, Монголын сурвалжит дээдэс төдийгүй, эгэл хүмүүс хоорондоо ураг барилдах, цус холилдох явдал энгийн зүйл болж, өргөн уудам нутагт тарж суурьшсан цөөн тоот монголчууд Орос цусыг сэлбэн уусч сарнихдаа хүчээр тасалж үл болох гинжин холбоо үлдээсэн юм. Л.Гумилёвын судалгаагаар бол Оросод монгол гаралтай вангийн 92 удам, бояр ноёны 50 удам, гүнгийн 13 удам гээд язгууртны 300 гаруй удам байдаг, түүн дээр угсаа язгуургүй эгэл татарын удам бол хэдэн мянгаар тоологдох ажээ[24].

Түүний дотор Монголын удмаас Орос хаад Борис Годунов, мөн Фёдор Годунов, Догшин Иван нар тодорч, таван ч хатан хааны заяа ивээгдсэний дотор Их Пётрийн эх Наталья Нарышкина багтдаг юм байна. Орос төдийгүй, дэлхийд нэр алдраа түгээсэн эрдэмтэд Менделеев, Мечников, Павлов, Тимирязев, түүхч Кантемир, Карамзин, Л.Гумилёв, туйл судлаач Челюскин, Чириков, зохиолч Достоевский, Тургенев, Державин, Куприн, Булгаков, урлагийн тайзнаа бүжигчин Галина Уланова, Анна Павлова, жүжигчин Ермолов, Каратыгин,

хөгжмийн зохиолч Скрябин, Танеев, зураач Шишкин гээд оюуны ертөнцийн үе үеийн одод, дайчин алдраа Оросын нэрээр мөнхөлсөн олон зуун баатар, жанжин, генерал, маршалуудын судсаар монгол цус гүйж байсан ажгуу[25].

Тав

Монголын эзэнт гүрэн хүчирхэгжиж, түүхэнд урьд хожид байгаагүй, дэлхийн талыг эзэлсэн аварга их улс байгуулсан нь угаасаа феномен шинжтэй, онцгой үзэгдэл юм. Иймээс түүний өрнөл, оргил, буурлын үйл явц, учир шалтгааныг онол, сэтгэлгээний ямар нэгэн хэвшил загвар, «нийтлэг зүй тогтол»-ын үүднээс тайлбарлах аргагүй гэж үзнэ. Онцгой юм нь онцгой нөхцөл орчинд, онцгой цаг үед, онцгой орон зайнд л бий болсон байж таарна. Монголчуудын хувьд бусдаас ялгарах тэрхүү онцлог нөхцөл орчин нь бараг «цэвэр», «сонгомол» гэмээр нүүдэлчин ахуй хэвшилд нь оршиж байсан мэт. Нүүдэлчид үргэлж амьдрах орон зайгаа тэлэх гэж тэмүүлнэ. Энэ бол бодит хэрэгцээ. Иймээс байнгын хөдөлгөөнд оршино. Нэгэн газар түгжигдэн суух нь нүүдэлчдэд үхэлтэй адил. Амьдралын орон зай, эд баялгаа нэмэгдүүлэх гэсэн нүүдэлчид хоорондоо мөргөлдөнө, дайтана, хүчтэй нь дийлж, шинэ газар нутгийг хүнтэй, малтай нь, эд баялагтай нь эрхэндээ авна. Цаашлаад суурьшмал амьдралтай улс иргэдтэй тулгарна. Өөрөө үйлдвэрлэдэггүй, хийж чаддагүй бүхнээ тэднээс булаан авна. Дахиад л эрх мэдэл, орон зайгаа тэлнэ. Ийм замаар Монголын нүүдэлчид дэлхийн хагасыг эзэлсэн түүх өрнөсөн байна. Чингис, түүний үйл хэргийг үргэлжлүүлэгчид цөм энэ л замаар явсан. Энэ замыг туулсан. Энэ л зам дээр алдар нэр, алдаа оноо аль алиныг нь олсон. Энэ утгаараа Чингис, түүний үр ач нарын хийсэн аян дайн бол эдийн засаг, аж ахуйн ашиг сонирхолтой шууд холбоотой байсныг олон эрдэмтэн судлаач тэмдэглэсэн байдаг.

Нүүдэлчид бас суурьшихыг эрмэлзэнэ. Тэдэнд ч тав тух хэрэгтэй. Хамгийн гол нь суурьшиж байж л нийгмийн баялаг үйлдвэрлэдэг, нэмүү өртөг бүтээдгийг тэд зөнгөөрөө мэдэрнэ. Тэгээд хот балгас барина. Үйлдвэрлэгч иргэдийг эрхэндээ авна. Аль болохоор илүү их эд хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөхийг чармайна. Ингэж суурьшил руу өөрийн эрхгүй татагдана. Гэлээ ч нүүдэлчний задгай сэтгэхүй, эрх дураар авир араншин нь суурин ахуй сэтгэлгээний түгжигдмэл, нэгэн хэвийн байдалтай удаан эвлэрч үл чадна. Ингээд л зөрчилдөнө, тэрсэлдэнэ. Энэ бүхэн Бат ханы амьдрал, үйл ажиллагаан дээр тод харагдаж байна. Бусад хаадын түүх ч үүнийг бас нотолно.

Зургаа

XIII-XIV зууны Монголын эзэнт гүрний түүх, түүн дотроо Бат ханы түүх зүгээр л нэг болоод өнгөрсөн явдал биш, харин өнөөгийн дэлхий дахины үйл явдлын өрнөл хөгжилд учир холбогдолтой.

«Вашингтон пост» сонин, «Тайм» сэтгүүл Чингис хааныг мянган жилийн сод хүнээр тодруулан зарласан том өгүүлэлдээ, XIII-XIV зууны Монголын эзэнт гүрний нээлттэй бодлого, хурд, эрч хүч, дэг журам, мэдээлэл, харилцааны шуурхай, түгээмэл тогтолцоо, итгэлцэлийг чухалчилдаг үзэл өнөөгийн хөгжингүй орнууд, ялангуяа Америкийн бодит байдалд тусгалаа олж байгааг товойлгон тэмдэглэсэн бий. «Америк бол эрин үеийн Чингисийн эзэнт гүрэн» гэж Солонгосын монголч эрдэмтэн бичжээ. Америкийн эдийн засагч Мик Эйч Чингис хааны удирдах арга барилыг өнөөгийн менежментийн үндэс гэж

үзээд «Дөрвөн Е» гэдэг томьёо гаргасан байна. Энэхүү «Дөрвөн Е» нь: Envision — урьдчилан харж, төлөвлөх чадвар, Enable — түүнийгээ хэрэгжүүлэх боломж, чадавхийг бүрдүүлэх, Energize — зорилгодоо хүрэхүйц хүчтэй байх, Empower — үүний тул доорх хүмүүстээ зохих хэмжээний эрх мэдэл олгох явдал гэжээ.

Чингис хаан, түүнийг залгамжлагчид дэлхийг нэгдмэл нэг гэр бүл шиг (Global village) болгох, «Монголын энх амгалан» (Pax Mongolica) буюу Монголын дэг журмыг дэлхий даяар тогтоохыг зорьж, зүгээр нэг хүчирхэг эзэнт гүрэн байгуулахаас илт хэтийдсэн, дэлхий нийтийг хамарсан эрчимт үйл ажиллагаа явуулж байсныг XIII-XIV зууны Монголын түүх, тэр дундаа Бат ханы түүх барьцтай нотолж байгаа юм. Тэр эрмүүн үйл явц өнөөгийн амны уншлага болоод буй «глобализм» (глобалчлал), даяаршил буюу «дэлхийчлэл»-ийн олон шинжийг агуулж байсан нь илэрхий бус уу?!

Өнөөдөр энэ дэлхийн хүн зон өмсөх зүүх, идэж уух, эдэлж хэрэглэхээс эхлээд үзэж сонирхох, сонсож дуулах, хүсч эрхэмлэх зүйлээрээ хүртэл үйлдвэрлэгч хэдэн том гүрний эрхшээл дор өөрийн эрхгүй ижилсэн ойртож, өөрөөр хэлбэл глобалжиж, үндэсний онцлог, ахуй сэтгэлгээний ялгавар, уламжлал, зан үйл бүдгэрэн нийтийн нэгэн урсгалд уусч алдарсаар байгааг хэн үгүйсгэх билээ.

Энэ үйл явц бидний мэт цөөн тоот улс үндэстэнд ямар нөлөө үзүүлэх вэ?!

Манай улс даяаршлын үйл явцад юугаараа бусадтай ижилсэн ойртож, юугаараа ондоосч, «Монгол» хэмээн танигдахуйц дотоод, гадаад шинж төрх, амьдрах чадвар, оршин тогтнох хүчин зүйлсээ яаж хадгалж үлдэх вэ?

Энд ганц хариулт байж болох мэт.

Үндэсний хэл, бичиг, соёл, түүх, уламжлал, заншил, ёс төрөө хадгалж үлдсэн улс түмэн л өөрийгөө аварч, бусдаас ялгарах өөдтэй бүхнээ өвлөн авч, өргөтгөн хөгжүүлж, өнө хойчдоо дуудах нэртэй, дуурсах түүхтэй, эсэн мэнд оршин тогтнож чадна. Энэ утгаараа Бат ханы түүх нэн баялаг агуулгатай бөгөөд өнөөгийн бидэнд олон санаа, сургамж өгч, ухаарал мэдлэг хайрлаж байгаагаараа үнэтэй юм.

Дэлхийн хэмжээний дэг ёсыг тогтоох, шуудхан хэлбэл, дэлхийг бүхэлд нь ноёлон захирах гэсэн Монголын их хаадын бүхий л үйл ажиллагаа тодорхой үзэл санаанд тулгуурлаж байсан нь Багад мөн холбогдоно. Тэр үзлийг «Тэнгэрийн үзэл» хэмээн томьёолж болох тухай академич Ш.Бира сонин санаа дэвшүүлсэн байна («Өнөөдөр» 2002.12.07.) Тэрбээр: «...Тэрхүү үзэл санаа нь тэнгэрийн үзэл буюу тэнгэризм хэмээн нэрлэж болохоор ихээхэн хөгжсөн онол, ... бүхэл бүтэн улс төрийн үзэл суртал байсан хэмээн үзэж болно» гэж тэмдэглээд, Монголын тэнгэрийн үзлийн үндэс, үүсэл хөгжил, нийгмийн зориулалт, ач холбогдлыг ултай авч үзэхийн хамт энэ үзэл ба эдүүгээгийн дэлхийчлэлийн үзэл хоёрын ижил төстэй болон ялгаатай талыг ой тоонд буутал гаргаж өгсөн байна.

Тэнд бичсэнээр бол, монголчуудын тэнгэрийн үзэл нь их оюунлаг, хийсвэр шинжтэй, төрт суртахууны номлол агаад хүчинд дулдуйдсан засаглалын философи болж байсан бол одоогийн дэлхийчлэл, глобалчлалын үзэл нь их материаллаг, прагматик шинжтэй бөгөөд

хэрэглээнд тулгуурласан, авах өгөхийн ашиг хонжоог урьтал болгосон, эвээр илбэн захирах, мөнгөөр эрхшээх бодлого, үйл ажиллагааны төвлөрсөн илэрхийлэл ажээ.

Бат хан бол Монголын бусад хаадын адил «Тэнгэрийн үзэлтэй» хүн байсан нь илэрхий. Түүний үйл ажиллагаанд өнөөгийн «дэлхийчлэх» үйл явцын зарим шинж ажиглагдаж байна. Гэхдээ Бат болон Монголын хаадын «тэнгэрийн үзэл»-ийг өнөөгийн үүднээс «тэнгэрчлэн» шүтэж үл болно. Бас «дэлхийчлэн» дагаж ч үл болно. «Даяарших», «дэлхийших» үйл явцын хол ойрын тусгал энэ цагийн Монголын нийгмийн амьдралд гэрэл сүүдрийн солбицол лугаа сүлэлдэн байгааг үгүйсгэх аргагүй. Энэ нөхцөлд дэлхийн хөгжлийн нийтлэг хандлага, зүй тогтлыг огоорон тойрох, алгасах арга зам байхгүй. Гэлээ ч аль нэг улс орны хөгжлийн загварыг хуулах, дөвийлгөн шүтэх, хэн нэгний талыг туйлшран дагах нь үндэсний эрх ашиг, аюулгүй байдалд асар их хор хөнөөлтэй болохыг түүх бидэнд сургаж байна.

Долоо

Л.Н.Гумилёв бичихдээ: «Монголчуудын хийсэн аян дайн бол хамгаалах дайн байжээ» гээд, «Монголчуудыг цаг ямагт хатгаж, өдөж, хамгаалахаас аргагүйд хүргэж байв. Тиймээс тэд хариуг нь хатуухан өгч чухам ингэснээрээ ялж дийлж байжээ» гэсэн сонирхолтой гаргалгаа хийсэн байна. XIII-XIV зууны монголчууд байлдах дуртайдаа биш, харин Монгол улсынхаа бүрэн бүтэн, биеэ даасан байдлыг аварч үлдэх гэсэндээ, хил хязгаарын амгалан тайвныг хамгаалах гэсэндээ зогсолтгүй их аян дайнд өөрийн эрхгүй татагдан орж байжээ гэдгийг үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, тэр цагийн байдалд авч үзвэл «Байлдах уу, үгүй юу?» гэдэг нь «Орших уу, эс орших уу?» гэдэгтэй агаар нэг байсан ажгуу.

Жавахарлал Неру: «...Чингис хааны байлдан дагуулал нь дундад зууны үед гарч байсан дайн байлдааны ердийн хэм хэмжээнд явагдаж байсан, бусдаас илүү харгис, ширүүн байгаагүй» гэж «Ертөнцийн түүхийг сөхөж үзвэл» номондоо тэмдэглэжээ.

Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов «Чингис хаан» номондоо «...Хэрэв түүхийн эх сурвалжуудыг анхааралтай шинжлэн судалбал, Монголын Чингис хаан цус урсгах, харгислах, эвдлэн сүйтгэх гэж улайрч байгаагүй. Чингис тухайн эрин үеийнхээ үр хөврөл байсан, тэгэхлээр түүнийг эрин зууны нь орчин нөхцөлд авч үзвэл зохино. Түүнээс биш, өөр цаг хугацааны, өөр улс орны хэмжүүрээр цэгнэх нь үл зохилдоно. Чингис хаан өөрийн хийсэн том аян дайны явцад тухайн эрин үе дэх бусад орны цэргийн эрхтний явуулж байсан дайн байлдаанаас илүү харгис хэрцгий явдал хийж байгаагүй» гэж үзсэн байна.

Манай Монголын эрдэмтэн сайд А.Амар 1930-аад оны эхээр бичсэн «Монголын товч түүх» номондоо: «Өдгөө цагийн эзэрхэг түрэмгий улсуудын элдэв тэсрэх зэвсгийн хүчээр нэгэн хэсэг орон, хотын хүмүүсээр үл барам, улс орныг бүхлээр нь үнсэн товрог болтол сүйтгэж болохоор, үлгэрлэж үзэхэд, тэр эрт үеийн цөөн Монголын нум сум, сэлэм жадаар хэрхэн энэ мэт аюулыг үзүүлж чадах байсан хэмээн хэлэх аж» гэж учирлан өгүүлжээ. Энэ санаа XIII-XIV зууны Монголын хаад, түүн дотроо Бат ханы хийсэн аян дайны шинж чанар, хор хохирол, үр дагаварыг бодитойгоор ойлгоход арга зүйн учир холбогдолтой юм. Амар сайд ингэж бичиж суухдаа дэлхийн нэгдүгээр дайны хор хөнөөлийг XIII зууны монголчуудын аян дайныхтай харьцуулан бодож байсан байх. Гэтэл тэр цагт атом, цөмийн бөмбөг гараагүй, дэлхийн хоёрдугаар дайн болоогүй, хүн төрөлхтөн үй олноор хөнөөгч эрин үеийн зэвсэг техникийг

төсөөлөө ч үгүй байсан билээ.

Улс үндэстэн үүсч буй болсноос хойш өөр хоорондоо өнөө болтол их бага хичнээн дайн байлдаан хийв! XIII-XIV зууны монголчуудын аян дайн бол түүний зөвхөн нэг хэсэг нь. Зарим орон гүрэн өнөө хүртэл байлдсаар л байна. Америк, Иракийн дайныг хэлж болно. Дайн байлдаан болгон учир шалтгаантай, хожил хохиролтой, үр дагавартай. Энэ бүхнийг тухайн цаг үе, орон зай, бодит нөхцөл байдалтай нь цогцоор авч үзэж, үнэн мөнийг тогтоох, сургамж авах нь өнөөдрийн төдийгүй, ирээдүйн ач холбогдолтойг тооцон байж Бат ханы цадиг түүхийг улам гүнзгийрүүлэн хичээнгүйлэн судлах хэрэгтэй юм.

Ашигласан сурвалж

1. А л т а н ш а а. Монголын гурван хаан: Өгэдэй, Гүюг, Мөнх. Хөх хот, 1985.
2. БНМАУ-ын түүх. 1-р боть. Улаанбаатар, 1966.
3. Г а н б а а т а р Я. Их нүүдлийн түүх. Улаанбаатар, 2001.
4. Д а л а й Ч. Монголын түүх: Их Монгол Улс 1206-1260. Улаанбаатар, 1994.
5. Д а л а й Ч. Өгэдэй хаан // «Хаадын сан». Улаанбаатар, 2001.
6. Д’ О с с о н. Монголын түүх. 2-р боть. Хөх хот, 1991.
7. Ж у в е й н и А. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. (Дээд, доод дэвтэр.) Хөх хот, 1989.
8. Ж ү Я о т и н. Чингис хааны түүх шастир. Улаанбаатар, 2002.
9. К и м Ж о н Р э. Мянган жилийн түүхэн хүн. Улаанбаатар-Сөүл, 1999.
10. Л о ч и н С. Алтан ордны хаад // «Хаадын сан». Улаанбаатар, 2000.
11. М а ц у в о О. Хубилай хаан. Улаанбаатар, 1994.
12. Монгол улсын түүх. Ерөнхий редактор Ж. Болдбаатар. Улаанбаатар, 1999.
13. Монгол цэргийн түүхийн товчоон. Тэргүүн дэвтэр Улаанбаатар, 1996.
14. Монголын нууц товчоо. Дөрөв дэх удаагийн хэвлэл. (Ц.Дамдинсүрэнгийн орчуулга). Улаанбаатар, 1990.
15. Н а ц а г д о р ж Ш. Чингис хааны цадиг. Улаанбаатар, 1991.
16. П л а н о К а р п и н и Ж. Монголчуудын түүх. Р у б р у к В. Дорно этгээдэд зорчсон минь. Улаанбаатар, 1988.
17. Р а ш и п у н ц а г. Болор эрихэ. Хөх хот, 1985.

18. С т о л ы п и н А. Москва, Бээжингийн завсар дахь Монгол орон. Улаанбаатар, 2000.
19. Т о в у у д о р ж С. Зүчи хаан // «Хаадын сан». Улаанбаатар, 1999.
20. Х о р о л д а м б а Д. Монголчууд дэлхийн нийслэлийг байгуулсан нь. Улаанбаатар, 2002.
21. Ш а г д а р Х. Гүүг хаан // «Хаадын сан». Улаанбаатар, 2000.
22. Армянские источники о монголах. Извлечения из рукописей XIII-XIV вв. Пер. А.Г. Галстяна. Москва, 1962.
23. Б о г а т о в а Г. Феномен Золотой Орды // Журнал «Наука и жизнь», 1969.
24. Большая Советская Энциклопедия. Изд. 3-е. Москва, 1970.
25. В е р н а д с к и й Г. В. Очерки русской истории. Москва, 1928.
26. В е р н а д с к и й Г. В. Монголы и Русь. Москва-Тверь, 1996.
27. Г р е к о в В. Д., Я к у б о в с к и й А. Золотая Орда и её падение. Москва-Ленинград, 1950.
28. Г у м и л е в Л. Древняя Русь и Великая степь. Москва, 1989.
29. Г у м и л е в Л. Н. Этногенез и биосфера земли. Ленинград, 1989.
30. И в а н и н М. И. О военном искусстве и завоеваниях монголо-татар и среднеазиатских народов при Чингис-хане и Тамерлане. Санкт-Петербург, 1875.
31. Р а ш и д а д - Д и н. Сборник летописей. Том 2. Москва-Ленинград, 1960.
32. Сборник материалов, относящихся к истории Золотой Орды. Санкт-Петербург, 1884.
33. Х а р а - Д а в а н Э. Чингис-хан как полководец и его наследие. Элиста, 1991.
34. К л а і с V i e k o s l a v. Poviesti Hrvata. Zagreb. 1899.
35. Lieutenant-colonel R i n s k. Le Panasiatisme au 13 siecle sous le Tchingis-khan et ses generaux (литогр.).
36. M a r s h a l l R. Storm from the East. London, 1994.

Их Монгол улсын цэргийн агсамж (Кибчагийн аяны жишээн дээр)

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, доктор, профессор Жамбын
Базарсүрэн*

Дундад эртний тэртээ нэгэн цагт монгол цэрэг Өрнө зүгт дайлаар мордсон их аяныг судлаачид «Батын аян дайн», «Ахмад хөвгүүдийн аян дайн» гэхчлэн нэрийддэг агаад зорилгыг нь «дэлхий дахиныг эзэгнэх» гэдэг утгаар тодорхойлдог. Тэгвэл «Монголын нууц товчоо»-ны 275 дугаар зүйлд түүнийг «Кипчагийн аян» гэж товч, тодорхой өгүүлсэн байдаг. Энэ нэрэнд тухайн аян дайны зорилго тодорхой агуулагдаж байгаа бөгөөд түүнд нөгөө уран зохиолд өгүүлдэг шиг «эцсийн тэнгис хүртэл» дайлаан хийж, «дэлхийг эзлэн түрэмгийлэх» гэх мэт санаа огт байхгүй. Харин Чингис хааны үеэс дайсагнан амар байлгахгүй байсан кибчагуудыг л номхотгон төвшитгөх зорилготой байсан нь үйл явдлын өрнөлөөс ч тодорхой агаад кибчагууд зугтсаар Мажар хүрсэн тул байлдааны цагийн эрхэнд хөтлөгдөн Адриатын тэнгис хүрсэн нь тэр байлаа.

Гэтэл Бат ханы цэргийн зөвхөн баруун гарын харьцангуй бага хүчинтэй сөргөцөлдөж, морины нь хөлд өртсөн Орос, Польш тэргүүтэн улс аймгийнхан «хүчтэй эсэргүүцэл үзүүлж монголчуудыг туйлдаасны хүчинд дэлхий дахиныг Монголын түрэмгийллээс аварсан» гэж ялагдлаа цайруулан, өөрсдийгөө дөвийлгөж ярьцгаадаг нь огт үндэсгүй зүйл гэдгийг энэ «Кибчагийн аян» гэдэг томъёолол ч нотолж байгаа юм. Тэгээд ч тэр үеийн хамгийн хүчтэй нь гэгдэж асан рыцариудын голлох томоохон хүчин нь Польш, Моравийн нутагт бут цохиулж, Мажар кибчагуудтай хамтраад ч баралгүй хүчин мөхөсдсөн байсан тул хэрвээ монголчууд хүссэн бол Европ бүхлээрээ эрхшээлд нь ороход бэлэн болчихсон байсан билээ. XIII зууны Зальцбургийн нэгэн гар бичмэлийн «Татарын довтолгооны дууль» хэмээх хэсэгт монгол цэрэг, зэвсгийн тухайд:

«Галд шарамдагласан

Ган жадтан, тэд.

Хүршгүй алсад хаймсагч сумтан

Хатан болдыг ч цөмлөх зэвтэн

Харвасан бүхэн нь онтодно

Харин биднийх л онохгүй...»[26] гэж ихэд харуусан өгүүлээд, тэд уурссан барс мэт биднийг мөшгиж, таарсан бүхнээ сүйтгэж, суман мөндөр оруулах агаад арьсан тулмаар хөвөгч тэдэнд тэнгис далай, их уст мөрөн ч саад болохгүй, тэднээс аврагдан мултрах арга зам байхгүй гэсэн утгатай зүйлсийг тэмдэглэн үлдээсэн байна.

Монголчуудын хөлд шууд өртөөгүй австричууд ийн бичиж байна гэдэг нэгийг өгүүлж буй хэрэг. Бодвол цэрэг нь Польш, Чехийн хавьд тулаанд оролцоод сүйрсэн хэрэг биз.

Ийнхүү монгол цэргийн сүр хүчин дэлхий дахинаа цуурайтан бадарч, ялан дийлэгдэшгүй байсны үндэс нь цэрэг, эдийн засаг, улс төрийн гэх мэт олон хүчин зүйлтэй холбоотойгоос зэр зэвсгийн хүчин чадавхи багагүй нөлөөтэй байсан нь дамжиггүй. Монгол цэрэг тэр үед европынхны үл мэдэх галт, дарьт зэвсэг хэрэглэх болсон байсан бөгөөд Легницийн тулалдаанд бараг химийн зэвсэг хэрэглэсэн байх гэдэг таамаглалыг зарим судлаач дэвшүүлсэн байдаг. Гэхдээ энд тэр бүхнийг өгүүлэх цаг хугацааны боломж байхгүй тул монгол цэргийн агсамжийн тухай товч тойм төдий дурдахыг зорив.

Аливаа цэрэг эрсийн байлдааны чадавхи нь түүний «агсамж» буюу биедээ агсаж зүүсэн зэр зэвсэг, өмсгөл хэрэгслийн иж бүрдлээс ихээхэн хамаардаг. Өөрөөр хэлбэл тухайн цэрэг ямархуу хувцас хэрэглэл, зэр зэвсэгтэй, тэр нь байлдааны ажиллагааны театр буюу тухайн газар орны физик-газар зүй, цаг улирлын нөхцөл, байлдааны цагийн байдалд хэрхэн зохицож байгаагаас түүний хөдөлгөөний хурд, дайчин шалмаг ажиллагаа болон дайсан этгээдийн хөнөөх хэрэгсэлд үл эрсдэх чадавхи голлон шалтгаална. Түүгээр ч зогсохгүй, хүн нэг бүрийн хөдөлгөөний хурд, хөнөөлд үл эрсдэх чадавхи нь улмаар цэргийн анги салбар, цаашлаад бүхий л армийн манёврын боломж, байлдааны хүчин чадалд шууд нөлөөлдөг.

Судлаачид цэрэг дайчдын биед агсах зүйлийн нийт жин дунджаар биеийн жингийн 30 хувиас хэтрээгүй бол тохиромжтой гэж тогтоосон байна.

Эртний цэргийн агсамж нь нэгд: байлдах зэвсэг, хоёрт: байлдааны хэрэгсэл хэмээх үндсэн хоёр хэсэг, мөн аяны хүнс болон бусад хэрэгцээт нөөцөөс бүрддэг. Үүнд: «байлдах зэвсэг» гэдэг тодорхойлолтод дайтан тулалдах явцад хүн амьтан, хүрээлэн буй орчинд шууд хөнөөл учруулах үйлчлэл бүхий зүйлийг, тухайлбал илд, жад, хутга, сэрээ, бялуу шийдэм зэрэг охор зэвсэг, нум сум, гал, чулуу урвуулан шидэх урвуур, харвуур, чөдөр оньс зэрэг уртын зэвсэг, сөргөө мэт хориглолтын зэвсгийг хамааруулдаг.

Харин «байлдааны хэрэгсэл» хэмээх ухагдахуунд байлдааны явцад хүн амьтан, хүрээлэн буй орчинд хөнөөл учруулдаггүй ч тулалдаанд шууд нөлөөлдөг, байлдах нөхцлийг бүрдүүлэх үйлчлэл бүхий зүйлс, тухайлбал, дээл хувцас, байлдааны морь, хуяг дуулга, туг хиур, хэнгэрэг хүүрэг, төмөр тэрэг, үүлэн шат зэрэг олон зүйлс хамаарна.

Тэгэхдээ тэр бүх төрлийн байлдах зэвсгийн дотроос юу нь тухайн улс аймгийн цэргийн гол зэвсэг болж байсан хийгээд байлдааны хэрэгслийнх нь дотроос чухам юу нь гол хэрэгсэл болж байна вэ гэдэг нь тэрхүү цэргийн агсамжийг тодорхойлох үндсэн хүчин зүйл болдог. Байлдах арга тактик нь ч үүнээс нь ихээхэн хамаарна. Энэ нь гартаа саваа мод барьсан нүцгэн хүн болон бүрэн зэвсэглэсэн, өвч хуягт хүн хоёр тус бүр өөр өөртөө тохирсон арга мэхээр үзэлцэхтэй үлгэр нэгэн буюу.

Монгол цэргийн агсамжийн бүрэлдэхүүнийг авч үзвэл гол зэвсэг нь нум сум, гол хэрэгсэл нь зэвлэх морь болж байсан байна. Эндээс бид тэр үеийн монгол цэргийг «хүн—морь—нум гурвын нэгдэл» гэж товчоор тодорхойлж болно. Тэдгээрээс гадна монгол цэргийн агсамжинд илд, жад, хутга, бялуу шийдэм, дүүгүүр цалам тэргүүтэн охор зэвсэг, «хатангу дээл», төмөр (ялтсан) гутал тэргүүтэн өвөрмөц хийцийн, хатуу зөөлөн эдээр үйлдсэн хуяг дуулга, бамбай халх зэрэг байлдах олон төрлийн хэрэгсэл ордог байжээ.

Нум, сум. Их Монгол улсын цэргийн уртын зэвсгийн гол төлөөлөгч болж асан нум нь нарийн хийцэт нумын бүлэгт хамаарах эвэр нум байв.

Нумын үүсгэр буюу их биеийг хус юм уу, хулсаар хийж, янгир, усны үхрийн эврээр элэг хийж наадаг байна. Нуманд мөн буга, үхэр, адуу, тэмээ зэрэг амьтны шөрмөс, сур, могойн юм уу, загасны арьс, бугын эвэр, хусны үйс зэрэг олон зүйл хэрэглэдэг.

Дундад эртний үед монголчууд гагц дунд талдаа тууш 15-25 см урт эвэр наалттай «алангир» нум, дунд талдаа тууш эвэр наалттайгаас гадна нэг талын мөрний хэсэгтээ бас эвэр наалттай, тэгш бус хэмт «эртэгчин» нум, гичрийн үзүүртээ эвэр зуулга (амгавч)-тай «эвэр нум», шөрмөснийх нь дор нарийн төмөр тууз наасан «болд ширхэгт нум» буюу «төмөр ширхэгт нум» зэрэг олон төрөл, хэлбэрийн эвэр нум үйлдэн хэрэглэж байжээ. Амгавч нь хоёр оньтой нум ч байдаг. Тийм ар, өвөр хос онины нэгийг нь ойрын зайд, нөгөөг холын зайд харвахад хэрэглэдэг.

Монгол цэрэг дайн байлдаанд мордохдоо хүн бүр наад зах нь хатуу, зөөлөн хоёр, гурван төрлийн нумтай, дүүрэн зэв сумтай гурван саадагтай (60-90 ширхэг сумтай) явдаг байжээ. Дундад эртний үеийн монгол цэргийн хамгийн зөөлөн нум нь 30 орчим килограммын таталтай байсан бөгөөд тийм нумаар хорь, гучин алхмын дотор хир баргийн хуягийг нэвт харвадаг байж. Харин хамгийн хүчит, хатуу нум нь «төмөр буюу болд ширхэгт нум» бөгөөд тийм нумын татал 70-80 кг-аас багагүй байв.

Монгол цэргийн нум сумын ашигтай тусгал 200-300 метр, хаймсах алсын тусгал 600-700 метр, түүнээс ч их байсан нь монгол цэрэгт тулалдааныг 200-300 метрийн алсаас эхлэх боломж олгож байв. Энэ нь охор зэвсэгт суурин улсын ихэнх цэргийн хувьд амжилттай тулалдах боломжгүй холын зай байлаа.

Сяо Дахэний «Монголын зан суртахууны тэмдэглэл»-д «Дүгрэг татаад талбивал 20-30 алхмын дотор хуягийг нэвт, өвчүүг шувт харвана»[27] гэсэн байх агаад «Монгол татарын бүрэн тэмдэглэл»-д монгол нумын хөвчийг тэлэх хүч «нэгэн ши-гээс дээш баймой» гэсэн байна[28]. Нэг ши нь одоогийн 29 кг 980 гр-тай тэнцүү буюу монгол хэмжүүрээр бол зургаан хөвчийн нум болно. Энэ баримтаас бид «XIII зууны монгол цэргийн хэрэглэж байсан хамгийн бага хүчтэй буюу зөөлөн нум нь зургаан хөвчийнх байжээ» гэсэн дүгнэлт хийж байгаа юм. Үүнийг одоогийн нумтай жишвэл нэлээд хатуу нуманд орж байна. Тухайлбал, одоогийн монгол сур харвааны нум 24-32 кг-ын таталтай, байт харвааных бол 23 кг-аас хэтэрдэггүй.

Монгол нумаар цэц мэргийн дээд амжилтыг Чингис хааны ач Есүнхэ мэргэн тогтоосон бөгөөд тэрээр 1225 онд 335 алд (ойролцоогоор 569-580 метр) газарт бай харван оносныг одоо ОХУ-ын Санкт-Петербург хотын Эрмитажд хадгалагдаж буй «Чингисийн чулуу» хэмээн нэрийдэгдсэн хөшөөнд сийлэн үлдээсэн байна.

Нум сумын иж бүрдэлд нумаас гадна зэв сум, эрхийвч, саадаг юм уу, ховд, хоромсого зэрэг зүйл ордог.

Зэв, сум нь «байлдааны», «наадам тэмцээний», «агнуурын» гэсэн гурван өөр зориулалттай,

олон төрөл, хэлбэртэй байна. Байлдааны бүхий л төрлийн сумыг ерөнхийд нь «зэв» гэж нэрлэдэг байжээ. Гэхдээ шаардлага гарсан үед наадам тэмцээн, агнуурын зориулалттай зэв сумаа ч байлдаанд хэрэглэдэг байсан нь ойлгомжтой.

Монголчууд эртнээс эхлэн хадаас шиг нарийн шовх хэлбэртэй «учимаг», цүүц маягтай, хурц охор хошуутай «хануур зэв», үзүүр тал нь тэгш «цавчуур зэв», хурц шовх «хатгуурст зэв», ац, сэрээ маягийн «анга зэв», «ацат зэв», хөндлөн огтлолоороо чагталсан дөрөв юм уу, гурван ир (хянгар) бүхий гурвалж, дөрвөлж хэлбэртэй «тооновт зэв» буюу «тоонолж», төмрийнхөө үзүүрт дарь юм уу, шатаагч бодис бүхий «галт зэв» зэрэг олон төрөл, нэрийн зэв хэрэглэдэг байв. Зэвний ирийг илд, хутганы адил тусгайлан хатаадаг нь хир баргийн хуягийг нэвтлэх бололцоог олгодог байна.

Зэв, сумын хөнөөх чадварыг дээшлүүлэхийн тулд зэвэнд тусгайлан бэлдсэн хор шингээдэг. Монгол болон Төв, Умарт Азийн овог аймгууд зэвэнд түрхэх хорыг ургамал, мөн могойноос ялгаруулан авдаг байв. Ийм хорт зэв, сумыг заавал нарийн хараалах шаардлага ч байхгүй агаад бяцхан шалбалах төдийхөн болоход л дайсан этгээд нь жагсаалаас гарахад хүрэлцээтэй байжээ.

Монгол нум маш хүчтэй хатуу байсан учраас харвалгын үед эрхий хурууг хамгаалах «эрхийвч» хэмээх тусгай хуруувч хэрэглэдэг. Дундад эртний үед эвэр, ясаар голчлон хийдэг байжээ. Эрхийвчгүй бол хэдхэн харваад л хурууны арьс зулгаран харвах аргагүй болно. Харин зөөлөн нум, зөөлөн хөвчтэй бол эрхийвч хэрэглэх шаардлагагүй. Тийм учраас нум, сум гол зэвсгийнх нь тоонд ордоггүй, зөөлөн нумтай асан өрнөдийнхөн монголчуудын довтолгооны өмнө эрхийвчийг мэддэггүй байсныг дурдах нь зүй байх.

Монгол цэргийн байлдааны гол хэрэгсэл нь дээр өгүүлсэнчлэн «зэвлэх морь» байв. Байлдаанд унахаар сонгож, тусгайлан сургуулилсан шилмэл агтыг тийн нэрлэдэг. Цэрэг бүр 3-4, түүнээс ч олон зэвлэх морьтой явна.

Монголчууд байлдаанд унах морьдоо эртнээс инагш тусгай шинжээр сонгон шилж авдаг байсан учир тэсвэр хатуужил, амьдрах чадвараар гойд байв. «Морины судар» хэмээх судруудад «Ер морины шинж найман түмэн дөрвөн мянган бүлэг буй» хэмээжээ. Тэгэхдээ тэр бүх шинжийг гадаад, дотоод, нууц гэж гурав бүлэглэн ангилдаг. Тэрхүү ангиллын дагуу сонгож авсан байлдааны хүлгээ XIII зууны үед «зэвлэх морин» гэж нэрлэдэг, тэдгээрийг адгуулах хүнийг «агтчин» хэмээн нэрийдэж тусгайлан томилдог, харин бусад адуун сүргийг маллах хүнийг «адуучин» гэж ялгаатай нэрлэдэг байв. Ер нь адуу монголчуудын амьдралд амин чухал үүрэгтэй байсан учир агт морьдын асуудал төр, цэргийн бодлогод нь хүртэл гол анхаарах зүйлийн нэг байсныг хэлэх хэрэгтэй. Дайсантай байлдах шаардлага гарлаа ч агтныхаа хурд хүч, тарга тэвээргээс шалтгаалан тухайн үед байлдах эсэхээ шийддэг байв.

Зэвлэх морьдыг бүр унаган цагаас нь тусгайлан сургуулиж, байлдаанд байнга бэлэн байлгахад онцгой анхаардаг байж. Тиймээс зэвлэх морьд дайсныг мөшгих үед уургач морь лугаа адил мөр алдалгүй гээг даран хөөх, налах, цахдах, суух, хэрэгцээтэй үед түлхэх, бултан бусгах, их усанд ч хөвөн сэлэх, дайны талбарт эзнээ үл орхих зэргээс эхлэн цэргийн төрөл бүрийн эрдмийг эзэмшсэн байдгаараа бусад адуунаас ялгаатай байжээ.

Монголчууд наад зах нь Хүн гүрний үеэс эхлэн цэргийн арван, зуун, мянганы морьдын зүсэм ижилсүүлэн нийлүүлдэг уламжлалтай байсан нь цэргийн удирдлагыг хөнгөвчлөх арга байсан агаад XIII зуунд монгол цэрэг гадагш дайлаар явахын зуур агт татварлахдаа мөн л зүсэм заан авдаг байжээ. Ийнхүү агт морьдын зүсэм, жадны молцог, хуяг дуулганы өнгө гэх мэт зүйлийг ижилсүүлдэг нь гагц цэргийн гаднах өнгө, сүр жавхааг харуулах төдийгүй, гол нь цэргийг байлдааны явцад төөрөггүй танин мэдэж удирдах хийгээд цэрэг дайчид нь ч өөрсдийн аравт, зуутынхнаа хатгалдаан, цавчилдааны явцад зайлшгүй тохиодог үймээн бужигнаан дунд андалгүй харж, тэднээсээ тасрахгүй байхад чухал хэрэгцээтэй зүйл байв.

Чингис хаан, түүнийг залгамжлагчдын их аян дайн, ялалт амжилтанд монгол морьдын оруулсан хувь нэмэр асар их бөгөөд зэвлэх морьдгүйгээр өөр ямар ч сайн зэр зэвсэгтэй байлаа гэсэн тавьсан зорилгодоо хүрэх нөхцөлгүй байсан нь ойлгомжтой.

Зэвлэх морьд нь одоогийн цэргийн авто, хуягт танкийн техник, нисэх онгоц лугаа адил дундад эртний монгол цэргийн байлдах аргын үндэс-манёврын тактикийг хэрэгжүүлэх гол хүчин зүйл байв.

Хуяг дуулга. XII-XIII зуунд монголчууд ерөнхийдөө хоёр төрлийн бүтэц хийцтэй хуяг, тухайлбал, бүхэл биеийг халхлах «өвч хуяг», эсвэл богино хантааз маягтай «охор хуяг» хэмээх хуяг хэрэглэдэг байв. Тэдгээрийг хатуу (төмөрлөг болон хэр баргийн сум нэвтрэхээргүй болтол нь тусгайлан боловсруулж хатууруулсан арьс шир) юм уу, зөөлөн (арьс, шир, олс, мяндас гэх мэт) хоёр үндсэн төрлийн эдээр хийдэг байжээ.

Зөөлөн эдээр хийсэн хуягийн дотроос дундад эртний үед хамгийн түгээмэл байсан нь «хатангу дээл». Энэ нь хуягласан монгол дээл маягийн хуягийн ерөнхий нэр юм. Хатангу дээл нь мөрөвчтэй, мөрөвчгүй, урт, богино хормойтой, эсвэл өвдөг хавьцаа хүрсэн богино хормойтой, захнаас хормой хүртлээ тууш шулуун энгэртэй юм уу, эсвэл монгол дээлийнх шиг ташуу энгэртэй, урт «харавч» буюу ханцуйтай, эсвэл гагц охор харавчтай зэрэг олон янз байжээ. Ийм хуягийг хожуу үеийн лувч, бэгтэр хуяг шиг дийлэнхдээ хээтэй, хээгүй торгомсог эд, өрмөг даавуугаар өнгө татан гадарласан байх авч, бас гадаргүй ч байсан байна.

Хатангу дээлийг анх хатуу ширэн тушим буюу ялтсаар хийдэг байсан агаад сүүлдээ төмөрлөг тушим хэрэглэх болжээ. Ийм тушимыг дээлийн гадар өнгөнд ил хадахаас гадна бас дотор талд бэхлэн тогтоодог тул дээлийн өнгөнд зөвхөн үдсэн хадаасны тав, малгай л ил гарсан байдаг байна. XIII зуунаас хойш хатангу дээлээс үлгэр авч Өрнөдөд жижиг тушим хэлхэн хийсэн уян хатан «бригантина» хэмээх хуяг хэрэглэх болсон билээ. Мөн монгол хийцийн тиймэрхүү хуягийг Оросод «куяк», Хятадад «татар хуяг» хэмээн нэрлэдэг байжээ.

Дундад эртний монголчуудын хэрэглэж асан хуягийн дотроос онцлог нэгэн бол «мяндсан хуяг» юм. Түүнийг үйлдэхдээ мяндсыг давхарлан зулж нягтруулаад торгомсог эдээр бүрж дээл, хантааз хэлбэртэй хийдэг. Мяндсан хуягийг хамгийн дотуур өмсөх бөгөөд нягтруулсан зөөлөн мяндас нь барагтай бол тасарч урагддаггүй учир нэгд: сумыг биенд гүн нэвтрэхээс хамгаалдаг; хоёрт: зэвний хамт биенд орсон мяндаснаас татахад амархан сугаран гарч ирдэг. Ийм хуяггүй бол сумыг сугалан авах үед шархыг урж сэдрээх аюултай байжээ; гуравт: биенд орсон мяндсан эд нь зэвэнд түрхсэн хор цусанд нэвчин тархахаас сэргийлэн хамгаалдаг өвөрмөц шинжтэй байна.

Хатуу хуяг үйлдэх үндсэн эд нь төмөрлөг болон хир баргийн сум үл нэвтрэх, усанд үл дэвтэх болтол нь халааж боловсруулсан шир байв.

Плано Карпини «мөр холбох» аргаар үйлдсэн хуягийн хийц, бүтцийг тодорхойлохдоо: «Уртаашаа алга дарам, өргөнөөрөө хуруу хэртэй нимгэн төмрийг олноор үйлдэн, тус бүрт найм найман жижиг нүх гаргаж, түүндээ бөх суран уяа гурвыг сүвлэн төмрүүдээ шатлан давхарлаж тавиад түүнийгээ зурвас ширэн дээр нүх нүхээр нь нарийн тасмаар бэхэлж тогтоосон байх бөлгөө. Тэдгээр төмөр ялтсуудаа бөх сайн нийлүүлэхийн үүднээс дээд ирмэгээр нь зурвас шир давхарлаж оёод ялтсан бүс болгоно. Дараа нь тэр болгоноо дээр дурдсан маягаар хооронд нь холбомой. Ингэж агт морьд болон эр цэргийнхээ хуягийг хийнэ. Тэгээд тэр хуягаа нүүр харагдтал гялалзуулан зүлгэсэн байх бөлгөө»[29] гэсэн байдаг.

Өмнөх үеийнхтэй харьцуулан үзвээс XII-XIV зууны тушим хэлхсэн монгол хуягийн үдээс холбоос нь өвөрмөц шинжтэй болж иржээ. Үүнд: тушимын дээд ирмэгийг хос үдээс, малгайт хадаасаар дарж тогтоосон байсан ба тушим нь харьцангуй уртавгар болсон байжээ.

«Тушим хэлхэх» аргаар үйлдсэн хатуу арьсан хуягийн тухай Плано Карпини мөн бичихдээ: «Алга дарам өргөн шир аваад гурав, дөрвөөр нь тавьж давирхайдаад хооронд нь нарийн сур юм уу, олсоор үдэн торгооно. Тэгээд дээд талын ширнийхээ доод ирмэгийг дараагийн ширний дунд хэсэгтэй нь сураар хэлхэх маягаар хийх бөгөөд ингэж хийсэн хуягийг өмсөхөд хэлхээтэй ширний доод талынх нь дээд талынхаа доогуур шурган орж, хоёр юм уу, гурван давхар болох бөлгөө»[30] гэсэн байдаг. Ийнхүү мөр бүрийг нөгөөгөөр нь дарж давхарлан үдсэн ширэн хуяг маш хатуу болдог байна.

Вильгельм (Гильом) де Рубрук «Мангу (Мөнх) ханд зэвсэгтэйгээ бараалхсан хоёр хүн маш зохимжгүй бөгөөд таарамжгүй хатуу арьсан цамцтай байсныг би харсан» гэсэн байдаг. Ийм «цамц» буюу мөрөвч, хормогчгүй хуягийг чухам юугаар хийснийг үл харгалзан ерөнхийд нь «дэглэй хуяг» гэнэ. Дэглэй хуягийг зөвхөн арьс ширээр ч бус, мөн төмөр тушим хэлхэж ч хийсэн байдаг.

Хатуу хуягийн тушим, ширний хавьс ширхгийг мөр холбон хөндлөн тийш нь тэгш дөрвөлжин шулуун үдэхээс гадна бас ташуу нүдлэн холбосон ч байна. Хатуу хуяг нь зөөлөн хуягийн адил гол төлөв дээл, хантааз маягтай бөгөөд мөрөвчтэй, мөрөвчгүй, урт богино хормогчтой, будагтай, будаггүй, тэгш юм уу, ташуу энгэртэй, цагаан харавчтай юм уу, эсвэл гагц охор харавчтай байна. Төмөр хуягийг гялалзтал өнгөлж, арьсан хуягийг ус чийгнээс хамгаалж чийддэг.

Дээр дурдсан хуягуудаас онцлог нэгэн бол «хөө хуяг». Түүнийг олон жижиг төмөр гархи холбон хийх бөгөөд нийтийн тооллын I мянган жилийн орчим Төв Азийнхан анх бүтээн хэрэглэх болжээ.

XIII-XIV зууны үеийн монгол цэргийг дүрсэлсэн түүхэн сурвалж зургуудад хоёр төрлийн хөө хуяг, тухайлбал, нэгд: богино, дэглэй маягтай хуяг, хоёрт: өвдөг хүрсэн гархин дээл маягтай хөө хуяг дүрслэгдсэн байдаг. Харин аль ч төрлийн хөө хуяг охор харавчтай (богино ханцуйтай) байжээ. Монгол сурвалжуудад бас «давхар хөө хуяг», «дархан хөө хуяг» гэх нэр тохиолддог оос үзэхэд зарим хөө хуягийн төмөр гархийг давхарлан бэхжүүлж хийдэг байжээ гэж ойлгож

болохоор байна. Заримдаа бас тушим болон төмөр гархи аль алиныг хослон хэрэглэсэн «тушимт хөө хуяг» ч хийдэг байсан уламжлал бий.

Хуяг, дуулгаар халхлагдаагүй биеийн зарим хэсгийг хамгаалах, бас хуягийг давхарлан бэхжүүлэх зориулалттайгаар толь, хүрз, хуягийн жийргэвч буюу үүлт мөрөвч, тохойвч, хөлийн шилбэний хаалт зэрэг зүйлийг бас хэрэглэдэг. Үүнд, хуягийн цээжний газарт дөрвөн товч хадаж товчлон халхлах дүгрэг хавтгай төмрийг «толь» гэнэ. Толийг анх дөрвөлжин хэлбэртэй хийдэг байсан бөгөөд зөөлөн хуяг юм уу, ердийн дээлэн дээр ч халх болгон энгэртээ зүүдэг байжээ. Хуяган дээр давхарлан элгэндээ бүсэлдэг буюу хавчуулдаг тийм дөрвөлжин толийг «хүрз» гэдэг.

Хуягийн дээр давхцан нөмөрдөг додиг маягийн угалзалсан мөрөвчийг монголчууд XIII зуунд их хэрэглэж байв. Тэдгээрийг «хуягийн жийргэвч» гэнэ. Түүнийг эсгийгээр хийж, цагаан шоогоор доторлон, хоргой торго зэргээр өнгө татаж гоёмсгоор эмждэг байжээ.

Угалзалсан дөрвөн үүл мэт хэлбэртэй жийргэвчийг «үүлт мөрөвч» гэх бөгөөд таван өнгийн хоргой, торго, сиймхий эдээр үйлдэж, алт, мөнгөн саагаар чимэглэдэг байв.

Хуягийн жийргэвч, үүлт мөрөвч нь хүзүү мөр, хоолой цээжийг халхлахаас гадна хуягийн мөрөвч, харавчийг бэхэлж тогтооход ч хэрэглэгддэг ба хуягийн жийргэвчийг нэлээд зузаан хатуу ширээр хээ, чимэг тавьж хийдэг. Бас төмөрлөг тушим, хавьстай, хөө хуягийн маягаар гархи хэлхэж хийсэн, заримдаа мөр холбох аргаар хийсэн нь ч байна.

Дуулга. Монголчууд эрт цагаас эхлэн дуулгыг арьс шир, төмөрлөгөөр үйлдэн хэрэглэж ирсэн бөгөөд хийц чимгээрээ олон янз байдаг. Дуулгыг хэрэглэгчийн хэргэм тушаалаас шалтгаалан алт, мөнгөөр чимэглэх бөгөөд хуягийн өнгийг дагуулан өнгөлөх нь элбэг.

Ихэнхи монгол дуулга шовхгор оройтой бөмбөлөг хэлбэртэй байдаг нь тэдгээрийн нийтлэг бөгөөд бусад улс орныхоос ялгарах хэлбэр шинж юм. Тэгэхдээ бараг тал бөөрөнхийгөөс авахуулаад зуувгар шовх хүртэл олон янз маягтай, зүйдэлтэй нэгэн цул төмөр юм уу, эсвэл хоёр, дөрөв, түүнээс олон хэлтэс төмрийг нийлүүлэн зүйж хийсэн ч байна.

Дуулганы төмрийн хормойг тойруулан даравч, магнайвч хадсан байх ба чихэн талыг чибгэчиэр халхлана.

XII-XIV зуунд монгол цэргийн хэрэглэж асан гадаад, дотоод гарвал, хийцтэй олон янзын дуулгын дотроос арагшаа гэдийсэн конус (шовхгор) оройтойг нь цэвэр монгол гаралтай гэдэг. Өндөр оройн оронд бас жижиг бөмбөлөг хадах нь ч байдаг байжээ.

Оройд голдуу зэс, гуулиар сийлэн үйлдсэн «соновтор» хэмээх чимэг хатгана. Мөн өнгө өнгийн хялгас, өд зэргийн юмыг залган, залаа мэт унжуулан оройд хатгасныг ч бас соновтор гэнэ.

Зарим дуулганд хоёр салаа хэл маягийн ширэн унжлага зүүж байсан байна.

XIII-XIV зууны үеийн зарим монгол дуулга нь өндөр орой дээр суулгасан бөмбөлөг маягийн

сөхмөл цэцэгтэй байсан нь бусдаас ялгарах бас нэг содон шинж ажээ.

Бамбай, халх. Бамбайг хатууруулан боловсруулсан арьс шир, мод, төмөрлөгөөр үйлддэг байжээ. Монголчууд дундад эртний үед бүх төрлийн дугуй бамбайг «халх» хэмээн нэрлэдэг байв. Жижиг дугуй, пөмбөгөр хэлбэртэй агаад уян хатан, бөх бат модны мөчрөөр сүлжин олон өнгийн утсаар хээ хуар гарган чимэглэж, төв дунд нь толь хадсан байх нь олонтаа. Бас яг ийм хэлбэр, хэмжээтэй боловч бөх бат модоор үйлдэж, хатуу ширээр гадарлан төмрөөр тасамдан эмжиж, дунд нь толь хадсан бамбай ч ихэд тархсан байжээ.

Бас 90 гаруй см өргөн, 140-өөд см өндөр, зууван хэлбэртэй том бамбайг монгол цэрэг гадагш дайлах болсон үеэс хот, цайзыг дайлах, дайсныг өдөж хөдөлгөх, бүслэн хаахад их хэрэглэх болжээ.

Мөн газраас мөр хүртэл халхлах дөрвөлжин хэлбэртэй том бамбай ч хэрэглэж байсан байна. Ийм дөрвөлжин бамбайг «тулас» гэдэг.

Морины бүрэн тоног, халх хуяг. Цэрэг эрс бүхэн эмээл хазаараас эхлээд бүрэн тоног хэрэгсэлтэй, мөн нилээд нь морины халх хуягтай байв.

Морины хуягийг төмөрлөг болон хатуу, зөөлөн арьс шир, эсгий зэрэг эдээр хийнэ.

XIII зууны үеийн хатуу ширээр туузлан мөр холбож хийсэн, мөн тушим хэлхэж үйлдсэн төмөр хуягийн тухай Плано Карпини бичихдээ: «Морины хуяг таван хэсгээс бүрддэг. Сүүлнээс аваад толгой хүртэл биеийн хоёр хажуугаар тус тус нижгээд хамгаалалт хийх бөгөөд тэдгээрийг эмээлтэй холбож тогтооно. Бас эмээлийн араас хондлой нурууг, мөн урагш хүзүүг хаасан хамгаалалт тус тус байх ба олон яс уулзахын хавьд үдэж холбоно. Хондлой нурууны хамгаалалтанд нүх гаргаж түүгээр мориныхоо сүүлийг гаргана. Бас цээж хэнхдэгийг хамгаалсан байдаг. Эд бүгд доош өвдөг, эсвэл шилбэ хүртэл унжина. Морины магнайн тус газар зурвас төмөр хамгаалалт хийж хүзүүний хоёр талаар явуулан дээрх хамгаалалттай холбон тогтоодог»[31] гэжээ.

Бүтцийн хувьд дээрхтэй ижил авч дан төмөр гархин юм уу, төмөр, хүрэл тушим болон гархи хослон үйлдсэн хуяг ч бас байдаг.

Бусад хэрэгцээт зүйлс хийгээд хүнсний нөөц. Монгол цэрэг нэг бүр зэр зэвсгээсээ гадна халуун, хүйтний аль ч улиралд тохирсон дээл хувцас, дах дэгтий, нөмрөг цув, мөн зэв сум, илд хутгаа ирлэх хуурай, олс татлага, хэт цахиур, аяны тулга тогоо, тэр ч атугай зүү утас зэрэг өдөр тутмын хэрэгцээнд эн түрүүнд шаардагдах бүхий л зүйлийг бэлтгэж явдаг байжээ.

Хүнсний зүйлс гэвэл аян замын урт, халуун хүйтний хэлбэлзлийг даахуйц чанартай агаад тэжээллэг, тээвэрлэхэд төвөггүй, овор хэмжээ, жин багатай зүйлс болох нүдсэн борц, ааруул хурууд, ээзгий, шар, цагаан тос зэрэг аяганы бусад хийц байдаг. Тэр бүхнээ аяны зориулалттай авсаар хийцтэй богц, даалин, дашмаг, борви, бортогон саванд хийж тээвэрлэдэг байжээ.

Энэ мэт хүн нэг бүрийн агсамжид байх зүйлээс гадна монгол цэргийн аравт, зуут, мянгат бүр

аян дайнд шаардлагатай, нийтийн хэрэглээний зүйлсийг шаардагдах хэмжээгээр бэлтгэж явдаг. Жишээ нь, аравт бүр чачир майхан, тулгат тогооноос эхлээд хоол унд хийх бусад хэрэгсэлтэй байдаг ба аж ахуй хариуцсан туслах хүн хүчтэй ч байдаг байжээ. Тухайлбал: зэвлэх сэлгээ морьд болон ачилга, уналга, хүнсний адуу малыг адуулах хөтөч, адуучин, саальчинтай, бас эмч домч, шархач, зэвсгийн дархан зэрэг хэрэгтэй бүхэнтэй явдаг байна.

Өөрөөр хэлбэл монгол цэрэг Эренжен Хара-Даваны бичсэнчлэн «*Omnia mea mecum porto*» («Миний гэсэн болгон надтай хамт яваа»)[32] гэж ам дүүрэн хэлэх боломжтой байжээ.

Төгсгөл

Монгол цэргийн агсамжийн тухай товч өгүүлвээс ийм байна.

Тэгвэл Кибчагийн аяны үед монгол цэргийг сөрөн зогсож байсан тэр үеийн Өрнөдийн хамгийн хүчтэй цэрэг болох «рыцарь» буюу монголчилвол «морьтон баатар» хэмээх цэргийн агсамж ямархуу онцлогтой байв? Рыцариудын байлдааны гол зэвсэг нь жад, гол хэрэгсэл нь морь, хуяг байв. Өөрөөр хэлвэл рыцариуд нь «хүн—хуяг—морь—жад» дөрвийн цогц байж гэж болно.

Хуяг нь монголчуудынх шиг жижиг ялтсаар хийсэн хөнгөн, уян хатан биш, харин цул төмрөөр хийсэн агаад биеийг өвч халхалсан нүсэр хийцтэй байв. Хамгийн хүнд хуяг нь 70-80 кг хүрдэг. Тийм хуягтай хүн өөрөө морин дээрээ мордож чаддаггүй тул тусгай хөшүүрэг хүртэл хэрэглэж мордуулдаг, байлдааны явцад хэрвээ мориноосоо уначихвал өөрөө биеэ дааж босож ч чаддаггүй байсан байдаг.

Кибчагийн аянд монголчуудтай Легницийн дэргэд тулалдсан рыцариуд харин ийм нүсэр хүнд хуягтай байгаагүй. Гэхдээ л монголчуудтай харьцуулахад хүнд хуягтай, морьд нь том, хүнд биетэй, одоогийн томъёоллоор бол хүнд морьт цэрэг байсан байна.

Тэдний гол зэвсэг болох жад нь урт бөгөөд хүнд байснаараа онцлог. Тийм учраас ердийн үед жад, хуяг дуулгыг нь түүнийг дагалдан явагч «зэвсэг агсагч» нар нь барьж зөөж явдаг байжээ.

Зэр зэвсэг, түүний дотор агсамжийн хувьд ийм ялгаатай байсан учир Монгол болон Европын улс орнуудын цэргийн хэрэглэж асан байлдааны арга тактик ч эрс ялгаатай байсан билээ. Тухайлбал: монгол цэрэг дан хөнгөн морьт цэргийн хөдөлгөөн, хурданд дулдуйдсан, одоогийн цэргийн хэллэгээр бол «манёврын дайны тактик» хэрэглэж байсан бол Өрнөдийн суурин улс орны цэрэг «үл хөдлөх, шигүү жагсаалаар журамласан бөөн цул хүчээр түрж байлдах» аргыг гол болгодог байв. Байлдааны энэ хоёр арга тактик, зэр зэвсгийн аль нь илүү байсныг түүх нэгэнтээ нотолсон болохоор энд тэр тухай ярих нь илүүц буй за.

Одоогоор бидэнд олдоод буй баримтаас харахад Их Монгол улсын цэрэг 9 төрлийн охор зэвсэг, 5 төрлийн уртын зэвсэг, 1 төрлийн хориглолтын зэвсэг, мөн дарьт, галт зэвсэг гэх мэт нийт 16 төрөл, хэлбэрийн зэвсэг хэрэглэж байв. Мөн нийт 15 төрөл, хэлбэрийн байлдааны хэрэгсэлтэй байжээ[33]. Тэдгээрийн дотроос монгол цэргийн агсамжийг бүрдүүлэгч гол зэвсэг нь нум сум, байлдааны гол хэрэгсэл нь «зэвлэх морь» байсан нь С.С.Уолкерын өгүүлсэнчлэн «галын хүч» (харьцангуй алсаас харвах харваа) хийгээд дайралтын хүчийг хавсрах, ээлжилж цохилт хийх боломж олгож[34], тэр нь гагц шигүү жагсаалаар буюу бөөн хүчээр түрэх дайралтын хүчинд дулдуйдаж асан дайснуудаа ямагт бага хохиролтойгоор ялан дийлэх нөхцлийг бүрдүүлж өгдөг байв.

Тийнхүү гол зэвсэг нь ойрын зайд шууд тулгаран байлдах илд, жад зэрэг охор зэвсэг бус, харин алсын зайнаас харвацалдан тулалдахад зохицсон нум сум байж, байлдааны гол хэрэгсэл нь явган цэргийнх лүгээ адил бие хамгаалах хуяг дуулга бус, харин салхи исгэрүүлэн давхих хүлэг морьд болж байсан учраас монгол цэргийн тактик нь хувьсахуй хөдөлгөөнд

үндэслэсэн «манёврын тактик» байж, цэрэг нэг бүрийн агсамж нь ч түүнд зохицсон хөнгөн агаад уян хатан чанартай зүйлсээс бүрддэг байжээ.

Түүнээс гадна цэрэг дайчдын биедээ агсаж асан нум сум, илд жад, хуяг дуулга, бялуу шийдэм зэрэг зэвсгийг оролцуулаад агсамжийн нийт жин дунджаар 25-30 кг-аас хэтрэхгүй байсан нь цэрэг дайчдын байлдах чадварыг үл алдагдуулах зорилгоор хүн нэг бүрийн агсамжид тавьдаг орчин үеийн шаардлагад хүртэл нийцэж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Мөн зөвхөн зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл ч төдийгүй, ерөөсөө агсамжийг бүрдүүлэгч бүхий л зүйл, аяны хүнс нь хүртэл нүүдэлчний өвөрмөц технологиор бүтээгдсэн агаад монгол хүний физиологийн шинж чанар, амьдралын хэвшилд нийцсэн, аян дайны хэрэгцээг бүрэн хангаж, хамаг л хүнд бэрхийг аль болох зүдэргээгүй, хохирол багатайгаар даван туулах шаардлагад зохицсон байсан нь Их Монгол улсын цэрэг армийн «амьдрах чадвар»-ыг тухайн үеийн бусад улс орны цэргээс илүү байлгах нөхцлийг бүрдүүлж байжээ.

Гүюг хаан, Бат ханы харилцаа

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, доктор, профессор Х. Шагдар

Эл хоёр түүхэн бие хүний харилцаа нь 1235 онд Хархоринд болсон Их эеийн шийдвэр ёсоор Дорнод Европыг дайлах их цэрэг 1236 оны хавар Булгар улсын хил дээр хүч хуралдуулсан үеэс түүхэнд тэмдэглэгдэх болжээ.

Янз бүрийн сурвалжийн мэдээгээр тэнд 13 хан хөвгүүн цэрэг жолоодон цугларсаны дотор Гүюгийн захирсан Монгол орны гол цэрэг, Мөнхийн захирсан монгол цэрэг, Байдарын захирсан Сартуул орны цэрэг, Батын захирсан өрнө дахины цэрэг, нийтдээ монгол - 5, түрк - 7 түмэн цэрэг хуралдуулжээ[35].

Энэ цагаас эхлэн Гүюг хааныг таалал төгсөх хүртэл тэр хоёр хааны харилцааны утга учрыг тайлахын тулд бие биеэс ургасан цуврал хэдэн асуултанд хариулах хэрэгтэй болно. Үүнд:

Асуулт 1. 1236 онд тэд хэн байв аа?

Гүюг (1206-1248). Их Монгол улсын хаан Өгэдэй, хатан Даргөнийн ууган хүү 30 настай, 1233 оны хавраас Алихай жанжны хамт мордож, Ваньну жанжин Алтан улсаас тусгаарлан 1214 онд Ляодунд байгуулсан зүүн Ся (Дунся) улсыг байлдан мөхөөж[36] Алтан улсыг мөхөөх дайны стратегийн нэн чухал зорилтыг хэрэгжүүлж ирсэн буюу «буунд мөрөө холгож, булшинд нөхрөө орхиж» үзсэн хан хүү байв.

Бат (1208-1256). Эцэг Зүчийн таалал төгссөний дараагаар Чингис хааны зарлигаар 19 настайдаа Зүчийн улсыг захирах болсон, Гүюгээс 2 насаар дүү буюу 28-тай, улсынхаа монгол, түрэг холимог цэргийг захирч байв.

Тэрээр Зүчийн хоёрдугаар хөвгүүн, Хонгирадын Уги нэрт хатнаас төрсөн хүү байлаа[37].

Асуулт 2. Зүчийн хоёрдугаар хүү атлаа улсын жолоог Бат залгамжилсны учир юунд орших вэ?

1. Түүний ах Орд нь ойрад (Сарт гуа) эхтэй, Бат хонгирад эхтэй байв. Хиад боржгинууд хонгирад, олхонууд аймгаас албан ёсны эхнэрээ авдаг уламжлал тогтоод байсан тэр үед Ордын эх нь татвар эхнэр, Уги нь авааль эхнэр байсан учраас Чингис хаан Батыг сонгосон бололтой. Тухайн үед товойн тодорсон гавьяа Батад байсангүй. Үүнээс өмнө 1230 онд Өгэдэйн цэрэгт Алтан улсыг байлдаж явсан сурвалжийн мэдээ[38] байдаг боловч энэ нь

1. Хятад сурвалжаар батлагддаггүй.

2. Өгэдэй хаан баруун хил нутгаа кибчагуудад нээн өгч, Батыг татан авах ёсгүй юм.

1230 онд Өгэдэй хаан Алтан улсыг дайлах гурван замын цэргийг арай ядан бүрдүүлж, хоорондоо хэдэн сар, бараг жилийн зайтайгаар мордуулж байсан түүхэн нөхцөл байдлаас үзвэл Батыг татан авсан байж болох боловч Өгэдэй хааны энэ удаагийн довтолгоон ямар ч үр

дүнд хүрээгүй, Багад цэргийн гавьяа байгуулах боломж байгаагүй билээ. Харин тэрбээр улсынхаа баруун хилээс кибчаг, аланчуудад үе үе довтлон тэдний аюулыг холтгох арга хэмжээ авч байсан юм.

Асуулт 3. Өгэдэй хаан яагаад олон хан хөвгүүдийг энд цуглуулав аа?

1. Сартуул, Тангууд, Алтан улсыг мөхөөсөн дайны дараагаар язгуур монгол цэргийн нөөц хомсдож, залуу хан хөвгүүдийн эзэмшил, захиргааны цэрэг л үлджээ.
2. Алтан улсыг мөхөөсний дараагаар Сүн улстай дайтах шаардлага ургаж байсан тэр үед баруун хилийн аюулгүй байдлаа хангахын тулд хамаг нөөцөө шавхан Европын дайныг богино хугацаанд дуусгах хэрэгтэй байлаа. Үүний тулд хан хөвгүүдийг дайчлав.
3. Чингис хааны дөрвөн хөлөг баатар, дөрвөн ноход, хоёр манлай зэрэг Их Монгол улсыг байгуулах, түүний гадаад аюулгүй байдлыг хангах тэмцэлд шалгарсан туршлагатай жанжнууд байлдааны талбарт ч, ертөнцийн жамаар ч үрэгдэж хорогдсоор гагцхүү 65 настай Сүбэдэй баатар үлджээ. Дорнод Европын домог болсон эл хосгүй жанжны цэргийн урлагийг хан хөвгүүдэд өвлүүлэх хэрэгтэй байв.
4. Их Монгол улс, Монголын эзэнт гүрний жолоон дээр сууцгаах эдгээр хан хөвгүүдийг үхэл, сэхлийн зааг — дайны талбар дээр ижилдүүлэн барилдуулах алсын бодлогыг ч Өгэдэй хаан өвөрлөн байсантай холбоотой биз ээ.

Асуулт 4. Хан хөвгүүдийг Батаар толгойлуулсны учир юунд орших вэ?

1. Тэдний дотроос хамгийн түрүүнд улсын хан болсон нь Бат.
2. Гүюг, Мөнхийн толгойлсон монгол цэргүүдийг хэзээ ч татан авч, зүүн (Хятадын) фронтод хаяж болзошгүй тул тэднээр баруун фронтыг толгойлуулж болохгүй.
3. дорнод европ руу Их цэргийн цөмрөн довтлох бэлтгэл ажил, бүх төрлийн хангалтыг Батын улс хариуцна.
4. Бат Их Монгол улсын баруун хилд сууж, 1223 оноос Сүбэдэй баатрын тогтоосон тагнуул, хяналтын сүлжээг ашиглан Европын цэрэг-улс төр, газар орны мэдлэгийг хуримтлуулсан.
5. Дорнод Европт нээсэн фронт нь Батын газар нутгийг өргөтгөж, түүний баруун хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилготой учраас Бат үхэн хатан зүтгэх ёстой зэрэг цэрэг, эдийн засаг, стратеги, сэтгэл зүйн олон талт нөхцөл хүчин зүйлийг харгалзан Батыг томилжээ.

Асуулт 5. Дайны талбарт Бат, Гүюг хоёр юуны учраас муудалцав аа?

Зүүн хойд Оросыг «нүд ирмэхийн зуурт» дайлж дуусгаад 1238 оны зун Бат цэрэг морио амраан Өмнөд Оросыг сөгтгөх бэлтгэлээ хангах зуурт ялалтаа тэмдэглэн хуримлажээ.

Хурим дээр Ц.Дамдинсүрэн гуайн «Нууц товчоо»-гоор бол Бат «бүх хан хөвгүүдийн ахмад

тул»[39], Ш.Гаадамбынхаар бол «эд бүх хан хөвгүүдийн ахахан болугсан болжу»[40] нэгэн хоёр аяга сархад тэргүүлэн тогтоосон байна. Ийнхүү ахас ихэсээ хүндлээгүйд эгдүүцсэн Бүри ам нээж, улмаар Гүюг, Аргасун нар Батад гашуун үг шидэлж, найрыг орхин гарчээ.

«Зөрчлийн онол»-оор бол энэ хэрүүлийн зангилаа амархан тайлагдана. Дашрамд өгүүлэхэд, ХХ зуунд Монголын утга зохиолд орж ирсэн социалист реализм Монголын түүх бичлэгт сүүдрээ тусгах болжээ. Эерэг, сөрөг дүр бүтээн зөрчлийг нь шийдвэрлэдэг соцреализмын аргыг Монголын зарим түүхч, зохиолч шүүрэн авч, бодитой бодигүй, санаатай санамсаргүйгээр дэвэргэснээр Монголын түүх чамлахааргүй олон зөрчилтэй болжээ.

Түмэн шаньюй-Модуны зөрчлөөс авахуулаад бидний сайн мэдэх болсон Тэмүүжин-Бэгтэр, Тэмүүжин-Хасар, Тэмүүжин-Жамуха, Тэмүүжин-Зүчи, улмаар Цогт-Лигдэн, Халх-Ойрад, Занабазар-Галдан бошигтын зөрчил гэх мэт олон зөрчлийг нэрлэж болно.

Миний өгүүлэн буй сэдэв дээр «Зөрчлийн онол»-ыг буулгавал: Зүчи-Цагадайн зөрчил, түүний сүүдэр нь Бат-Гүюгийн зөрчил, улмаар Тулуй-Өгэдэйн удмын хоёр талцсан зөрчил, эцэст Эзэнт гүрний сүйрэл гээд л цэг тавьчихна.

Тэгвэл Бат-Гүюгийн сөргөлдөөнийг арга зүйн өөр барилаар, тухайлбал тэр явдлыг түүхэн цаг хугацаа, орон зайнд нь, дундад зууны монголын нийгмийн хөгжлийн түвшин, монголчуудын сэтгэлгээ, зан суртахууны үүднээс авч үзэж болох юм. Тэгвэл:

1. «Монголын нууц товчоо»-нд тэмдэглэснээр Тэмүүжин Жүрхэний хурим дээр найрын сөнг жүрхэний нас өндөр хатан Эбэхэйд эхлэн бариагүйгээс будлиан үүсч, тэр нь цуст мөргөлдөөнд хувирч байв. Дараагийн удаад Батын цэргийн хурим дээр Аргасун, Гүюг нарын ахмад настанд түрүүлэн дарс сөгнөөгүйгээс болж хурим таржээ. ХШ зууны монголчуудын ёс заншил нь хууль байсан байна. Энэ үүднээс харвал Бат ёс алдан, хууль зөрчжээ.

2. Үүнийгээ Бат Өгэдэй хаанд тайлбарлахдаа хан хөвгүүдийн дотроос анхны улсын хан буюу ахахан болсны хувиар ганц-хоёр хундага түрүүлэн тогтоосон гэжээ. Энэхүү «ахахан» гэдэг үгийг Ц. Дамдинсүрэн аругайн «Монголын нууц товчоо»-нд «ахмад» гэж авснаар гадаад дотоодын судлаачид «Бат бол бүх хан хөвгүүдээс насаар ах байсан» гэдэг утгаар ойлгож бичсээр ирсэн юм. Гэтэл «ахмад» гэдэг үг «Монголын нууц товчоо»-нд ганц ч байхгүй. Бат тэднээс түрүүлж хундага тогтоохдоо: 1. Бусад хан хөвгүүдтэй жишвэл би улсын хан хүн. 2. Бас тэдний ахлах буюу ерөнхий командлагчийн хувьд түрүүлж сархад өргөх ёстой хэмээн бодож байснаа Өгэдэй хаанд уламжлан өчжээ.

Үнэхээр Батад улс төржсөн буюу биенээ гоочилж гутаах, доромжилж гомдоох хар хорын бодол байсангүй. Мөн Гүюг тэргүүтэнд ч бас ийм бодол байсангүй. Дайсны хүрээлэл дотор эв эе, заль ухаанаа л зангидаж явах ёстойг хэн хэн нь сайтар ойлгож байв. Ахуй, ёс заншлын нэгээхэн гажуудал нь бүр улс төрийн гомдол хорсолд ч хүргэж болдог, тухайн цаг үеийн нүдээр харвал найрыг орхидог ахмад настнууд, эхний хундага тогтоодог ерөнхий командлагч-улсын эзний аль алиных нь зөв болж, алдаа оноо нь тэглэх байна. Үүний учрыг арай тодруулж хэлбэл, Гүюг-Батын маргаанд овог аймгууд хүрээний зохион байгуулалтаар амьдарч байсан нийгмийн хуучин ёс заншлыг Гүюг барьж, бие даасан хант улсын тэргүүний сүр жаягийг Бат баримталсны зөрчил, мөргөлдөөн болохоос биш, Бат, Гүюг хэмээх хоёр хүн улс

төр болон хувийн атгаг санаа, зан араншингийн үүднээс мөргөлдөөгүй байна гэсэн дүгнэлтэнд хүргэнэ.

Ийм дүгнэлтийг тэр хоёрын цаашдын харилцаа ч батламжилж байдгаас жишээ татвал:

1. «Хээрийн үйлийг хээр» гэсэн монголчуудын гайхамшигт зарчмаар Бат өөрөө Гүюгийг дураар шийтгэх атал Өгэдэй хаанд илгээсэн нь хэмжээгүй эрхт хаант төрөө хүндэтгэсэн, улсын болон фронтынхоо эв эгнээг сахисан хашир хэрсүү бодлого мөн. Нөгөө талаар Бат өөрийн зохих хувийн бурууг хаандаа айлтгаж уучлалт гуйх мэт ээ.

2. Өгэдэй хаан Гүюгийг шийтгэх хэргийг Батад даалган буцаасан. Бат түүнийг зүүн гарын цэргийн албан тушаалаас нь буулгаж, цэргийг нь баруун гарын Мөнхийн захирсан монгол цэрэгтэй нийлүүлэн Хадаанд захируулснаар Эстергомын операцид энэхүү зүүн замын монгол цэргийг Сүбэдэй, Хадаан хоёр толгойлон мордсон билээ. Эстергомын операцид Гүюг, Бүри нар оролцоогүй, «Монгол руу буцсан»[41], «Монголдоо ихэд хилэгнэн буцсан»[42] хэмээн түүхч, нийтлэлчид үүнийг Бат европоос цэргээ татан буцсан нэгэн шалтгаан хэмээн нөгөө л «зөрчлийн онол»-оор тайлбарласаар байна.

Гэтэл Гүюг, Бүри нар ард үлдсэн ба Батын цэрэгт дахин элсэн явсан алин болох тухай түүхийн олигтой баримт нотолгоо олдохгүй байгаа юм.

1237 оноос Хятадын буюу зүүн фронтыг Өгэдэй хаан стратегийн хориглолтод шилжүүлсэн тул Европоос цэрэг шилжүүлэн татах шаардлага байгаагүй зэргээс Гүюг Европын дайнд явсан, явах явахдаа Сүбэдэй, Хадааны зүүн замын цэрэгт явсан гэх таамаг гарна. Ийнхүү Бат хан Гүюгт асар өндөр өршөөл үзүүлсэн, нэг ёсны нүглээ наминчилж байгаа мэт дүр зураг эндээс харагдана.

Бүри ч ялгаагүй Байдарын захирсан Цагадайн улсын буюу «Сартуул орны» баруун замын цэрэгт явж Европын дайнд орсон биз. Тиймээс Бат, Гүюгийн зөрчил нь Европоос монголын цэргийг эргүүлэх шалтгаан огтхон ч бус, өөр учир холбогдолтой байсан юм. Бат европоос буцах зөвлөлгөөнөөр гурван асуудал шийдвэрлээд буцахуйн шалтгааныг «Кибчагийг мөхөөсөн тул»[43] хэмээн тов тодорхой томъёолсон юм. Үнэхээр Батын цэрэг нь кибчаг, түүнийг орогнуулсан Польш, Унгарыг дарснаар операцийн зорилгоо бүрэн хангаад эргэж төвхнөсөн билээ.

3. Гүюгийг хаан ширээнд залах хуралдайд Бэрх тэргүүтэй дүү нараа илгээж «хөл өвчтэй» шалтгаанаар Бат ирээгүй нь:

- Дөргөнэ хатны үйл ажиллагаанд зэвүүцсэн хийгээд Гүюгтэй түнжин хагарсан.
- Эзэнт гүрний баруун хилийн аюулгүй байдлыг хуралдайн үеэр сахиж байх зорилготой холбоотой байсан биз ээ.

4. Бат ямагт Эзэнт гүрний хэмжээнд сэтгэдэг, эе эв, Алтан ургийн бодлогыг тууштай баримталдаг хаан байсан учраас Гүюгийн хаан ширээнд байх үед нэн хорон бодлого баримталж байгаагүй бололтой байдаг. Плано Карпинигийн аяллын тэмдэглэлүүд тийм

сэтгэгдэл төрүүлдэг.

Гэвч Гүюг, Бат хоёр гадны хорон бодлого, дарамтын дор амьдарч байв. Гүюгийн эхийг «Батын туршуул хорлосон»[44] гэхээс авахуулаад худал хуурмаг мэдээлэл, хов жив, өдөөн хатгалга тэр хоёрын дундуур тасралтгүй сүлбэлдэж байснаас Гүюг дотроо сэжиглэн, Батыг шууд өдөхгүйгээр турших, бас тэр цэрэглэн ирвэл ашигтай байрлал сонгох далд бодлогоор цэргээ авч, Эмил, Долоон гол тийш хөдөлсөн болов уу.

Гүюгийн мордохыг Батад «сэрэмжтэй бай»[45] хэмээн Сорхугтани хатан хэл хүргэснээр Бат мордсон байна. Тухайн цагийн байдал, зарим түүхчийн бичихээр, Гүюг Самарканд орчимд ирээд байхад Бат Алатау уулын бэлд ирээд байсан нь үнэн бол Бат ганц үсрэлтээр Их Монгол улсын цэргийг ороон бут цохих бололцоо нээгдсэн байжээ. Мөн л Эзэнт гүрний эрх ашиг, эе эвийн бодлогын үүднээс Бат цэргээ татсанаар Бат, Гүюгийн харилцаа цусан далайд живэлгүй, бие биеэ харж тандсан, эмээж жийрхсэн, ивээл өршөөл горьдсон дүртэй хоёр «чулуун хөшөө» мэт түүхэнд үлдэн хоцорчээ.

Энэ бүхнээс дараах дүгнэлт гарч болно:

Нэгд, миний өгүүлэн буй «зөрчлийн онол» гэгчийн үндэс нь Гегель, Энгельс, Лениний боловсруулсан «эсрэг тэсрэгийн нэгдэл, тэмцлийн хууль» юм. Энэ бол байгаль, нийгмийг танин мэдэхүйн тухай хууль мөн боловч түүхийн шинжлэх ухаанд түгээмэлээр хэрэглэх нь тэр бүр зохимжгүй байна. Монголын түүхийн тухайд түүнийг түгээмэл хэрэглэх нь «тамын тогооны үлгэр» гэгчийг баталгаажуулж, тэр нь бүр амьдралын хэв маяг байх ёстой гэсэн ухаарлыг хойч үед төрүүлэхэд хүргэж байна. Жишээлбэл, ном уншихаа больж, телевизийн киногоор сэтгэх болсон өнөө үед «Мандухай цэцэн хатан» киногоор халх, ойрадын харилцааг төлөөлөх болсон байна. Амарсанаа вангийн ясыг монгол нутагт нь оруулж ирж чаддаггүй юм аа гэхэд оршуулсан цэгийг нь мэддэг хүн байгаа дээр тэр газрыг тэмдэглэмээр байна гэхэд хөдлөх хүн олдохгүй байна. Зүүн гарын хаант улсын түүхийг монголын түүхийн хэсэг бус гэж үздэг эрдэмтэнтэй тааралдах болжээ. Энэ нь үзэгдэл, үйл явцын дотоод зөрчлийг өнгөцхөн гаргаад, гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг орхигдуулсны харгай юм. Марксизмын гүн ухаанд энэхүү дотоод зөрчлийг шийдвэрлэх арга нь аль нэг талыг нь заавал ялуулж, нэгийг нь газрын гавд булж, нөгөөг нь тэнгэрийн зулайд залснаар төгсдөгийн харгай юм.

Тиймээс түүхч бид энэхүү «зөрчлийн онол»-ыг хэрэгцээт газар нь хэмжээтэй хэрэглэж байхыг монголын түүх бидэнд сануулж байна. Эс тэгвээс монголчуудын нийгмийн сэтгэл зүй, үндэсний ухамсарт сөргөөр нөлөөлөх, түүхэн үнэнийг гуйвуулах хандлага гарч болзошгүй байна.

Хоёрт, «Зөрчил»-ийн аргаас арай ангид авч үзвэл:

· Бат ханы хэлсэн үгийг «ахмад» бус, «бүгдийг ахлах» буюу «бүгдийн захирагч» гэдэг утгаар орчуулж, хэрэглэхийг «Монголын нууц товчоо» судлал нотолж байна.

· Оросын тал нутгийн хурим дээр гарсан Гүюг, Батын сөргөлдөөн нь бие хүмүүс хоорондын бус, нийгмийн шинэ, хуучны хоорондын зөрчил байжээ гэж үзнэ.

Гуравт, Монголын болон дэлхийн түүхэнд Бат ханы оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурийг бодитоор, нуруу төвшин үнэлэх ёстой. Буйлмал улс төрч, буурьтай жолоодогч, Эзэнт гүрний эв нэгдлийн бодлогыг туглан өргөгч, Хубилай хаанаас хол дутуугүй эзэн хаан байсан гэдгийг түүний үндэслэн байгуулсан Алтан ордон улсын урт нас тод илтгэнэ.

Харин жанжны нь тухайд бол аливаа жанжныг эзэлсэн газар орны эн хязгаар төдийгүй, хэрэгжүүлсэн операцийн хэмжээ далайц, ялалтын тоо, жанжин хүнд байвал зохих шинж чанар зэрэг цогц хэмжүүрээр тодорхойлох шаардлагатай төвөгтэй асуудал юм.

Гэлээ ч Бат нь Чингис хаан өвөө, Сүбэдэй, Мухулай зэрэг дэлхийд энгүй жанжнуудын сүрд дарагдах болохоос бус муугүй жанжин явжээ.

Бат хан ба Оросын шинэ түүх бичлэг

~~МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхим, дэд доктор, дэд профессор Чойжилжавын Чойсамба~~

Бат ханыг хамгийн учир битүүлэг байлдан дагуулагчдын нэг гэж хэлж болно. Ямар ч нэвгэрхий толиноос түүний тухай лавлаж сонирхоход Чингис хааны ууган хөвгүүн Зүчийн хоёрдугаар хүү, Алтан Ордны улсыг үндэслэгч, Орос ба Европт түрэмгийлсэн Монголын их цэргийг удирдагч гэхээс өөр дорвитой зүйл олж уншихгүй.

Батын нэр Чингис хаан, эсвэл Мөнх, Хубилай, Хүлэгү нарын нэрсийн дэргэд бүдгэрч харагддаг. Гэвч түүний хийсэн бүтээснийг үнэхээр гайхан биширмээр. 19-хөн настайдаа эцгийнхээ улсыг өвлөж, 27-тойдоо их аян дайныг толгойлж, 35-тайдаа өөрийн их гүрнийг төвхнүүлсэн тэрээр Монголын үе үеийн хаад дотроос сод ухаан, авьяас билгээрээ тэгширсэн нэгэн байв. Тиймдээ ч тэрээр ард иргэдийнхээ хайр хүндэтгэлийг хүлээж, түмнээ «Сайн хаан» хэмээн алдаршсан билээ.

Харамсалтай нь Батын хүүхэд ахуй болон залуу насны тухай ямар нэг баримт мэдээлэл хадгалагдан үлдээгүй юм. Түүний тухай ихэнх мэдээллийг зөвхөн өөртэй нь дайсагнаж байсан улс үндэстнүүд бичиж үлдээсэн бөгөөд Батын намтар гээд хэлчих бүтээл нэг ч үгүй. Гэтэл Бат ханаас зиндаа хавьгүй доогуур Их Карл, Салах ад-Дин, Арслангийн зүрхт Ричард, тэр ч байтугай балмад Кортес, Писарро нарын тухай хүн төрөлхтөн хавьгүй ихийг мэдэх бөгөөд тахин шүтдэг.

Бат ханы тухай яагаад туйлын хомсхон мэдээлэл уламжлагдан ирэв? Яагаад Бат ханы намтраа байг гэхэд түүний тухай дэлгэрэнгүй өгүүлсэн бүтээл бичигдсэнгүй? Бат ханы тухай мэдээлэл яагаад эрс тэс, зөрчилтэй байдаг вэ?

Энэ бүх асуултанд хариулахад тийм ч хүндрэлтэй биш. Монгол, Хятадын албан ёсны эх сурвалжуудад Батын тухай дурдах төдий өнгөрсөн байдаг. Энэ нь ч аргагүй юм. Өгэдэй хааныг даган Хятадад дайтахдаа Бат ямар нэг гарамгай үйл байгуулж амжаагүй. Харин Өгэдэйг нас барснаас хойш Бат Их Монгол улсаас салан тусгаарлагч, их хаадын сөрөг хүчин болж хувирсан байжээ. Тиймээс монгол, хятад түүхчид Бат ханы тухай дурдалгүй тойрон өнгөрч байв.

Бат ханы түрэмгийллийн дараа түүний тухай бичиж байсан Орос, Европын түүхчид юу туурвисныг таахад тийм ч хэцүү биш. Батыг цусанд дуртай, улангассан, зэрлэг, бүдүүлэг араатан, алуурчин гэх зэргээр нэг хүнд байж боломгүй муу муухай чанарыг түүнд нялзааж, дайрч давшилсан байдаг. Оросын хожуу үеийн түүхчид ч Бат ханыг ийм л маягаар дүрсэлсэн байдаг.

Бат хан Зөвлөлт, Оросын түүхчдийн анхаарлыг үеийн үед татсаар ирсэн нь зүй ёсны үзэгдэл юм. Энэ илтгэлдээ бид Бат хан, ер нь монголчуудын тухай Оросын шинэ түүх бичлэгт хэрхэн өгүүлсэн тухай тогтож ярихыг зорилоо. Тэгэхэд: нэгдүгээрт, Бат ханы аян дайны цар хүрээг хэт явцууруулах; хоёрдугаарт, түүхийг хуурмаг учир зүйд тулгуурлаж, мөн хувийн үзэмжээрээ хэт гуйвуулах хандлага түгээмэл ажиглагдаж байна.

Батын аян дайны цар хүрээг явцууруулах хандлага Баруун зүг дайлаар мордсон түүний цэргийн тооноос шууд хамааралтай. Хэрэв хувьсгалын өмнөх үеийн Оросын түүхчид Оросод халдсан монгол цэргийн тоо 300 мянгаас дутуугүй байсан гэж үзэж байсан бол социализмын үеий түүхчид ихэвчлэн 120-150 мянга гэсэн тоог заадаг. Тэгвэл сүүлийн жилүүдэд Оросын шинэ үеийн түүхчид энэ тоог хэд дахин, тэр ч байтугай хэдэн арав дахин бууруулжээ.

Тухайлбал, Константин Пензев «Оросын хаан Батый» өвөрмөц бүтээлдээ Оросын ванлигууд руу 2-3 мянган морин цэрэг, 5 мянга орчим явган цэрэг хөдөлсөн гэж бичсэн юм[46]. Үүнийгээ тэрээр хэд хэдэн үндэслэлээр тайлбарласны нэгийг нь сонирхон үзвэл: «Бат аян дайнд мордохынхоо өмнө морьдоо тахлах хэрэгтэй байсан. Хэрэв тэд (түүхчдийн заадаг 30 мянган монгол цэрэг — Ч.Ч.) наанадаж хос морьтой хөдөлсөн бол энэ нь 60 мянган адуу, 240 мянган тах, 1 сая 920 мянган тахны хадаас гэсэн үг. Өөрөөр хэлбэл Ижил мөрний доод хөвөөгөөр Бат 1237 он гэхэд төмрийн хүдэр, нүүрс, төмрийн дархны газар, ажиллах хүч гээд үйлдвэрлэлийн хүчирхэг баазтай болчихсон байх шаардлагатай.

Тэр хэзээдээ энэ бүхнийг амжуулчихаа вэ? Хэн түүнд туслав? Хаанаас төмөр олов? Төмрийн дархны газарт зориулж хаанаас нүүрс авчрав? Тах, хадаас бэлдээд морь тахлахад дор хаяж гурван цагийн ажил орно. 60 мянган адууг тахлахад 180 мянган ажлын цаг шаардагдана. Хэрэв төмрийн дархан өдөрт 12 цаг ажиллана гэж бодвол нэг өдрийн дотор ердөө дөрвөн адууг л тахалж чадна. Амралтгүй ажиллаад нэг сард 120 орчим адууг тахална. Тэгвэл 60 мянган адууг нэг сарын дотор тахлахын тулд дор хаяж 500 төмрийн дархан, мөн тооны дагалдан шаардагдана. Төмрийн дархны 500 газар гэдэг их үү, бага уу? /.../ Ямартаа ч 1625 оны байдлаар Оросын том хотод төмрийн дархны 15 газар байсан гэсэн баримт бий. Тэгэхээр төмрийн дархны 500 газар бол 1625 оны загварын Оросын 33 том хоттой дүйх юм. Тэгвэл Батад Каспий орчмын тал газар ийм нөөц яавч байгаагүй.

Морины тах, хадаас нь 4 кг орчим жин татдаг. 60 мянган адууг тахлахын тулд наанадаж 240 тонн төмөр шаардагдана. Энэ 240 тонн төмрийг Бат хаанаас олсон нь түүхэн оньсого юм. Монголчууд өөрсдөө төмөр үйлдвэрлэдэггүй байсныг бодолцох хэрэгтэй. /.../

Тиймээс Бат Оросод өвөл халдахдаа маш хязгаарлагдмал тооны цэрэгтэй байсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй юм»[47].

Хэрэв Баруун зүг ердөө 7-8 мянган монгол цэрэг хөдөлсөн юм бол тэд ямар ч гарамгай дайчид байсан Оросыг байлдан дагуулж, улс орныг нь тонон дээрэмдэж, эвдэн сүйтгэж чадна гэж үү? Тэгэхээр Монголын байлдан дагуулал гэж юм байгаагүй, оросуудыг монголчууд байлдан дагуулаагүй болж таарна.

Монголчуудын байлдан дагууллын цаг хүрээг хумих, үр нөлөөг нь үгүйсгэх хандлага Монголын түүх бичлэг дэх олон цагаан толбыг арилгасан нэрт эрдэмтэн Лев Гумилёвтой холбоотой нь хачирхалтай. Тэрээр «Эртний Орос ба Их тал» бүтээлдээ: «1240 онд Бат Владимир-Волынскийг цэргийн хүчээр авч, хүн ардыг нь хайр найргүй устгажээ... Ийм явдал Галичийн нутагт ч болсон юм. Тус нутагт энэ дайны үеэр 12 мянган хүн үрэгджээ. Энэ нь Липиц голын дэргэдэх тулалдаанд ганцхан өдрийн дотор амь үрэгдсэн хүний тоотой тэнцүү юм. Гэхдээ энэ нь Липицийн тулалдаанд алагдсан цэрэг эрсийн л тоо болохоос хүчиндүүлсэн эмэгтэйчүүд, тонуулсан хөгшид, өнчирсэн хүүхдүүдийн тоо хэдэд хүрснийг

хэн ч мэдэхгүй. Эдгээр баримтаас улбаалаад Батын аян дайн нь учруулсан хохирлынхоо цар хүрээгээр тэр амаргүй цаг үед энгийн үзэгдэл болсон хоорондын тэмцлээс гарсан дайнтай адил байсныг тэмдэглэх хэрэгтэй. Харин үлдээсэн сэтгэгдэл нь санаанд багтамгүй байсан юм»[48] гэж үнэлсэн байна.

(1216 оны гуравдугаар сарын 4-нд Липиц голын дэргэд болсон тулалдаанд новгородчууд Владимирын вант улсын цэргийг бут цохисон юм.)

Л.Гумилёвын дэвшүүлсэн санаа өмнөх үеийн Оросын түүхчдийн бичиж, нотолж байсан зүйлтэй эрс харшилж буй юм. Тэд нэгэн дуугаар: «Монгол-татарын түрэмгийлэл ба үүний үр дүнд бий болж, он удаан жил үргэлжилсэн харийн талхи манай орны үйлдвэрлэх хүчинд асар их хохирол учруулж, эдийн засаг, улс төр, соёл гээд бүхий л салбарын хөгжлийг урт удаан хугацаагаар хаан боогдуулсан юм /.../ Монгол-татарын феодалуудын байлдан дагуулал хүн төрөлхтөнд тоолж баршгүй их үхэл хагацал, эвдрэл сүйрэл, материаллаг ба соёлын үнэт зүйлийн мөхлөөс өөр юу ч авчраагүй болой»[49] гэж бичиж байсантай Л.Гумилёвын санааг харьцуулбал Монголын түрэмгийлэл ямар нэг сүртэй, ноцтой үр дагаваргүй жирийн нэг байдаг л халдлага байсан болж таарах нь.

Одоо монголчуудын угсаа гарал, үүх түүхийг Оросын шинэ үеийн «түүхчид» хэрхэн үзэж байгааг сонирхуулья.

«Ертөнцийн агуу нууц хийгээд оньсогууд» цувралын «Дорно дахины нууцууд» бүтээлд дэндүү хачин, жигтэй зүйл их бичигджээ. Монголын түүхийг хэрхэн эрээ цээргүй гуйвуулсан нь монголчууд бидэнд сонирхолтой санагдаж магадгүй гэж бодсон учир хэчнээн утгагүй байлаа ч үүнийг иш болгон авлаа. Тухайлбал: «XIII зуунд омгийн ахлагч залуухан, маш шаламгай Чингис хаан асар их цэрэг хуримтлуулаад “сүүлчийн далай” руу хийх алдартай аян дайнаа эхэлжээ. Тэрээр олон ард түмнийг байлдан дагуулж, 1237 онд өөрийн цэргийн хамт Орос орны нутаг дэвсгэрт нэвтрэн орсон юм. Түүний өв залгамжлагчид улам цааш явж, Баруун Европыг байлдан дагуулах гэж оролджээ. Гэхдээ Адриатын тэнгисийн эрэгт хүрмэгц ардаа үгүйрэн хоосорсон, гэхдээ өвдөг сөгдөөгүй Орос орныг орихоосоо айж, гэдрэг буцсан байна. /.../

Ингэхэд энэ харгис татар-монголчууд гэж хэн юм, татар дээр монголчуудыг нэмсэн энэ хачин цэргийн эвсэл ямар учиртай юм? Эртний судар бичгүүдэд монголчуудын тухай дурдсан өчүүхэн хэсгийг олох оролдлого анхнаасаа л нуран унана! Учир нь тэдний нэр ч олдохгүй, угаасаа ч байгаагүй! /.../

Домогт өгүүлснээр Чингис хаан өөрөө шаргал үстэй, хөх нүдтэй байжээ. /.../ Түүний удам Бат ч гэсэн монгол хүнтэй төсгүй, учир нь тэр үед амьдарч байсан хүмүүсийн бичиж үлдээсэн зүйлийг судалж үзвэл шаргал үстэй, шаргал нүдтэй нэгэн байсан гэдэг. Тэдний нэрс ч ойлгомжгүй, яагаад гэвэл Бат гэсэн нэртэй хүн монголчууд дотор байдаггүй! Харин башкирчууд дотор ийм нэртэй хүмүүс байдаг шүү! Тэр ч байтугай Чингис нэртэй хүн Монголд байдаггүй. Эндээс маш хялбар дүгнэлт урган гарна. Орос руу монголчууд биш, харин европчууд, славянуудаас нэг их ялгаагүй өөр ард түмэн халдсан юм. Тэгвэл бодит хэрэг дээр татар-монголчууд нэрээр Оросод хэн халдсан юм бэ? Монголын эзэнт гүрэн Сибирь, Алтай, Байгаль нуур орчны нутаг дэвсгэр дээр бүрэлдэн тогтсоныг бид мэднэ. Чухам Төв

Азиас нэгэн цагт Европ руу этрускууд, эллинчууд, славянчууд, вендууд нарын олон бусад үндэстэн их, бага нүүдлийн үеэр шилжин нутагласан юм»[50] гэсэн байдаг.

Энэхүү нууцуудыг «түүвэрлэсэн» А.Г.Ушаковын зорилго бол оросууд өөрсдөөсөө бүдүүлэг ард түмэнд эзлэгдээгүй, гагцхүү өөрсөдтэй нь адил зиндааны хөгжилтэй славянчуудад ялагдсан гэсэн санааг «чулуу болгох» явдал юм. Аанай л социализмын үе шиг түүхийг өөрт таалагдсанаараа бичих гэсэн санаархал нь харин ч өөрийнх нь тодорхойлсноор нуран унах тавилантай.

Сүүлийн жилүүдэд Оросод олноороо хэвлэгдэн гарч байгаа «өвөрмөц» номнуудаас дээрхийн зэрэгцээ Г.В.Носовский, А.Т.Фоменко нарын «Орос ба Орд. Бүгдэд зориулсан шинэ он дараалал» бүтээлийг дурдаж болно. Түүхийг шинээр бичих, гэхдээ өөрийн үзэмжээр бичихийг зорилго болгосон тэдний бүтээлээс нэгээхэн хэсгийг орос эхийнх нь хамтаар толилуулья:

«Задумаемся над происхождением названия МОНГОЛИЯ. Не исключено, что оно произошло от русского слова МНОГО, множество (людей), МНОГОчисленное войско. Возможно также, что слово МОНГОЛИЯ произошло от русского МОЩЬ, МОГ, МОГУщество»[51]—«МОНГОЛ гэдэг нэрний гарал үүслийг тунгаан эргэцүүлье. Энэ нэр ОЛОН, олон (хүн), ОЛОН цэрэг гэсэн орос үгнээс гаралтай байхыг үгүйсгэшгүй. Мөн МОНГОЛ нь ХҮЧ ЧАДАЛ, ЧАДАХ, СҮР ХҮЧ гэсэн орос үгнээс үүссэн байж болзошгүй».

Физик-математикийн ухааны доктор, шинжлэх ухааны докторын зэрэгтэй дээрх эрдэмтэд иймэрхүү маягаар, ямар ч үндэслэлгүй таамаглал дэвшүүлэх замаар түүхийг шинээр бичихийг санаархсан нь бүхэл бүтэн ард түмнийг доромжилсон увайгүй үйлдэл юм.

Оросын түүхийг цоо шинээр «биччихсэн» тэдний дэвшүүлсэн зарим нэг санааг тоймлон дурдвал Дундад зууны Монгол, Орос хоёр улс бол угтаа нэг гүрэн байсан, улмаар харийнхан Оросыг байлдан дагуулж байгаагүй, татарууд угаасаа л Оросын нутаг дэвсгэр дээр амьдарч байсан, түүх бичлэгт монголо-татарское иго буюу монгол татаруудын талхидал гэж тэмдэглэгдэн үлдсэн үе үнэн хэрэгтээ Оросын вант улсууд нэгдэн нягтарч, төвийн засаг хүчээ авсан үе байсан[52] гэнэ.

Ер нь аливаа үндэстний түүхийг бичихдээ наанадаж тухайн ард түмний хэлийг мэддэг байх, цаанадаж хүмүний хэм хэмжээнээс гажаагүй ёс суртахуунтай байх шаардлагатай санагдсаныг тэмдэглэмээр байна. Оросын шинэ үеийн «түүхчид» монголоор нэг ч үг мэдэхгүй байж Монголын түүхээс бичилцэж, МОНГОЛ гэдэг нэр оросын МНОГО гэх үгээс гаралтай гэж улайм цайм цэцэрхэхээр барахгүй, хамгийн аюултай нь аливаа асуудалд өөрийн явцуу хандлагаар хандаж байна. Өөрөө морь унаад хэдэн мянган километр туулж чадахгүй учир ерөөсөө ямар ч үндэстэн ингэж чадах учиргүй мэтээр бичиж байгаа нь нэн өрөвдөлтэй, бас эмгэнэлтэй. Энэ маягаар аливаа асуудалд хандах юм бол 2008 оны Бээжингийн Олимпийн найман удаагийн аварга, АНУ-ын тамирчин Майкл Фелпсыг ийм хүн байгаагүй, яагаад гэвэл хүн нэг Олимпоос ийм олон медаль авах боломжгүй гэх хуурмаг учир зүйг үндэслэл болгож үгүйсгэж болно.

Түүхийг «шинэчлэгчид»-ийн бичиж буйгаар, монголчууд Оросод халдаагүйгээр үл барам,

дэлхийн талыг байлдан дагуулж байгаагүй, юун дэлхийн тал, Чингис хаан Бээжинг эзэлж байгаагүй болж таарах нь. Хамгийн арчаагүй нь эдгээр санаагаа тэд ямагт хуурмаг учир зүйгээр тайлбарладаг. Тухайлбал, Ромын легионуд ингэж хол давшсан түүх үгүй, ийм байхад яахаараа монголчууд чаддаг билээ? гэсэн хандлагаар тэд аливаа асуудалд ханддаг. Тэгвэл XII Карл, Наполеон, Гитлер хэнд ч ялагдаж байгаагүй, тэгэхээр тэд яагаад Оросод ялагддаг юм? маягаар бид асуудалд хандвал дэлхий нийт хэрхэн хүлээж авах вэ?

Түүхийг шинээр бичих гэсэн өөр нэгэн бээр бол А.Бушков юм. Тэрээр «Алтан ордны сүүдэгнэл» бүтээлийнхээ гол санааг базан өгүүлэхдээ:

«1. Ямар ч “монголчууд” тал нутгаасаа ирж, Оросод халдаагүй.

2. Татарууд бол холоос ирсэн хүмүүс биш, харин өнөөх “түрэмгийлэл” гэгчээс б ү р ө м н ө (А. Бушков онцолсон — Ч.Ч.) оросуудтай хаяа нийлүүлэн аж төрж байсан Ижил мөрний хавь орчмын оршин суугчид.

3. Татар-монголчуудын түрэмгийлэл гэж нэрлэж байсан үзэгдэл бол үнэн хэрэгтээ Их үүр хочит Всеволод вангийн (Ярославын хүү хийгээд Александрын ач) үр угсаа нар Орос орныг ганцаарчлан захирахын тулд өөр хоорондоо өрнүүлсэн тэмцэл байсан. Улмаар Чингис хаан, Бат бол мөн чанартаа Ярослав, Невийн Александр юм»[53] гэсэн байдаг.

Энэхүү үндэслэлээ хэрхэн «баталгаажуулах»-аа А.Бушков дараах байдлаар тайлбарлажээ. Үүний тулд «Оросын олонх он дараалсан бичиг, эртний түүхчдийн бүтээлийг хянуур, дахин уншихад л хангалттай. /.../ Ердөө таван зуун жилийн өмнө Нар дэлхийг тойрон эргэдгийг хүн бүр л “мэдэж” байсан шүү дээ»[54].

Тэгвэл хянуур, дахин унших гэдэг үгийн цаана ямар санаа агуулагдаж байна вэ?

А.Бушков «Монголчууд хаана байна?» бүлэгтээ гурван жилийн өмнө А.Г.Ушаковын бичсэнийг хичээнгүйлэн хуулжээ. Тэрээр монголчууд гэж үндэстэн Оросод халдаагүй («Чи хагарч үхмээр байвал үх, гэхдээ л монголчууд гэж үндэстэн байгаагүй»), Чингис, Бат нар гадаад төрхөөрөө одоогийн монголчуудтай ерөөс төсгүй, монгол хэлний бүлэгт хамаарах нэг ч хэлэнд «Бат», эсвэл «Батый» гэдэг нэр байдаггүй гэх зэргээр мэдэмхийрсэн юм. Харин Бат ханы цэргийн тооны тухай өгүүлэхдээ К.Пензеваас будаа идсэн байна.

Ер нь энэ гурван зохиогчийн бүтээлүүд нэлээд этгээд хэллэгтэй болохыг тэмдэглэх хэрэгтэй.

Монголын түүхийг тун ч явцуу үүднээс дүгнэж, өөрийн байр суурийг нялзаасан А.Бушковын зарим санааг гаж гэж хэлэхэд ч багадана. «Салхи мэт эрх чөлөөтэй талын нүүдэлчид “сүүлчийн далай”-г хүртэл Чингисийн араас хүлцэнгүй нь аргагүй дагаж явсан гэдэгт биднийг итгэ гэх юм. Татгалзсан нэгэнд нь нөлөөлөх ямар ч боломж Чингис хаанд байгаагүйг зориуд тэмдэглэмээр байна. Мянга мянган километр тэлсэн тал нутаг, тайгаар тэдний араас хөөцөлдөх нь бүтэшгүй явдал шүү дээ.

Т а в а н м я н г а н (А. Бушков онцолсон — Ч.Ч.) километр. Түүхчдийн баримталдаг “сонгодог” хувилбараар Орос орон хүртэл Чингисийн цэргүүд чухам ийм зайг туулжээ.

Иймэрхүү юм бичдэг, тасалгаанаасаа ч гарч үзээгүй онолчид бодит хэрэг дээр энэ зайг туулахад ямар их хүч шаардагдах тухай ердөө ч бодож байгаагүй. Хэрэв “монголчууд” Адриатын тэнгист тулсан гээд бодвол дээрх зай 1500 километрээр уртасна. Талын нүүдэлчдийг ийм хол одоход ямар хүч, ямар гайхамшиг нөлөөлсөн болж таарах вэ?

Нүүдэлчин бедуинууд Өмнөд Африкийг байлдан дагуулахаар нэгэн удаа Аравийн талаас хөдөлж, Таатай найдварын хошууг хүрсэн гэвэл та итгэх үү? Аляскийн индианчууд тодорхой бус шалтгаанаар нутгаа орхиж, нэг сайхан өдөр Мексикт хүрээд ирж гэвэл итгэх үү?

Мэдээж, энэ бүхэн бол ёстой солиотой зүйл. Гэхдээ хэрэв орон зайг зэрэгцүүлбэл Монголоос Адриатын тэнгис хүрэхийн тулд Аравийн бедуинууд Кейптаун ортол, Аляскийн индианчууд Мексикийн булан хүрэх дайтай газар нутгийг “монголчууд” туулж байгаа юм. Гэхдээ зүгээр нэг яваагүйг онцлох хэрэгтэй. Замаараа Хятад, Хорезм зэрэг тухайн үеийн хэд хэдэн томоохон улсыг э з э л ж (А. Бушков онцолсон — Ч.Ч.), Гүрж, Оросыг түйвээж, Польш, Чехи, Унгарт түрэмгийлсэн гээд байгаа...

Тэгээд э н э б ү х э н д (А. Бушков онцолсон — Ч.Ч.) түүхчид биднийг итгэ гэх юм. Одоо яахав дээ, өөрсдийнх нь л хохь. Та нар хүмүүст тэнэг харагдахгүйн тулд тэнэг зүйл бүү хий. Энэ бол орчлонгийн энгийн үнэн хууль шүү дээ. “Сонгодог” хувилбарыг баримтлагч түүхчид өөрсдөө л доромжлуулах юмаа хийгээд байх юм даа»[55].

Иймэрхүү маягаар А.Бушков түүхийг өөрийн үзэмжээр шинэчлэн бичжээ. Түүний бичсэнээр, Бат бол «зохиомол дүр», «оргүй худал зүйл», бодит хэрэг дээр Ярослав, Александр ванг Бат хэмээн нэрлэсэн, Батын аян дайн гэгч нь үнэн хэрэгтээ Ярослав, Александр хоёроос дайснуудтайгаа хийсэн тэмцэл гэнэ[56]. А.Бушковын цэцэрхлийг хязгааргүй үргэлжлүүлж болно.

Түүний өөр нэг «бүтээл» болох «Их гүрний зэрэглээ» мөн л хуурмаг учир зүйн туйл болжээ. Тухайлбал, Монголын эзэнт гүрний нийслэлийг Каракорум (Хархорин) гэдэг байсан, энэ бол монгол бус, харин түрэг үг, монголчууд яахаараа нийслэлээ түрэг үгээр нэрлэдэг юм, тэгэхээр Каракорум бол Монголын хот биш гэсэн хосгүй «дүгнэлт»-энд хүрчээ. Энэ санаагаа цааш дэлгэрүүлж «”Кара” гэдэг нь түрэгээр “хар” гэсэн үг. Харин “Корум” гэдэг нь “Кырым” гэдэг үгтэй дуудлагаараа маш адилхан. Кырым гэдэг чинь ... Крым шүү дээ! Энэ бол Кара-Кырым хот мөн»[57] гэж хөөрөн цэцэрхэж, энэ хот Крымд байсан байж таараа гэжээ.

Энэ учир зүй ямар ч үндэслэлгүй болохыг бид дараах жишээнээс харж болно. Хэрэв хотын нэрийг гуйвуулж түүх бичиж болдог юм бол «Москва» гэдэг үг орос хэлэнд байдаггүй, энэ бол монгол хэлний «мушгиа» гэсэн үгнээс гаралтай нэр, тэгэхээр Москва бол Оросын нийслэл биш, харин эрт цагт монголчуудын аж төрж байсан хязгаарын нэг хот гэж бид бичиж болох нь. Аз болоход монголчууд дотор ийм сохор ухаанаар асуудалд ханддаг түүхч байтугай, жирийн иргэн ч үгүй.

Бат бол Оросын Ярослав ван гэсэн санааг Г.В.Носовский, А.Т.Фоменко нар ч дэвшүүлсэн байдаг. Невийн Александр нь Бат ханы өргөмөл хүү байсан гэсэн яриан дээр үндэслээд тэд Бат бол Ярослав мөн гэж үзжээ[58].

Дашрамд хэлэхэд, дундад зууны үеийн Оросын түүхийг ул суурьтай судалсан И.Н.Данилевский Александр ван Батын өргөмөл хүү байсан тухай ямар ч сурвалж бичигт дурдагдаагүй болохыг тэмдэглэсэн байдаг[59].

Энэ бүхний эцэст оросууд яагаад түүхээ шинээр бичих болов? гэсэн асуулт урган гарна. Бичих бичихдээ монголчууд гэж үндэстэн байгаагүй, Чингис хаан, Бат хан бол түүхэн хүмүүс биш, монголчуудын аян дайн гэж байгаагүй, Бат хан бол Невийн Александр, Батын аян дайн бол Оросын вангуудын хоорондын тэмцэл мэтээр бичих болов?

Энэ асуултын хариултыг Оросын шинэ «түүхчид» өөрсдөө өгсөн юм. Худал зүйлийг мянга давгвал үнэн болдог гэсэн үг бий. Одоо хэн ч сонссон, уншсан утгагүй энэ бүхнийг Оросын түүхчид арван жил, хорин жил, гучин жил уйгагүй давтахад 50 жилийн дараах үеийнхэн монголчууд гэж үндэстэн байгаагүй, Чингис хаан бол манай, Оросын хаан гэж боддог болно. Энэ бол их гүрний дээрэнгүй бодлогын нэг илрэл юм.

Түүх бол тухайн үндэстний баялаг мөн. Ямар ч үндэстэнд бусад ард түмний түүхийг булаан авах, эзэрхэгээр өөрчлөх, үгүйсгэх эрх байхгүй. Гэхдээ хэрэв аль нэг үндэстнээс ийм түрэмгий хандлага гаргавал доромжлуулсан ард түмэн өөрийн үндэстний баялгаа (үүх түүхээ гэж унш) хамгаалах эрхтэй ч, үүрэгтэй ч. Үүх түүхгүй үндэстэн бол үндэстэн биш учир монголчууд бид нэгийг бодох хэрэгтэй болжээ.

Польш дахь монголчуудын өв

«Урбанек» ХХК-ийн гүйцэтгэх захирал

Баатаржавын Лхагважав

Бат ханы 800 жилийн ойг бид өнөөдөр тэмдэглэж байна. Энэ хүн бол Алтан ургийн жирийн нэг хаан биш, түүхэнд гарамгай үүрэг гүйцэтгэсэн хүн. Бат ханы ойг тэмдэглэж буй энэ өдөр би нэгэн түүх ярих гэсэн юм.

1999 онд Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабанди Польш улсад албан ёсны айлчлал хийсэн. Энэхүү айлчлалынхаа үеэр ерөнхийлөгч Варшав хотоос 80 км-ийн зайд орших Лович хотод байрладаг манай «Урбанек» компанид зочилсон юм. Энэ хотоос 20 км-ийн цаана Монколицэ гэж тосгон бий. Үүнийг кирилл үсгээр бичвэл Монголицэ гэж үг гарч ирдэг. Энэхүү тосгонд ойролцоогоор 1200 хүн амьдардаг. Тэндхийн оршин суугчид XIV зууны үед загалмайтны шашинд орсон ч өөрсдийгөө монголчуудаас гаралтай гэж үздэг. Тухайн үед ерөнхийлөгч Н.Багабанди албан ёсны хүсэлт тавьж, энэ тосгоны түүх, XIII зууны Бат ханы аян дайн болон тэр үеийн Польш улсын түүх, эрх зүйн асуудлыг судалж товхимол гаргах хүсэлт тавьсан.

Ингээд Адам Матышяк хэмээх санваартанд Войцех Урбанек санал болгосноор ерөнхийлөгчийн хүсэн хүлээсэн товхимол бүтсэн түүхтэй. Энэхүү ном нь «Алс тэртээх Монголоос Монколицэ хүртэл» гэсэн нэртэй, гурван бүлгээс бүрддэг. Бат ханы аян дайны үеийн Польшийн улс төрийн байдал, Монколицэ тосгоны түүх, Монколицэд монголчууд аж төрж байсан талаар энэ бүтээлд өгүүлсэн байдаг. Адам Матышяк бол энгийн нэгэн санваартан бөгөөд архивын материал, тулгуур сурвалж дээр үндэслэн энэ номыг бүтээсэн юм. анх польш хэл дээр, дараа нь монгол хэлнээ хөрвүүлэгдэн арван хувь хэвлэгдсэн энэ номын дээжийг ерөнхийлөгч Н.Багабандид өргөн барьсан байгаа.

Би Польш улсад сурч, боловсрол эзэмшсэн хүн. Польшид сурч байхдаа хэд хэдэн сонин уламжлал үзсэн. Краков хотын сүлд дуу өдрийн 12 цагт эгшиглэж байгаад 30 секунд завсарлаад дахин үргэлжилдэг. Энэ эртний уламжлал өнөөдрийг хүртэл хадгалагдан иржээ. Энэ бол яах аргагүй Бат ханы байлдан дагууллын үеийн ул мөр мөн. Тэр уламжлал 750 жилийн урт замыг туулж, өнөөдөр ч мөрдөгдөж байгаа нь Польшийн ард түмэн хором тутамд сонор соргог байж, батлан хамгаалах, цэрэг дайн, улс төрийн байдлаа умартаж болохгүйг сануулж байгаа хэрэг мөн. Энэхүү уламжлал үүссэн түүхээс товчхон танилцуулбал 1241 оны гуравдугаар сард Хайду ханы командалсан Монголын баруун жигүүрийн цэрэг Польшийн эртний нийслэл Краковыг бүслэн хаажээ.

Монгол цэргийн манлай анги ирж буйг үд дундын үед харсан Краковын харуул хотынхныгоо сэрэмжлүүлэхээр бүрээ татсан байна. Монголын эрхий мэргэн харваач алсаас бүрээчийн хоолойг тэр даруйд нэвт харважээ. Монгол цэрэг ямар зайнаас харвасан тухай асуудал судлаачдын анхаарлыг татдаг. Ямартаа ч бүрээч монголчуудыг нэлээд зайнаас ажигласан байх магадлалтай. Тэгвэл монгол нум сумын алсын тусгалыг тооцоод 200-300 метр, цаашлаад 400-500 метрийн алсаас харвасан болов уу гэсэн таамаглал бий. Хоолойгоо нэвт харвуулсан бүрээч үхэтхийн унахад бүрээн дуу хэсэг замхарчээ. Харин түүний дэргэд байсан өөр бүрээч

газар унасан зэмсгийг аваад, дахин бүрээ татсан байна. Краковчууд аюулын дохиог сонсож, нийслэлээ хамгаалахаар нэгэн зэрэг боссон түүхтэй.

Өнөөдөр Краков хотод очсон жуулчдад бүрээч хоолойгоо нэвт харвуулсан Ариун Мариягийн цайзыг үзүүлж, энэхүү түүхийг хуучилдаг. Эх орноо хамгаалах үйлсэд ганц хором ч сонор сэрэмжээ алдаж болдоггүй, тэгвэл тусгаар тогтнолоо ч алдах аюултайг ард түмэндээ цаг ямагт сануулж байхын тулд энэ уламжлал зуун зууныг дамжсаар өнөөдрийг хүрчээ.

1241 оны дөрөвдүгээр сарын 9-нд Легницийн дэргэд Байдар, Хайду хадын командалсан монгол цэрэг, Силезийн ван Хоёрдугаар Хенрикийн командалсан армийн хооронд шийдвэрлэх тулалдаан өрнөжээ. Монгол цэрэг байлдааны хосгүй ур чадвар, гарамгай тактикийн ачаар хүч давуу дайсныг бут цохисон юм. Тулалдаанд Хенрик ван алагдсан байна. Монголчууд түүний толгойг тайрч, Бат ханы цэргийн өмнө бууж өгөөгүй хэн ч ингэж төгсөнө гэж сэрэмжлүүлэхээр Легницэд давхилдан иржээ.

Монголчуудыг дайран өнгөрсний дараа Хенрик вангийн бэлэвсэн гэргий Анна[60] эр нөхрөө загалмайтны ёс жаягийн дагуу оршуулахаар цогцсыг нь хайгаад олоогүй байна. Учир нь монголчууд Хенрикийн толгойг тайрнаас гадна хувцас хунар, эд зүйлсийг нь тонон дээрэмдсэн тул олон арван мянган цогцос дундаас олж таних арга байсангүй. Тиймээс Анна зүүн хөлөндөө зургаан хуруутай хүний цогцос хайхыг тушааж, чухамхүү ийм л аргаар ванг олж, загалмайтны ёсоор оршуулсан юм.

Тэр цагаас хойш польшчуудын сэтгэлийг эмзэглүүлж байсан нэг асуудал бол бид үнэхээр эх орноо хамгаалан босч, амь үрэгдсэн вангаа олж оршуулсан уу, аль эсвэл хэн нь үл танигдах этгээдэд хүндэтгэл үзүүлсэн үү гэсэн болгоомжлол байлаа. Тулалдаанаас хойш 600 жил өнгөрсний дараа, 1832 онд Польшийн археологичид Хенрик вангийн гэгддэг булшинд малтлага хийхэд үнэхээр толгойгүй, зүүн хөлөндөө зургаан хуруутай араг яс олдсон байна. Польшчууд эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө амь үрэгдсэн Хенрикийн цогцос олдсон тэр газар хожим сүм барьж, хүндэтгэл үзүүлсэн нь өдгөө жуулчдын очдог газрын нэг болжээ.

Хенрик ван алагдсан тухай өөр нэг түүх байдгийг энд дурдмаар байна. Монголчууд Легницын тулалдааны үеэр түүнийг олзлоод цаазаар авч, толгойг нь Бат ханд илгээсэн гэдэг.[61]

Бат хан Европын орнуудад цөмрөн ороод богино хугацаанд зэвсэгт хүчнийг нь устгаж, эзлэн түрэмгийлсний учрыг судлаачид янз бүрээр тайлбарлагдгийн нэгээс сонирхуулъя. Монголчуудад Польш, Чехи, Унгар зэрэг орны цэрэг-улс төрийн байдал, газар зүй-эдийн засгийн нууцыг хэн задруулсан бэ гэдэг асуулт урган гарч ирдэг. Тэгвэл түүхч, судлаачид нууц мэдээллийг монголчуудад оросууд задруулсан гэсэн таамаглал дэвшүүлдэг. Ингэснээрээ монголчуудын түрэмгийлэлд өртөж, батлан хамгаалах тогтолцоогоо устгуулсан оросууд Европын орнуудын зүгээс ирж болзошгүй аюулаас өөрсдийгөө урьдчилан сэргийлж чадсан гэж үздэг.

Тулгар бичгүүдийг үзвэл Польшид гурван замаар юүлэн орсон Монголын цэргийн хоёр анги хожим стратегийн төлөвлөгөөний дагуу нийлээд буцсан байдаг. Харин одоогийн Монколицэ тосгон оршиж байгаа зүг явсан гурав дахь анги нь гол хүчтэйгээ нийлсэн эсэх талаар мэдээлэл байдаггүй. Сураггүй болсон гурав дахь хүч Монколицэ тосгонд суурьшсан байж

болох таамаглал бий. Ингээд тэр тосгоныхон XIV зуунд загалмайтны шашинд ороход татар овогтой байсныг Европын түүхчид тухайн үеийн католик шашны сүм хийдийн архивуудын баримтанд дүн шинжилгээ хийж тогтоосон байдаг. Энэ тосгоны түүх, уламжлалын тухай олон сонирхолтой баримтыг Адам Матышяк цуглуулан номондоо оруулсан нь бий.

Баг ханы цэргүүд явж өнгөрсөн газрын тухайн үеийн зураг Польшид хадгалагдан үлдсэн байдаг. Тэр зурган дээр Польшийн вант улсын бүрэлдэхүүнд орж байсан газар нутгийг хожим XVIII зуунд Прусси буюу Герман эрхшээлдээ оруулжээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараа Польш улсыг газар нутгийн хувьд зүүнээс баруун тийш зөөсөн байдаг. Вроцлав, Легниц зэрэг олон хот 1945 он хүртэл Германы мэдэлд байжээ. Дэлхийн хоёрдугаар дайнд Германыг ялж, Европын газрын зургийг шинэчлэн өөрчлөхийнхөө өмнө Сталин дундад зууны үеийн, тэр дотор XIII зууны үеийн Польшийн газрын зургийг архивуудаас олж илрүүлэхийг тушаасан байдаг. Үүний дагуу Польшийн хил баруун тийш нүүсэн, харин зүүн хязгаарын газар нутаг нь тэр үеийн ЗХУ-ын бүрэлдэхүүнд оржээ. Хилийг баруун зүг нүүлгэсэн нь түүхэн учир шалтгаантай байсан юм. Хоёрдугаар Хенрик 1241-1242 онд Монголын цэрэгтэй Легниц хотын дэргэд яагаад тулалдах болов? Энэ хот Германых байсан бол Хенрик эх орноо хамгаалж тэнд тулалдах байсан уу? Легниц хот орших газар бол гагцхүү Польшийн нутаг дэвсгэр байсан учраас Хенрик ван монголчуудыг сөрөн зогссон байна.

Ийн монголчуудын аян дайн Польшийн уламжлалт газар нутгийг тодруулан сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн түүхтэй.

Чингис хааны төрийн ураг барилдахуй ёсон

МУИС-ийн түүхийн тэнхим,

Дугарсүрэнгийн Энхцэцэг

Чингис хаан барс жил (1206 он) Онон мөрний тэргүүнээ их хуралдай хуралдуулж «эсгий туургат улсыг шулуутгаж (нэгтгэж)»[62] Монголын нэгдсэн төр улсыг байгуулан тунхаглаж, урьдын олон жижиг улс ханлигуудын тархай бутархай байдлыг эцэс болгожээ. Улсын дотоодод шинэчлэлт хийж, «Их засаг» хууль баталж, цэрэг, засаг захиргааны зохион байгуулалтыг төгөлдөржүүлэн, эдийн засаг, цэргийн хүчин чадлыг бэхжүүлжээ.

Монгол улсын төрийн гадаад бодлогын чиг шугамыг боловсруулан, хөрш зэргэлдээ орон лугаа улс төр, эдийн засгийн эрх тэгш харилцаа тогтоохыг эрмэлзэх болжээ. Монгол улсын газар нутаг «өргөн уудам ... нэг захаас нөгөө хүртэл долоогоос найман сар явах»[63] бөгөөд өмнө болон «дорно талаараа хятадын нутагтай»[64], «өрнө талаараа уйгар оронтой, умар талаараа киргизийн нутаг, түрэг, монгол гарал бүхий ойн иргэдтэй, өмнөд (баруун өмнөд) талаараа тангад, түвэдийн эзэмшил газартай хил залган»[65] суух болжээ.

Эдгээр улс түмэнтэй харилцах, хил хязгаараа сахин хамгаалах, шинэ тулгар төр улсаа хүлээн зөвшөөрүүлэх талаар явуулсан Монгол төрийн гадаад бодлогыг дан ганц цэрэг-дайны бодлогоор тайлбарлах нь ихээхэн учир дутагдалтай байлаа. Аль нэг харь улсын талаар урьдчилан сайтар бодож боловсруулсан дипломат бодлого, үйл ажиллагаа явуулж, элчин төлөөлөгч солилцох, худалдаа арилжаа хийх, ураг барилдах, найрамдал байгуулах зэрэг олон аргыг хэрэглэж байв. Энэхүү өвөрмөц бодлого нь цаашид «цэрэг-улс төрийн бодлогоо амжилттай хэрэгжүүлэх бас нэгэн эх сурвалж»[66] болж, Монгол улс, эзэнт гүрний олон арван жил баримтлах гадаад бодлогын үндсэн зарчим болон уламжлагджээ.

Монгол улсын гадаад бодлогын эхлэл, Монголын эзэнт гүрний үндэс суурийг тавьсан амжилттай үйл ажиллагааны гол чиглэл юуны өмнө Түрэг, Киргиз, Уйгар гаралтай аймгуудыг өөртөө нэгтгэн захирах, «даган ирэгсдийг өршөөн соёрхож, өөрийн холбоотон»[67] болгох явдал байв. Чингис хаан, Алтан ургийн сурвалжит охид, гүнж нараар дамжуулан түрэг, уйгар, киргиз аймгийн дээд эзэд, ноёдтой ургийн холбоо тогтоох өвөрмөц бодлогыг баримталж ихээхэн амжилт олж байв.

монголын эмэгтэйчүүдийн улс төрийн амьдралд оролцох оролцоог илтгэх нэг өвөрмөц зүйл нь «төрийн ураг барилдахуй» хэмээх эрхэм ёсон - Монгол хаадын алтан аргамжийн хэлхээ болж байсан гэж үзэж болох юм. Чингис хаан олон монгол аймаг, эсгий туургатныг эрхэндээ хурааж, өөрийн төрөл төрөгсөд, ээж, дүү нар, нагац нараар захируулан, Ойрад, Түрэг, Уйгар, Киргиз хүчирхэг аймаг ханлигийн ноёдтой урагласан өөрийн гүнж, охид, татвар хатгад түрэг овог аймгуудын ахлагч, зонхилогч нар эртнээс зүүн ирсэн бэхи (бег) цолыг соёрхсон нь өөрийн охин ургийг тэдгээр овог аймгийн дээд эзэн болгон, улс төрийн эрх мэдэл тэдний гарт төвлөрөх болсныг илтгэсэн, өөрийн гол түшиг тулгуур гэж үзэж байсантай холбоотой. [68]

1207 онд Чингис хаан, ахмад хүү Зүчийг илгээн ойн иргэдийг эзлэн авахад Ойрадын эзэн Хутуга бэхи Ойрадаа авч дагаар ирж, цэргийг замчлан явж, Шишгид гол хүрч түмэн ойрадыг оруулан авчээ. Хутага бэхи, Чингис хаанд цагаан шонхор, цагаан морь (агт), хар булгуудаар бэлэг барин уулзсанд «даган элсэв» гэж түүний хүү Иналчид өөрийн охин Сэцэйхэн (Чэчэйхэн) гүнжийг өгөв. Охиндоо хандаж:

«Эрт босож, орой хэвт ...

Өдөр шөнө нэгэн сэтгэлээр хатууж,

амны ухаан билгээ тогтоо

Эс сурсан мууг энд тавьж (үлдээж) од.

Сурсан сайныгаа аваад од

Ойрад иргэнээ сэлбэн холбон соёрхогтун»[69] хэмээн сургажээ.

Иналчийн ах Төрүлчид Зүчийн охин Улухуйн гүнжийг ураглажээ.

Тухайн үеийн хүчирхэг овог аймгуудын нэг Уйгар аймгийн эзэн Идүйд[70] (амжилтын эзэн) Барчук (Барчук арт тегин)-т 1208 онд Чингис Адхираг, Дарбай хоёр элчийг (Куталмыш-Кайя, Умар-огула, Дарбай гурвыг)[71] илгээж:

«Үүл арилж, ээх наран үзсэн мэт

Мөс арилж, мөрөн ус олсон мэт

Чингис хааны нэр алдрыг сонсож маш их баясав.

Чингис хаан соёрхвоос

Аалтан бүсний чинь горхинаас

Ал (улаан) дээлийн үртэснээс олбоос, тавдугаар хүү чинь болж хүч өгье» хэмээн илгээжээ. Чингис хаан соёрхож: «Охин өгье. Тавдугаар хөвгүүн болтугай. Алт мөнгө, сувд тана, хоргой, таж магнаг торго аваад Идүйд иртүгэй»[72] хэмээн илгээхэд Уйгурын эзэн Барчуг тегин 1211 онд хаврын тэргүүнд сард Хэрлэнгийн хөдөө аралд хаанд «соёрхогдов» хэмээн иржээ. Уйгарын эзэн Идүйдэд Ал алтун[73] нэрт охиноо өгөхдөө:

Хатагтай хүнд гурван эр бий

Анхны эр нь алтан төр

Түүний дараах эр нь ариун нэр

Түүний удаах эр нь авсан эр мөн билээ.

Алтан төрийг хагуужин дагавал

Ариун нэр ирнэ

Ариун нэрийг бэхэлбэл

Авсан эр ангид үл одно[74] хэмээн сургаал юугаан хайрлан, төр ёсыг өндөр өргөж явахыг сануулж байжээ[75]. Хожим Өгэдэй хаан энэ уламжлалыг баримтлан өөрийн охин Алажинг Уйгарт Барчукийн хүү Кешмэш ханд ураглаж байжээ.

Мөн түүний хамт харлугуудын («ажнай хүлэг» гэх түрэг үг) Арслан хан[76] дагаж ирсэнд Чингис хаан Арсланг «Эс тэмцэлдэв» хэмээн сайшаан соёрхож, охин өгье хэмээн зарлиг болгов[77]. «Нууц товчоо»-нд чухам ямар нэрт охиноо өгсөн нь тодорхойгүй. Ургийн бодлогоор Харлугийг нэгтгэн, хожим Арслан хааны хөвгүүн Есөн буха, түүний хүү Хундар нар монголын төрд үйлчилсэн төрийн хүргэд байжээ. «Юань ши» ба Хятад сурвалжид «Тулай гүнжийг өгч ван өргөмжлөв» гэжээ. Арсланг үгүй болсон хойно хүү Есөн буха гүнжийг дагав (залгаж суув) гэжээ.

Цагаан татар буюу соёлжуу татарын нэг аймаг Онгуд[78] эртнээс Хятад, Хятан, Уйгуртай аж ахуй, соёлын харилцаатай, Наймантай адил уйгуржин монгол бичигтэй, хүн ам олонтой хүчирхэг аймаг, түүний захирагч нь Алахуш Дигидхури байв. Найманы Таян хан, түүний эх Гүрбэсү хатан нар:

«Энэ дорно зүгт цөөхөн Монгол буй хэмээмүй

Тэнгэрт нар сар хоёр гэрэлтэн... буй за

Газарт хоёр хан хэрхэн байж болох? Бид тэдгээр Монголыг авч ирье ... тэр Монгол руу одож хор зэвсгийг нь хураан авч ирье» гээд Торбиташи нэрт элчээр Онгудын Алахуш дигитхурид (зарж) илгээсэнд, тэрээр «Баруун гар чинь болж үл чадна» гээд Юхунан нэрт элчийг Чингис хаанд илгээн, «Сэрэмжлэгтүн»[79] гэж тус хүргэсэн, наймантай байлдахад (1204 он) онцгой гавьяа байгуулж, хожим дагаар ирсэнд хаан талархаж, 88 гавьяатны нэгээр өргөмжлөн, мянганы ноён болгож хааны гүнжээр шагнасан нь цэрэг-улс төрийн төдийгүй аж ахуй соёлын хөгжилд ихээхэн ач холбогдолтой болжээ. «Монголын нууц товчоо» зэрэг түүхийн сурвалжид тэмдэглэснээс үзвэл: Чингис хаан дагаар ирсэн Онгуд аймгийн эзэн Алахуш дигидхурийн хүү Буяншбалд сайшаан соёрхож Алаха бэхи охиноо хатан болгон өгөхдөө

...Харайхад минь хөл болж

Хазайхад минь түшиг болж

Халтирахад тах болж

Халамж тус хүргэхээ

Хайрт Алаха минь мэдтүгэй

Энэ бие хэврэг боловч

Эрхэм нэр мөнх шүү

Саруул ухаанаас илүү сайн нөхөр үгүй

Мунхаг ухаанаас илүү муу дайсан үгүй

Эрхэм итгэлтэн олон боловч

Энэ бие бүхнээс итгэлтэй

...Хатуужиж явбал хамгаас хайрлалтай

Ариун явбал аминд тустай[80] хэмээн сургаж төр улсын чухал үүрэг хүлээлгэж байжээ. Алаха бэхи эцгийн итгэлт шадар түшмэдийн хувиар үүргээ нэр төртэй биелүүлж төрийн үүргийг түшилцсэн юм. 1219 онд Чингис хаан Дундад Ази, Сартуул иргэнийг дайлах үед гүнж Алаха, дүү Отчигин ноён хоёроор тус тус говийн өмнө, умарын төрийн хэргийг захируулахаар шийдвэрлэж «Төр захирах гүнжийн тамга гэсэн гуулин тамга гүнжтэнд олгож байжээ»[81]. Энэ тухай Сүн улсын «Монгол-татарын бүрэн тэмдэглэл»-д: «Гүнж бол сэцэн мэргэн бодлоготой, хаан ийш тийш аян дайнд морилохуйд төр улсын их засгийг зөвлөн захируулахаар үлдээдэг тул цэрэг эргэлзээгүйгээр явах үед гүнжийн гавьяа их»[82] гэж тэмдэглэжээ. «Монголын нууц товчоо»-нд дээр дурдсанаас гадна «Охин ураг»-аар соёрхол хүртсэн Чингис хааны хүргэдийн тухай мэдээ цөөнгүй бий[83].

Ийнхүү Чингис хаан өөртөө дагаар ирсэн Түрэг, Уйгар, Киргиз ханлигуудтай найртай харилцах олон овог, аймгийг өөртөө нэгтгэн захирч байх зорилгоор тэдгээр аймгийн «хан», «бэхи» нарт өөрийн сурвалжит гүнж, охидыг хатан болгон өгч байсан нь эзэн хааны дипломат бодлого байжээ.

Энэ бүхнээс Чингис хааны төрийн бодлогод охид, гүнж нарын гүйцэтгэсэн нэгэн үүрэг ба Их монгол улс нэгдсэн хүчирхэг байхын нэг үндэс нь дээрх ургийн бодлого байсан нь харагдаж байна. Их монгол улс, Эзэнт гүрний үед хэдийгээр эмэгтэйчүүд өрх гэр, төрөл садны хүрээнд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, тухайн үеийн нийгэм-улс төрийн онцлог байдал, цаг үеийн шаардлагын улмаас улс төрийн амьдралд шууд ба дам байдлаар оролцож иржээ гэж хэлж болох юм.

Төрийн ураг барилдахуй бодлогын үр дүнд Их эзэнт гүрний үндэс тавигдан, Ойн иргэдийн зарим хэсэг, Харлуг (Киргиз), түрэг аймгууд Чингис хааны ахмад хүү Зүчийн улс, Батын улс Алтан ордны улсын, «Татарын морины туурай хүрэх газрыг эзэмших»[84]-ийн үндсийг тавьж, Уйгар зэрэг олон аймаг улс дэд хүү Цагадайн улсын эзэмшил болж зуун дамжин монголчуудын түүхийг өгүүлж ирсэн билээ.

Ашигласан сурвалж

1. Б а я с а х Ж. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр баримт бичиг. УБ., 2005.

2. Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл. Хайлаар, 1985.
3. Б о р Ж. Монголын дипломат товчоон. УБ., 1997.
4. Ж у в е й н и А. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Уб., 2006.
5. Л у в с а н д а н з а н. Алтан товч. УБ., 1970.
6. Монголын нууц товчоо. УБ., 2005.
7. Монгол улсын түүх. дэд боть. УБ., 2003.
8. Р а ч н е в с к и й П. Чингис хаан, түүний амьдрал ба өв (Англи хэлнээс орчуулсан Л.Мөнх-Эрдэнэ.) УБ., 2006.
9. Р а ш и д - а д - д и н. Судрын чуулган. I, II, III УБ., 2000.
10. С а й ш а а л. Чингис хааны товчоон. Дэд, доод дэвтэр. Хөх хот. 1985.
11. Сэцлэглэгсдийн чуулганы намага (монголын хаадын төрийн товчоон. Аблагачи баатар хаан түрэг хэлээр зохиов) Хөх хот, 1999.
12. У р а н г у а Ж., Э н х ц э ц э г Д. Монгол хатад. УБ., 2000.
13. Э н х ц э ц э г Д. «Монголын нууц товчоо» ба эмэгтэйчүүд. УБ., 2008.
14. Д' О с с о н. История Монголов от Чингис хана до Тамерлана. И., 1937.
15. К л я ш т о р н ы й С. Г., С у л т а н о в Т. И. Казахстан: летопись трех тысячелетий. Алма-Ата, 1992.
16. М у н к у е в Н. Ц. Мэн-Да Бэйлу (Полное описание монголо-татар). М., 1975.

Алс тэртээх Монголоос Монколицэ хүртэл

Адам Матышяк

онгол Улс бол Төв Азид байрладаг, түүх, соёлын баялаг өв уламжлалтай үзэсгэлэн төгөлдөр орон билээ. Яагаад Монголын тал хээр нутгаас ийм хол орших манай орны газар нутагт тэдний үр удам байгаа гэсэн бодлыг зарим нэг таамаглал болон ажиглалт төрүүлнэ вэ? Польш Улсын түүхэн эх сурвалж бидний энэхүү таамаглал зөвхөн худал төсөөлөл буюу хий хоосон мөрөөдөл төдийхнөөр хязгаарлагдахгүй байж болохыг харуулж байна.

Өнгөрсөн зуунуудад Польш орны улсын хил дээр монголчууд байсан нь түүхийн хуудаснаа мөнхрөн үлдсэн билээ. Хэдийгээр энд нөхөрсөг айлчлалын тухай ярихад бэрх ч гэсэн, XIII зууны нэгдүгээр хагаст Польш улс руу довтолсон монголчуудын байлдан дагууллын түүхэн үнэнийг үгүйсгэх аргагүй билээ. Хэдийгээр алс тэртээх он жилүүдэд болж өнгөрсөн боловч чухам энэхүү түүхэн үйл явдал нь бид өөрсдөдөө хэдэн асуулт тавьж, тэдгээрийн хариуг олох буюу үгүй ядаж цаашдын судалгаа шинжилгээнд нэмэр болохуйц зүг чигийг тогтоохыг шаардсаар бөлгөө.

Монколицэ нь Польшийн төв хэсэгт оршдог бяцхан суурин газар ажгуу. Өв уламжлалаас үзэхэд уг суурин газрыг алс тэртээх он жилүүдэд Польшийн газар нутагт монголчууд амьдран сууж байсан түүхтэй холбох нь бий. Энэ таамаглал хэр үнэн болохыг тогтоохыг бүгдээрээ оролдоод үзэцгээе.

Польш дахь монголчуудын байлдан дагуулал

XIII зууны эхээр засаг захиргааны нэгжүүдийг шинээр хуваах болсонтой холбогдон Польш улс төрийн хүнд байдалд ороод байв. 1138 онд Болеслав Кшывоусты ван хүн бүр өөрийн эзэмшлийн дүүрэгтэй байхаар бодож, улсаа хөвгүүддээ хувааж гэрээслэлээ бичжээ. Ингэснээр төрийн нэгдмэл байдал алдагдсан байна. Гэрээслэлээс үүдэн өв залгамжлагчдын дунд улс төрийн тэмцэл өрнөж энэ нь XIV зууны эхэн үе хүртэл үргэлжилжээ. Польш улс төрийн довтолгооны хялбар бай болж хөрш орнуудын үй олон түрэмгийлэлд өртөж, дайны хөлд дарлагдан, нэн түрүүнд дүүргүүдийн хагарлын улмаас үүссэн вант гүрний бүрэлдэхүүн хооронд дэгдсэн дотоодын хагарал маргалдаанд нэрвэгджээ. Энэ үед Шьлонск, Велькопольска, Малопольска, Маюйшэ, Куявы, Поморье хэмээх шинээр бий болсон вант улсууд тус тусдаа биө даасан улс төрийн бодлого явуулж харилцан ойлголцол, Польш улсын эрх ашгийг хувь хүний хүсэл сонирхлоос дээгүүрт тавих сэтгэл дутсан юм[85].

Польшийн нэгдмэл байдалд хямрал нүүрлэсэн энэ үед Төв Азийн алс тэртээх газар нутагт Монголын асар хүчирхэг төрт улс тогтнож эхлээд байв. Монголын нэгдсэн овог аймгуудын агуу их удирдагчаар Чингис хаан тодорч нөр хүчирхэг цэрэг арми байгуулж, Азийг эзлэх аянд мордон, улмаар Хятадыг эзлэн, Ази тивийн төвд орших газар нутгийг эзэлж, цааш үргэлжлүүлэн Перс, Кавказад довтолжээ[86]. 1223 онд Чингис хааны цэрэг Өмнөд Оросод хүрч, Киевийн вангийн цэрэг армитай Калка голын эх орчимд тулалдаж ялалт байгуулсан байна. Польшийн түүхч Павел Яшеница энэ тухай бичихдээ: «Чингис хаан бол түүхэнд алдартай сод билигт шилдэг удирдагч, зохион байгуулагчдын нэг байв»[87] хэмээн дурдсан

байдаг. Агуу их удирдагч 1227 онд гэнэт тэнгэрт халин одсон хэдий ч монголчууд байлдан дагууллаа зогсоогоогүй билээ. Европыг зорин хөдөлсөн цэрэг арми 1236 онд Киевийг эзэлж, түүнийг өөрийн засаг захиргаанд нэгтгэжээ. Монголын цэрэг арми довтлохоор төлөвлөөд байсан удаахь гүрэн нь Унгар байв[88].

Оросыг довтлон эзэлж, дараа дараагийн эзлэн түрэмгийлэх гараагаа эхэлж байхаар цэргийн баазаа тэнд байгуулжээ. Монголчуудын хүчин чадлыг Төв Европын улс орнуудын удирдагчдын ихэнх нь мэдэрч байсан ажгуу. Унгарын санваартны доминикан бүлгийн гишүүн Юлиан 1236 онд хоёр удаагийн жишин дэлгэрүүлэх аянд мордсоноор монголчуудын төлөвлөж буй довтолгооны талаар чухал мэдээллийг сонсож мэдсэн байдаг. Ромын пап ламын татан буулгасан санваартан Унгарт үлдсэнээр, түүний өгсөн мэдээлэл улсыг хамгаалах арга барилыг боловсруулах гол эх үндэс суурь нь болж өгчээ. Айсуй буй монголчуудын довтолгооноос эмээн Киевээс зугтан дүрвэж ван Конрад Мазовецкийн нөмөрт хоргодсон Черниговын ван Михаил Всеволодович ойртож буй түгшүүртэй байдлын тухай ээлжит мэдээллийг дамжуулжээ[89].

Унгар гүрэнд нүүрлээд байсан шууд заналхийлэл удирдагчид нь хоорондоо ах дүүгийн холбоотой байсан түүний хөрш орнууд Польш, Чехид ч түгшүүр төрүүлсэн юм. Сандомирийн ван Болеслав Стыдливыйгийн эгч Саломэа Унгарын ван IV Бела Коломаны ахтай гэрлэж, харин Сандомирийн ван өөрөө Белагийн охин Кингаг авааль эхнэрээ болгон суусан байлаа. Чехитэй харилцах харилцаа мөн адил төстэй дүр төрхтэй байв. Чехийн вангийн ээж Вацлава Констанция Унгарын вангийн эцэг II Андрейн төрсөн дүү нь байсан бол, Чехийн вангийн дүү Анна Шьлонскийн ван II Хенриктэй гэрлэсэн байжээ. Гэвч Польш, Чехи, Унгарын удирдагчдын дунд нягт хамтын ажиллагаа дутагдаж, харилцан туслалцахаар бие биедээ амласан амлалт нь Монголын эзлэн түрэмгийллээс улс орноо хамтын хүчээр хамгаалах шаардлагатай болох үед хоосон үг байсан нь харагдсан ажгуу[90].

Дээрх байдлыг монголчууд мэдэж байсан нь Унгар руу дайран довтлох төлөвлөгөө боловсруулах үндэс суурь болж өгчээ. Ерөнхийдөө Монголын цэрэг хүчин уг оронд довтолж, 10 мянга орчим хүчирхэг цэрэг армийн нэгжүүд хойд зүгээс ирж болзошгүй Чехи, Польшийн тусламжийг сөрөн зогсохоор төлөвлөгдөөд байв. Улам бүр ойртож буй довтолгооны тухай анхны мэдээ 1240 оны арванхоёрдугаар сард хил орчмын дайн тулалдаанд нэрвэгдэж хоосорсон суурин газрууд болох Унгарын хилийн зүгээс тархжээ. Гэвч гол цохилт гуравдугаар сард эхэлсэн бөлгөө.

Польшид халдсан Монголын цэрэг армийн довтолгооны бааз нь Владимир Волыньскийн бүс нутагт байв. Цэргийн үндсэн армийг Бат удирдаж, Польш руу довтлогч хашилтын цэргийг түүний дүү Орд удирджээ. Төлөвлөгөө ёсоор Польшийн өмнөд хэсгээр дайрч өнгөрөн, үүний дараа Моравийн гол хаалга Мораваар дайран Унгарт довтлох ёстой байв. Энэ нь маш хэцүү даалгавар байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Учир нь цэргүүдийн явах зөрөг замуудыг судалж танин мэдэх, мөн Монголын цэрэг армийн тоог харьцангуй давамгайлж болзошгүй эсрэг талын цэргүүд хоорондоо нэгдэх боломжийг хайх арга боловсруулах шаардлага тулгараад байв.

Энэ үед Польшид гүн нэвтрэх Сандомир, Краков хүртэлх замыг нээх Завихостын ойролцоох Вислагаар гарах стратегийн цэг сонгогдоод байсан. Тандаж мэдэх анхны үйл ажиллагаа 1240-

1241 оны заагаар эхэлж, санаандгүй байтал Монголын цэрэг армийн бүлэг Малопольскагийн нутаг дэвсгэрийн зүүн хэсгээр довтлон орж Люблинийг түйвээн сүйтгэж хоосруулаад, гол зорилго нь байсан байж болзошгүй Завихостод хүрчээ. Хоёрдугаар замын цэрэг армийн бүлэг улсын төв рүү нилээд ойртож довтолсон байна. Тандаж мэдэх үйл ажиллагаагаа ийнхүү явуулсны дараагаар цэрэг армийн бүлгүүд Орос руу эргэжээ[91].

Монголын байлдан дагууллыг 1241 онд эхэлсэн гэж тооцоолдог. Монголын цэрэг арми Сандомирт ямар ч саад бэрхшээлгүйгээр хүрч эзлэн түрэмгийллээ эхэлжээ. Хэдийгээр эсэргүүцэл тэмцэлтэй тулгарсан боловч 1241 оны хоёрдугаар сарын 13-нд монголчууд хотыг бүрэн эзэлсэн юм. Сандомир хотыг хамгаалах тулалдаанд хот сүйтгэгдэж, үй олон оршин суугч амь үрэгджээ[92].

Цэрэг армийн хоёрдугаар бүлэг сүйтгэсэн хотыг орхин Краковын зүг жолоо залсан байна. Краковын мужийн дарга Владимир ойртож буй дайсныг баатарлагаар угтан довтолсон ба Польшийн цэрэг арми ойртож буйг мэдээд монголчууд жолоо мушгиж, хилийн зүг ухрахаар шийджээ. Турскийн доохно ухарч явсан цэргүүд рүү польшууд гэнэт довтолсон байдаг. Энэ тухай цаг тооны бичээч Ян Длугош:

«(...) Краковын мужийн дарга Владимир Краковын бусад баатарлаг эрстэй хамтарч татарчууд руу довтлох үеэр тэд Хар голын эрэг дээр байрлах Поланец руу хүрч, Вельке Турско хэмээх хөдөө газар урц майхнаа барьцгааж байв...»[93] хэмээн тэмдэглэжээ. Санамсаргүй байхад нь довтолсон Польшууд монголчуудын ачаа хөсгийг эзэлж, олз омог руу нь дайрсан байна. Яг энэ үеийг ашиглан Монголын цэрэг арми тэдэн рүү довтолж ялалт байгуулжээ. Польшууд маргаангүй ялагдсан боловч тулалдаанаас амссан хохирлын улмаас монголчууд Орос руу эргэн буцжээ.

Ордын удирдсан цэргийн довтолгоо 1241 оны гуравдугаар сарын эхний өдрүүдэд эхэлсэн юм. Монголын цэрэг арми онцын сөргөлдөөнтэй учралгүйгээр сүйтгэгдсэн Сандомирийг алгасан Краковын зүг хөдлөв. Будлиан хутгалга, үймээн шуугианыг ихэсгэж, эсрэг талынхныг төөрөгдөлд оруулахын тулд Орд нэг салаа цэргээ Ленчица, Куявын зүг илгээж, харин өөрөө цэргийн гол хүчээ дайчлан Краков руу довтолсон байна. Краковын цэрэг, сандомирийн үлдэгдэл цэргүүдийн хамтарсан хүч морин цэргүүдийн замыг хааж амдан бүсэлжээ. 1241 онд Польш, Монголын цэргүүд Хмельникийн ойролцоо газар тулалдаж, буруу стратеги бодлогын улмаас эхэн үед давуу байдалтай байсан польшууд уг тулалдаанд ялагдал хүлээсэн байна.

Урьд дурдсан Ян Длугош энэ тухай дурсахдаа: «...Польшийн үй олон баатарлаг эрс энэ тулаанд шүтлэг бишрэл, эх орныхоо төлөө баатарлагаар амь үрэгдсэн...»[94] хэмээн бичжээ. Энэ үйл явдал нь Краковын вант улсад эмх замбараагүй байдлыг дэгдээснээр монголчууд саад бэрхшээлгүйгээр Краковт хүрч, хотыг бараг тулалдалгүйгээр эзлэн авчээ. Гуравдугаар сарын 21-22-ны өдөр хот дайсны гарт орсон байна. Хэдийгээр Польшууд гэгээн Андрейгийн сүм болон Околын тосгоны ойр орчинг хамгаалж сөрөн зогссоны улмаас монголчууд бүх сөрөг хамгаалалтын цэгүүдийг бүгдийг устгаж чадаагүй ч хотын үлдсэн хэсгийг эзлээд байв. Арван өдөр алжаал ядралаа тайлсны дараагаар гуравдугаар сарын 31-нд монголчууд хотын барилга байшингуудыг шатаагаад, дөрөвдүгээр сарын 1-нд баруун зүгт чиглэн хотыг орхин гарч явцгаажээ[95].

Ленчица, Куявы руу дайран довтолсон монголын цэргүүдийн явдал үл ялиг нууцлаг, тодорхой бус санагдана. Гнезногийн капитулын цаг тооны бичгээс «...Их мацаг барилт эхлэх өдөр монголчууд Сандомирийг эвдлэн сүйтгээд Краков, Вишьлицаагаар дайран Вроцлавт хүрсэн...»[96] болохыг бид мэдэх билээ. Ян Длугош он дарааллын бичигт энэ тухай дурсахдаа: «...Улаан өндөгний баярын шөнө татарчуудын хоёрдугаар салаа цэрэг Краковт эргэн ирж Сандомирийн хавь газар буудаллаж байгаад гал, илд сэлмээ далайн ойр хавийн газар нутгийг сүйтгээд Ленчица, Куявын зүг жолоо залсан болой...» хэмээжээ. Монголын цэргүүд Куявыг чиглэн явсныг хэдийгээр үүний явц, үр дагаварын талаар ямар нэгэн эх сурвалж байхгүй хэдий ч бид багтай хэлж болох юм. Ордын цэрэг арми Краковт ийнхүү удсан нь урьд дурдсан салаа цэргүүдээ эргэж ирэхийг хүлээсэнтэй холбоотой байж болзошгүй билээ. Цэрэг эрс дараа нь хүчээ нэгтгэн польшийн цэргийн голлох хүчин төвлөрөөд байсан Шьлонскийн зүг хөдөлцгөөсөн ажгуу.

Монголчууд Рацибор руу чиглэн хотын ойр орчимд гүүр нь эвдэрч сүйтгэгдэн балгас болсон голоор Одра голын нөгөө эрэг рүү гатлан гарахыг зорив. Тагнан турших зорилгоор илгээгдсэн салаа цэрэг Рациборийн цэргээр довтолж бут цохигджээ. Цэргийн гол хүчин Польшийн цэргүүдийн сөрөн зогсох эрмэлзэлтэйг хараад хотыг тойрон Опольегийн зүг хөдөлсөн байна. Монголчууд хотоор түргэн зуур дамжин гарч Вроцлавт хүрээд хотыг эзлэх оролдлогоо эхлүүлжээ. Хотыг хамгаалагчид морьтон эрстэй эрэлхэг сөргөлдөн тэмцсэний дүнд энэ оролдлого нь амжилтанд хүрсэнгүй.

Эцсийн үр дүнд монголын цэргүүд Вроцлавыг орхин Польшийн цэргүүдтэй хийсэн хамгийн том тулалдаан өрнөсөн Легницыг чиглэн оджээ. Чухам яагаад II Хенрик ван Легниц хотыг баатарлаг эрс цугларах газраар сонгосон тухай тодорхой сурвалж мэдээ байдаггүй. Холбоотны хувьд өөрийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлэхийг амласан Чехийн ван Вацлаваас тусламж ирнэ гэдэгт найдсан хэрэг биз ээ. Дайсны цэргүүд хотоор хоромхон зуур дайран гарсан учир II Хенрик ван тулалдаанд өөрийн биеэр оролцохоос өөр аргагүй байдалд орсон байна. Польшийн цэргүүдийн талд загалмайтнуудын цэрэг эрс орж тулалджээ. Эцэстээ дөрөвдүгээр сарын 9-ний өдөр Легницийн зэргэлдээ газар тулалдаан өрнөжээ. Эхэн үед тулалдаан тэнцвэртэй явагдаж, талуудын аль нь ч давамгайлах боломжгүй байв. Польшийн цэргүүд рүү Монголын нум сумт баатар эрсийн дайрсан довтолгоо тэдний эгнээ цэргүүдийн дунд ихээхэн будлиан дэгдээж Мешко Кажимежовичийн удирдсан салаа цэргийн нэг хэсэг баруун жигүүрийг хаалтгүй орхин ухран зугтсан байна. Энэ нь эцсийн үр дүнд польшуудыг ялагдалд хүргэжээ. Польшийн баатарлаг цэрэг эрс хэдий амь биеэ золиослон эрэлхэгээр тулалдсан боловч Монголын цэрэг эрс тэдний салаа, нэгжүүдийг бут цохисон юм. Уг тулалдаанд II Хенрик ван амь үрэгджээ[97].

Ялалт байгуулсныхаа дараагаар монголчууд Легниц хот руу довтолсон байна. Ялагдана гэдгээ мэдэрч байсан хэдий ч хотынхон бууж өгөлгүй, ойролцоо хот суурин газрууд сүйтгэгдсэнийг хараад улам бүр сэтгэл шулуудан зориг зүрхжиж байв. Үүнийг ажигласан Орд уг хотыг эзлэн түрэмгийлэх бодлоо хойш тавьж өмнөд зүгт орших Унгарыг чиглэн оджээ. Монголын цэрэг эрсийн аяллын зорилго биеллээ олсон юм. Легницийн дэргэд бут цохиулсан польшууд унгарчуудад тусламж үзүүлэх боломжгүй болов.

Монголын гол цэргийн хүчинтэй Моравиар асар хурдан дайран өнгөрч нэгдэх гэсэн нь Чехид

үймээн сандаргаант байдал төрүүлж, Вацлав ван халдаж болзошгүй эзлэн түрэмгийллээс өөрийн биеэр улсаа хамгаалахаар шийджээ. Эцэстээ Ордын цэрэг эрс Унгарыг үнсэн товорго болтол нь сүйтгэн хоосруулжээ. Легницийн ойролцоо хүлээсэн ялагдал Польшийн хүчийг сулруулсан боловч вант улсууд хоорондоо харилцан ойлголцож, хамтран ажиллахад хүргэсэнгүй. Монголчуудын 1259-1260 он, 1287-1288 оны хооронд Польшид дайран довтолсон өөр хоёр ч тулааныг дурдах хэрэгтэй. Эдгээр нь гэвч үүнээс харьцангуй бага хүрээг хамарсан төдийгүй, олзлон дээрэмдэхэд чиглэгдэж байжээ.

Монколицийн товч түүх

Монколицэ хэмээх хөдөө газар Лодзь, Ленчица, Лович гэсэн гурван хилийн дунд Польшийн төв хэсэгт байрладаг. Өнөөгийн байдлаар түүний ойролцоо газар (10 километр) зүүн талаар нь Гловно хэмээх хотхон, харин хойд талаар нь Пёнтэк хэмээх суурин газар байрладаг. Монколицийн байрлалын талаарх нарийвчилсан зураглал 1885 оны «Польшийн Вант Улс болон Славын бусад орнуудын газар зүйн толь бичиг» номонд байдаг билээ. Уг номноос Монколицийн байрлалын тухайд: Монколицэ тосгон болон Вола Монкольска тосгон нь Лович хошууны Лубянкув багт Гловнагаас баруунтаа 7 мод газар, харин Ловичоос 33 бээрийн цаана оршдог хэмээснийг үзэж болно[98].

Монколицийн түүх нь Дэнбногийн архиепископ (тэргүүн хамба лам) Винцент Кот өөрийн өмнөх архиепископ Войчех Ястшенбецийн эхлүүлсэн сүмийн харьяа нутгийн шинээр байгуулалтыг гүйцээн бяцхан модон сүмийг санваартан лам гэгээн Войчехийн сүм хэмээн нэрлэж аравнайсан үеэс буюу 1444 оны тэртээгээс эхлэлтэй бөлгөө. Дээрх эх сурвалжийг архиепископ Ян Ласкигийн «Liber Beneficiorum» хэмээх тэртээ XV зуунд бичигдсэн мөнхийн бүтээлээс мэдэх билээ. Энэ бүтээлд Сүмийн холбоо архиепископын эрдэнэсийн сан хөмрөгт оруулах гэж байсан Гнезногийн газар нутагт сүмийн шинэ харьяа нутаг бүтээн байгуулах болон сүмийн тохижилттой холбоо бүхий нэн эртний баримт бичгүүд байдаг ажгуу.

Монколицэд сүмийн харьяа нутаг бий болсон хувь зохиол нь Войчех Ястшенбец, Винцент Кот болон хамгийн анх уг хөдөө тосгоны тухай эх сурвалж болсон мэдээг үе хойчид уламжилж үлдээсэн Ян Ласки хэмээх гурван архиепископын ажил үйлс, хичээл зүтгэлтэй холбоотой билээ. архиепископ Войчех Ястшенбецийн шийдвэрээр Монколицэд шинэ сүм баригдсан ба тэрбээр Лович, Ленчицагийн нутаг дэвсгэрт их гавьяа байгуулсан билээ. 1242 оны долоодугаар сарын 9-ний өдрөөс 1436 оны есдүгээр сарын 2-ны өдрийг хүртэлх 13 жилийн туршид Гнезногийн үнэн алдартны шашны ширээт ламын их цол гуншинг зүүх хугацаандаа Ленчицагийн мужид үнэн алдартны шашны хэд хэдэн хурал зөвлөгөөнийг зохион хуралдуулсан билээ. Тэрээр сүмийн харьяаны нутаг дэвсгэрт бүгдэд нь айлчилж, архиепископ нарын эд хөрөнгө, санхүүг цэгцэлжээ. Шинээр сүмийн харьяа газруудыг байгуулж шинэ сүм дугануудыг босгосон байна[99]. Харамсалтай нь Монколицэ дахь сүм байгуулах ажлаа дуусгаж чадаагүй бөлгөө.

Түүний залгамжлагч Дэнбнагаас гаралтай Винцент Кот уг зорилт ажлыг нь үргэлжлүүлэн явуулсан байна. 1437-1448 онд архиепископын хувьд төрийн эрх барих хугацаандаа сүмийн харьяат нутаг дэвсгэр болон түүний удирдлагад шашны үйл ажиллагаа, ном номлох үйлсэд хичээнгүйлэн зүтгэж, Польш дахь сүмийн сайн сайхан байдлын төлөө биеэ хайрлалгүй хөдөрмөрлөж байжээ.

Польш улсын түүхэн бэрхшээлт хүнд хэцүү цаг үе нь II Владислав Варнэньчыкийн дараа улсын хаант ширээг хэн эзлэх талаар гарсан маргааныг зогсоож, улс төрийн гол үүрэг гүйцэтгэхэд хүргэсэн байна[100]. Чухамхүү тэр л өөрийн өмнөх хүний хийж байсан үйлс бүтээлийг дуусгаж, 1444 онд Монколицэ дэх сүмийг аравнайлсан бөлгөө. Агуу их архиепископ Ян Ласки (1456-1531) нь зөвхөн сүмийн төдийгүй, мөн нийт Польшийн төлөө үйлсэд чухал үүрэг гүйцэтгэсэн хүн билээ. 1510 оны дөрөвдүгээр сарын 20-ны өдрөөс 1531 оны тавдугаар сарын 19-ний өдрийг хүртэлх 21 жилийн турш архиепископын өргөө хотод төрийн эрх барихдаа тэрээр өөрийн харьяат иргэдийн сайн сайхны төлөө хүчин зүтгэсэн юм.

Удаа дараалан хийгддэг байсан үй олон шашны хурал зөвлөгөөний үр дүнд сүсэгтэн олонд хандах санваартан нарын хандлага сайжирч, сүмийн эзэмшлийн газар нутаг, эд хөрөнгийн захиран зарцуулалт сайжирч иржээ. Тэрбээр мөн 1513-1515 онд Ромд хуралдсан Латеранийн V Шашны хурал цуглаанд оролцсон байна. 1527 онд шашны хурал цуглааны тухайн үеийг хүртэлх хууль дүрмүүдийг цэгцлэн «Zwod Laskiego» (Ласкигийн хуулийн эмхэтгэл) хэмээх номыг хэвлүүлжээ. Ласки мөн Эзэн хаан I Зигмундын удаах эхнэрүүд хатан хаан Барбара Заполя болон хатан хаан Бона Сфорца нарын зуучаар ажиллаж байв. Түүнийг өөрийнх нь бариулсан гэгээн Станиславын сүмийн орох хаалганы дэргэд Гнезногийн орд газарт хөдөөлүүлжээ[101].

Монколицэ болон Вола Монколицка тосгоны нутаг дэвсгэр, эд хөрөнгийг архиепископ нарын эзэмшлийн газар, орлого нэгтгэн тухайн үед Польш даяар суурьшсан епископын мэдлийн 10 эзэмшил газрын нэг болох Klucz piatkowski (Пёнтковскигийн эзэмшилт газар)-д нийлүүлжээ. Түүний бүрэлдэхүүнд Мощеница голын эрэг дээр байрладаг Пёнтэк хот, Монколицийн суурин газар Монколицэ болон Вола Монколицка тосгодын хамт орж байв[102].

Урьд өмнө нь сайн пиво хийдгээр орон даяар алдаршаад байсан Пёнтэк хот нь Ленчица хошуунд харьяалагддаг байсан бөгөөд XVII зууны үеийн баримт мэдээг сөхөн үзвэл: 230 гаруй суурин газар, 1400 орчим оршин суугчтай байжээ. Пёнтэк 1683 онд түймэрт автсан ч аажим аажмаар урьдын хүчирхэг байдлаа эргэн олж авчээ. Монколицийн суурин газар 1685 онд 118 эзэн, 117 эхнэр, 155 хүү, 139 охин, дор хаяад мөн төдий хэмжээний төрөл садан, зарц шивэгчин, харьяат тариаланчидтай, нийтдээ ойролцоогоор 800 орчим хүн амтай байв. Архиепископт Пёнтковскигийн эзэмшил газрын оршин суугчид жил бүр 7000 злотын алба гувчуур төлдөг байжээ[103].

Монколицийн тухай дэлгэрэнгүй мэдээ баримттай урьд дурдсан Польшийн Вант Гүрний Газар зүйн толь бичгээс «Монколицэ нь хөдөө тосгоны модоор байгуулсан сүм болон анхан шатны сургуультай. 1827 онд эдгээр нь 103 дециметр квадрат талбай бүхий гадаргуутай, 539 оршин суугчтай байсан ба харин Вола Монколицка нь 58 дециметр квадрат талбай бүхий гадаргуутай, 310 оршин суугчтай байв. Дээрх хоёр суурин газар болон Колоня Феликсүв хэмээх тосгоны нийт хүн ам 1210 хүнтэйгээс 120 хүүхэд сургуульд суралцдаг ба 600 орчим нь уншиж чаддаг байв. 1882 онд бараг бүх байшин барилга нь гал түймэрт автаж устжээ. Яг энэ үеэр газрын зарим хэсгийг өөрчилж Александровское хэмээх нэртэй гацаа суурин байгуулсан байна. Уг тосгон дахь тосгоны санваартан Валишевийн эзэмшлийн хоёр тусдаа тариалангийн талбайг ХҮI зууны эхэн үед Waga, Baraon, Sokyt (Жинлүүр, Хонь, Шонхор) хэмээх тариачид

түрээслэн суудаг байсан»[104] хэмээсэнтэй уншиж танилцах боломжтой.

Монколицийн түүх энэ үеэс хойш тодорхой бус хэдий ч Нобелийн шагнал хүртсэн агуу их зохиолч Владислав Станислав Рэймонтын «Тариачид» хэмээх туужийг энд дурдах нь зүйтэй болов уу. Уг туужид XX зууны эхэн үеийн Польшийн хөдөө тосгодын хувь заяаны тухай өгүүлдэг бөгөөд энэ нь Монколицийн оршин суугчдын амьдрал ахуйгаас онц гойд ялгаагүй байсан биш ээ. Өнөө үед Монколицийн сүмийн харьяа нутаг нь Гловнестю захиргааны Ловичийн епархид харьяалагддаг. Тэнд 1444 онд баригдсан Польшийг сахин хамгаалагч епископ, санваартад гэгээн Войчех, Станислав нарын эртний түүх дурсгалт католик шашны сүм байдаг бөлгөө. Энэ нь савх модоор бүрэгдэж, загалмайны зураглал дээр баригдсан модон сүм бөгөөд Matka Boska Laskawa (Өгөөмөр бурхан ээж)-ийн XVII зууны хөрөг зураг бүхий гол гонхон шүтээн, гэгээн Войчех, гэгээн Рох, гэгээн Анна болон Matka Boska Rozancowa (Мөргөлийн Эрхэт бурхан ээж)-ийн хөрөг зурагнууд бүхий хажуугийн гонхонуудтай нийлээд 5 гонхон шүтээнээс бүрддэг болой.

Сүмийн хажууханд модон гонхон байдаг. 1994 онд Пабяницэгээс гаралтай Божэна Новацка хэмээх уран барилгачны төслөөр шинэ сүмийн барилгын ажил эхэлж, 1999 оны тавдугаар сарын 13-ны өдөр Ловичийн Тэргүүн епископ Алойзы Оршулик уг сүмийг Matka Boska Fatimska (Фатимын Бурхан Ээж)-ийн сүмээр өргөмжилж аравнайлсан билээ. Аравнайлагдсаны нэг жилийн ойгоор уг сүмийн нэрийг Санктуариум болгон өргөмжилсөн юм[105]. Монколицийн сүмийн харьяаны нутаг нь 1253 оршин суугчтай, бүрэлдэхүүнд нь: Феликсүв, Монколицэ, Вола Монколицкагийн нутаг дэвсгэр харьяалагддаг.

Жил бүр өнөр даяар тэмдэглэдэг сүмийн баярыг сүмийн харьяаны нутгийг сахин хамгаалагч гэгээн Войчехийн өдөр болох дөрөвдүгээр сарын 23-ны өдөр болон Фатимийн Охин Тэнгэр Гэгээн Мариагийн үзэгдсэн өдөр болох тавдугаар сарын 13-ны өдөр тэмдэглэдэг. Өнөөгийн байдлаар уг сүмийн харьяаны нутгийн католик шашны лам нь сүмийн лам Ян Крышик байгаа.

Монголчууд Монколицэд

Польшийн урт түүхэн хуудаснаа монголчууд мэдэгдэхүйц ул мөрөө үлдээсэн билээ. 1241 оны эзлэн түрэмгийлэл нь Польш улсын нэгдмэл байдалд учраад байсан хямрал гүнзгийрэхэд хүргэжээ. Польшийг дүүргүүдэд хуваан салгасан, эзлэн түрэмгийллийн улмаас газар нутгууд үгүйрэн сүйтгэгдсэн явдал, Шьлонскийн ван II Хенрикийн үхэл нь вант улс эзэмшигчдийн хооронд тоо томшгүй үй олон хэрүүл тэмцэл дэгдэхэд хүргэж, улмаар улсын тогтвортой байдлыг ихээхэн сулруулжээ.

Тэр үед улсаа нэгтгэх хүсэл эрмэлзэл үзэгдэх болж үүнээс 92 жилийн дараа буюу 1320 онд Владислав Локетэк Польшийн хаант ширээнд өргөмжлөгдсөнөөр энэ нь биеллээ олсон билээ. Яг энэ мөчид маш чухал асуудал болох биднийг энэ бүхнийг бичихэд хүргэсэн үндсэн гол оньс болсон «Монголчууд Монколицэд байсан уу? Хэрэв тийм бол хэрхэн, яаж?» хэмээх асуултыг тавих хэрэгтэй бөлгөө. Итгэл төгс батлан хариулах боломжгүй учир үүнд хариулахад маш бэрх юм. Энэ тухай түүхийн ямар ч сурвалжид дурсагдаагүй боловч энэ нь үнэхээр тийм байсан гэсэн таамаглал дэвшүүлэх хэд хэдэн нухацтай үндэслэл бий. Мөн түүнчлэн таамаглалыг томьёолж, өөрсдийн сонирхсон асуултууддаа хариулт авах ч

БОЛОМЖТОЙ ЮМ.

1241 оны монголчуудын эзлэн түрэмгийллэл Монколицэ байрладаг нутаг дэвсгэрийг ч мөн адил хамарчээ. Иймд монголчуудын ул мөрийг уг үйл явдалтай холбож үзэх хэрэгтэй болж таарна. Учир нь түүхийн хуудаснаа Ази гаралтай хүмүүсийг нүүлгэн авч ирж, суурьшуулан амьдруулах болсон тухай ямар ч мэдээ баримт байхгүй бөлгөө. Өмнө бичсэнчлэн алс тэртээ Влоцлавекийн ойр орчимд ч хүрсэн байж болзошгүй монгол явган цэргийн марш хэрхэн, яаж, хаагуур явж өнгөрсөн тухай бид бүхэн тодорхой мэдэхгүй билээ. Замдаа ямар хувь тохиолтой учирсныг ч бид мөн мэдэхгүй. Магад, чухамхүү өнөөгийн Монколицийн ойр хавьд аяллын завсар хоорондоо амарч, алжаалаа тайлахаар түр буудаллан саатсан ч байж болох юм. Цэргүүдийн нэг хэсэг нь ингэхэд дайн байлдаанаас хол хоцорч үлдсэн байж болно. Мөн тэнд газар нутаг, хотоо хамгаалан боссон Польшийн салаа цэргүүдтэй бага сага сөргөлдөөн тэмцэл хийгээд Ордын толгойлсон цэргийн гол хүчинтэй нэгдэхээр аянд мордоход явган цэргийн хурдыг бууруулж байсан учир шархтаж гэмтсэн хэсгийг эдгэрч тэнхрэн эх нутагтаа буцаж харь хэмээн үлдээгээд явсан ба тэдгээр нь тэр газраа үлдэхийг илүүд үзсэн байж ч магад гэсэн таамаглал ортой байж болох талтай.

Гэвч дээрх таамаглалуудыг баттай тогтоож, чухам тийм байсан хэмээн нотлох боломжгүй бөлгөө. Ийнхүү үлдэж хоцорсон хүмүүсийн ул мөрийг тухайн үед тэр нутагт амьдран сууж байсан хүн ам хүлээн зөвшөөрч, түүгээрээ үлдсэн болов уу гэмээр монгол нэр, овгууд гэрчилж чадахсан билээ. Польшийн нутаг дэвсгэр, хилийн дотор үлдэгч уг нутгийн бус явуулын хүн ам нутгийн уугуул иргэдэд түргэн уусч шингэдэг болохыг түүх судлаач нар нотолж байна. Иймд дээрх таамаглалыг баталж чадахуйц, хуучин овгийн нэрийг олох боломжгүй болж байна.

Тухайн үед амьдарч байсан хүмүүсийн нэрийг хайх сүмийн хөтөлсөн бүртгэл нь монголчуудын эзлэн түрэмгийллээс даруй хэдэн зуун жилийн хойно шийдэж эхэлсэн бөгөөд тухайн үед хэрэглэгдэж байсан овог, нэрсийг польш хэллэгт шууд шилжүүлсэн учир үүнийг эрж хайх нь бүр ч төвөгтэй болох ажгуу. Уг газар дээр монголчууд байсны ул мөр тэнд оршин суугч хүмүүсийн нүүрний төрх байдал, биеийн галбираас харагдах шиг санагддаг билээ.

Гэвч алс хэтэд хүн судлаач, хуучны судлалын эрдэмтэд тогтоохоос урьтаж энэ онолыг батлахад хэцүү юм. 1237 онд Монгол руу шашин номлох аянд мордоод тэндээс Киев, Унгараар дамжин ирсэн Франц гаралтай эр Ян ди Пиано Каприни монголчуудын гадна төрхийн тухай дүрслэн бичихдээ: «Монгол орны оршин суугчдын гадна төрх өөр бусад бүх хүмүүсийнхээс ялгаатай. Тэдний нүд, хацар хоорондын зай нь бусдынхаас өргөвтөр, хацар нь мөн эрүүнээсээ харьцангуй хол зайтай байрлагдсан. Шулуун, томгүй хамартай, жижигхэн онигордуу нүдтэй, зовхи нь хөмсөг хүртлээ өргөөстэй. Ерөнхийдөө ганц нэг хүнээс бусад нь бүсэлхий нарийн, бараг бүгдээрээ дунд зэргийн нуруутай. Бараг бүгдээрэнгийнх нь эрүү хавиар сахал тун шингэн ургадаг, зарим нэг нь дээд уруулын дээгүүрх живэр сахал тавих бөгөөд эрүү хавиарх багахан сахал үсээ хусалгүй орхидог. Толгой дээрээ лам нарынхтай төстэй гэзэг ургуулж, эрчүүд бараг бүгдээрээ нэг чихнээс нь нөгөөг хүртэл гурван хуруу газар үсээ хусдаг. Магнайн тус газраар мөн л бүгд үсээ хоёр хуруу орчим газарт хусах ба харин магнайн хоёр талаарх үсийг голынхоос ялимгүй урт ургуулан бусад хэсэгтээ гэзэг тавьж хоёр салаа сүлжин чихнийхээ ард боодог. Хөлийн ул нь харин жижигхэн болой»[106] хэмээсэн

байдаг.

Монколицийн оршин суугчдын өнөөгийн гадна төрхийг зуун хувь батлан хэлэхэд хэцүү хэдий ч зарим нэг ижил төстэй шинж чанарыг ялангуяа ахмад настнуудын дунд ажиглаж болно. Монколицийн унаган оршин суугчдын дунд өөрсдийн Монгол түүхэн гарал үүсэл, үндэс угсаагаа үе удамдаа дамжуулж үлдээдэг заншил тогтжээ. Гэсэн хэдий ч дээр танилцуулсан таамаглалууд нь харамсалтай нь одоогоор шийдвэрлэн тогтоож чадамгүй олон эргэлзээ төрүүлнэм. Түүх гэдэг нь мэдлэг, мөн хариулт олоход бэрхтэй асуултуудын уурхай билээ. Магад ирээдүй хэтдээ бид бүгдээр түүний бүхий л нууцыг, тэр дундаа Монколицийн хүн амын Монгол удмын гарал үүслийн тогтоосон нууцад хүрч таньж мэдэх юун.

[1] Монголын нууц товчоо. Улаанбаатар, 1976, §254.

[2] Монголын нууц товчоо. §255.

[3] Юань улсын судар.

[4] Ч о й с а м б а Ч. Бат хааны байлдан дагуулал. Улаанбаатар, 2003, 39 дэх тал.

[5] С а у н д е р с Ж. Ж. Монголын байлдан дагуулал. Улаанбаатар, 1992, 100 дахь тал.

[6] Монголын түүхийн сурвалж судлал: өнөөгийн байдал, судалгааны асуудлууд. Улаанбаатар, 2004, 30 дахь тал.

[7] Монголын нууц товчоо. §276.

[8] Ч о й с а м б а Ч. Дурд. зох., 102 дахь тал.

[9] Ц о л м о н С. Монголын Алтан ордон улс. Улаанбаатар, 2006, 42 дахь тал.

[10] Р а ш и д а д – Д и н. Судрын чуулган. II боть. Улаанбаатар, 2002, 145 дахь тал.

[11] Р и н ч е н Б. Дундат эртний Монголын тухай хоёр сонин бичиг // «Шинжлэх ухаан, амьдрал» сэтгүүл. 1989, №2, 37 дахь тал.

[12] Монголын Эзэнт улс ба Өрнө дахин. Ред. Сагүчи Тоорү. (Т. Мөнхцэцэгийн орчуулгаар.) Хэйбоншя, 1970, 154 дахь тал.

[13] Мөн тэнд, 379 дахь тал.

[14] П л а н о К а р п и н и Ж. Монголчуудын түүх. Р у б р у к В. Дорно этгээдэд зорчсон минь. Улаанбаатар, 1988.

[15] Ж у в е й н и А. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх (дээд, доод дэвтэр). Хөх хот, 1989.

[16] Г р е к о в В. Д. Золотая Орда и её падение. Москва-Ленинград, 1950. (Дам иш татав.)

- [17] Ц о л м о н С. Дурд. зох., 23-24 дахь тал.
- [18] Л о ч и н С. Алтан ордны хаад // «Хаадын сан». Улаанбаатар, 2000, 34 дэх тал.
- [19] Ц а х и л г а а н Д. Бат хаан // «Хаадын сан». Улаанбаатар, 2003, 243-244 дэх тал.
- [20] В е р н а д с к и й Г. В. Монголы и Русь. Москва-Тверь, 1997, с. 5.
- [21] Т о в у у д о р ж С. Зүчи хаан // «Хаадын сан». Улаанбаатар, 1999, 169 дэх тал.
- [22] С т о л ы п и н А. Москва, Бээжингийн завсар дахь Монгол орон. Улаанбаатар, 2000, 16 дахь тал.
- [23] Мөн тэнд, 17 дахь тал.
- [24] С т о л ы п и н А. Дурд. зох., 116 дахь тал.
- [25] Г а н б а а т а р Я. Их нүүдлийн түүх. Улаанбаатар, 2001, 117 дахь тал.
- [26] Д а р к е в и ч В. И единую чашу смертную испили // Журнал «Наука и жизнь», № 3, 1997, с. 79.
- [27] Богд баатар биеээр дайлсан тэмдэглэл. Хөх хот, 1985, 301 дэх тал.
- [28] Мэн-да бэй лу. Перевод Н.Ц. Мункуева. Москва, 1975, с. 188.
- [29] П л а н о К а р п и н и Ж. Монголчуудын түүх. Р у б р у к В. Дорно этгээдэд зорчсон минь. Улаанбаатар, 1988, 40 дэх тал.
- [30] Мөн тэнд, 39 дэх тал.
- [31] Мөн тэнд, 39 дэх тал.
- [32] Х а р а – Д а в а н Э. Сод жанжин Чингис хаан, түүний үлдээсэн өв. Орчуулагч Ч.Баатар. Улаанбаатар, 2003, 95 дахь тал.
- [33] Б а з а р с ү р э н Ж. Их Монгол улсын цэргийн зэр зэвсэг (XIII зууны эхэн). Доктор (Ph.D.)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар, 2000, 164 дэх тал.
- [34] У о л к е р С. С. Чингиз-хан. Ростов-на-Дону, 1998, с. 44.
- [35] Д' О с с о н. Монголын түүх. II дэвтэр. Хөх хот, 1962, 91 дэх тал.
- [36] Ш а г д а р Х. Гүюг хаан // «Хаадын сан». Улаанбаатар, 2000, 16 дахь тал.
- [37] Ц а х и л г а а н Д. Бат хан // «Хаадын сан». Улаанбаатар, 2005, 14-15 дахь тал.
- [38] А б у л ь - Г а з и - Б а х а т у р - х а н. Родословное древо тюрков. Москва-Тверь. 1996, с.

- [39] Монголын нууц товчоо. Улаанбаатар, 1990, 275 дахь тал.
- [40] Монгол-ун нигуча товчийн. Улаанбаатар, 1990, 207 дахь тал.
- [41] Саундерс Ж. Монголын байлдан дагуулал. Улаанбаатар, 1992, 99 дэх тал.
- [42] Вернадский В. Г. Монголы и Русь. Москва-Тверь, 2001, с. 65.
- [43] Шагдар Х. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх. II боть. Улаанбаатар, 2000, 491 дэх тал.
- [44] Далай Ч. Монголын түүх: Их Монгол улс (1206-1260). Улаанбаатар, 1994, 177 дахь тал.
- [45] Чойсамба Ч. Бат хааны байлдан дагуулал. Улаанбаатар, 2006, 29 дэх тал.
- [46] Пензев К. Русский царь Батый. Москва, 2007, с. 137.
- [47] Там же, с. 133-135.
- [48] Гумилёв Л. Н. Древняя Русь и Великая степь, Москва, 2003, с. 484.
- [49] Ишлэлийг: Каргалов В. В. Монголо-татарское нашествие на Русь на Русь. XIII в. Москва, 1966, с. 111-134.
- [50] Тайны Востока. Авт.-сост. А.Г.Ушаков. Москва, 2004, с. 9-10.
- [51] Носовский Г. В., Фоменко А. Т. Русь и Орда. Москва, 2007, с. 13.
- [52] Там же, с. 112-113.
- [53] Бушков А. Призрак Золотой орды. Москва, 2007, с. 68-69.
- [54] Там же, с. 69.
- [55] Там же, с. 99.
- [56] Там же, с. 124, 126, 133.
- [57] Бушков А. Мираж Великой империи. Москва, 2007, с. 70.
- [58] Носовский Г. В., Фоменко А. Т. Указ. соч., с. 13.
- [59] Данилевский И. Н. Русские земли глазами современников и потомков (XII-XIV вв.). Москва, 2001, с. 339.
- [60] Америкийн түүхч Ж.Ведерфорд Хенрик вангийн цогцсыг эх Ядвига нь олсон гэжээ (We

at herford J. Genghis khan and the Making of the Modern World. Three Rivers Press. N.-Y., 2004, p. 153).

[61] Христианский мир и Великая монгольская империя. Материалы францисканской миссии 1245 г. СПб., 2002, с. 289.

[62] Монголын нууц товчоо. Улаанбаатар, 2005, 100 дахь тал.

[63] Ж у в е й н и А. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. I боть. Улаанбаатар, 2006, 17 дахь тал.

[64] Мөн тэнд.

[65] Мөн тэнд.

[66] Б о р Ж. Монголын дипломат товчоон. Улаанбаатар, 1997, 123 дахь тал.

[67] Ж у в е й н и А. Дурд. зох., 30 дахь тал.

[68] У р а н г у а Ж., Э н х ц э ц э г Д. Монгол хатад. Улаанбаатар, 2000, 69-70 дахь тал.

[69] Монголын нууц товчоо. 121-122 дахь тал, Л у в с а н д а н з а н. Алтан товч. Улаанбаатар, 1990, 101 дэх тал.

[70] Уйгарууд өөрийн захирагчаа тийнхүү нэрлэдэг байв.

[71] Ж у в е й н и А. Дурд. зох., 35 дахь тал.

[72] Монголын нууц товчоо, 121 дэх тал.

[73] Мөн тэнд, 122 дахь тал.

[74] У р а н г у а Ж., Э н х ц э ц э г Д. Дурд. зох., 69-70 дахь тал; Л у в с а н д а н з а н. Дурд. зох., 99 дэх тал.

[75] Алтун беги Барчуктай гэрлэж амжаагүй өөд болсон тул, Өгэдэй хаан Алажин бехийг түүнд хатан болгон богтлон өгсөн тухай Жувейни бичжээ.

[76] Чингис хаан 1208 онд харлагуудад Хубилай жанжинг цэрэглэн илгээсэнд Арслан хан байлдалгүй элсэн иржээ.

[77] Монголын нууц товчоо, 121 дэх тал.

[78] Доктор Н. Ишжамц онгудыг түрэг гаралтай монголжсон аймаг гэж үзсэн байдаг.

[79] Монголын нууц товчоо, 85 дахь тал.

[80] Л у в с а н д а н з а н. Дурд. зох., 98-99 дэх тал.

- [81] У р а н г у а Ж., Э н х ц э ц э г Д. Дурд. зох., 68 дахь тал.
- [82] Монгол-татарын бүрэн тэмдэглэл. Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл. Хайлаар, 1985.
- [83] Э н х ц э ц э г Д. «Монголын нууц товчоо» ба эмэгтэйчүүд. Улаанбаатар, 2008, 64-64, 81 дэх тал.
- [84] Ж у в е й н и А. Дурд. зох., 33 дахь тал.
- [85] B o b r z y n s k i M. Dzieje Polski w zarysie. Warszawa, 1987, s. 137-144.
- [86] R o b e r t s J. M. Historia swiata. Kształtowanie sie roznorodnych cywilizacji. T. IV, Warszawa, 1999, s. 105.
- [87] J a s i e n i c a P. Polska Piastow, Warszawa, 1986, s. 135.
- [88] L e p k o w s k i T. Historia Polski. Warszawa, 1973, s. 216.
- [89] J a s i n s k i T. Dzieje Narodu Polskiego. Przerwany hejnal. Krakow, 1988, s. 45.
- [90] J a s i n s k i T. Dz. cyt., s. 45-46.
- [91] C z a p l i n s k i W. Zarys dziejow Polski do roku 1864. Krakow, 1985, s. 52.
- [92] L e p k o w s k i T. Dz. cyt., s. 217.
- [93] J a s i n s k i T. Dz. cyt., s. 49.
- [94] J a s i n s k i T. Dz. cyt., s. 51.
- [95] J a s i n s k i T. Dz. cyt., s. 55.
- [96] J a s i n s k i T. Dz. cyt., s. 54.
- [97] G a s o w s k i T., R o n i k i e r J., Z b l e w s k i Z. Bitwy polskie, Krakow, 1999, s. 77.
- [98] Słownik Geograficzny Krolestwa Polskiego i innyh krajow slowianskich. Red. F. Sulimierskiego, B. Chlebowskiego, W. Walewskiego. Warszawa, 1885, s. 217.
- [99] P r o k o p K. R. Arcybiskupi Gnieznienscy w tysiacleciu. Krakow, 2000, s. 122-124.
- [100] P r o k o p K. R. Dz. cyt., s. 126-128.
- [101] P r o k o p K. R. Dz. cyt., s. 154-155.
- [102] K o r y t k o w s k i J. Prymasi Polski, Arcybiskupi Gnieznienscy i Metropolici Polsey od Roku 1000, az do dnia dzisiejszego. T. I, Poznan, 2001, s. 143.

[103] K o r y t k o w s k i J. Dz. cyt., s. 143-145.

[104] Słownik Geograficzny Królestwa Polskiego..., s. 217.

[105] Informator Diecezji Łowickiej. Łowicz, 2002, s. 310.

[106] <http://www.gildia.pl/teksty/belphegor/tatarzy>

Table of Contents

[Эрдэм шинжилгээний бага хурлыг нээж, МУИС-ийн НШУС-ийн захирал, доктор, профессор](#)

[Ш.Содномын хэлсэн үг](#)

[Дэлхий дахины болон Монголын түүхэнд Бат ханы гүйцэтгэсэн үүрэг](#)

[Бат ханы цадиг намтрыг гүнзгийрүүлэн судлахад анхаарах зарим асуудал](#)

[Их Монгол улсын цэргийн агсамж \(Кибчагийн аяны жишээн дээр\)](#)

[Төгсгөл](#)

[Гүюг хаан, Бат ханы харилцаа](#)

[Бат хан ба Оросын шинэ түүх бичлэг](#)

[Польш дахь монголчуудын өв](#)

[Чингис хааны төрийн ураг барилдахуй ёсон](#)

[Алс тэртээх Монголоос Монколицэ хүртэл](#)